# ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх | | | | | | |
| 1.1 | Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа | Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх ажлын үзүүлэлтийн өсөлт | -ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хүрээнд авсан үүрэг амлалт 87 хувь<br>-ДХБ-ын Меркатор хөтөлбөрийн хүрээнд хийсэн худалдааг хөнгөвчлөх арга хэмжээний үнэлгээ 57 хувь<br>-НҮБ-ын ХХБХ-ийн Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн хөтөч хэрэгжилтийн үнэлгээ 71.6 хувь | -Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороонд Барааны урьдчилсан шийдвэр (Зүйл 3), Олон улсын стандарт ашиглах (Зүйл 10.3) Хэрэгжилт 90 хувь;<br>-ДХБ-ын Меркатор хөтөлбөрийн хүрээнд хийсэн худалдааг хөнгөвчлөх арга хэмжээний үнэлгээ 75 хувь;<br>-НҮБ-ын ХХБХ-ийн Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн хөтөч хэрэгжилтийн үнэлгээ 80 хувь;<br>Нийт: 37.1 хувь | Нэг.ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр:<br>-Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн Нэгдүгээр хэсгийн 12 зүйлийн хүрээнд тодорхойлсон 36 арга хэмжээ тус бүрээр хэрэгжилтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар гарган гаалийн албан хаагчдын хүртээл болгохын зэрэгцээ Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо, СЯ, ГХЯ-нд хүргүүлж, мэдээллийн ил тод нээлттэй байдлыг ханган ажилласан.<br>-Тайланд тусгасан 2025 онд хэрэгжилтийг хангах үүрэг амлалт авсан “Зүйл 3. Барааны урьдчилсан шийдвэр, Зүйл 10.3 Олон улсын стандарт ашиглах” арга хэмжээний хэрэгжилтийг ГХЯ, ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хороонд хүргүүлж, Монгол Улсын хэлэлцээрийн өмнө хүлээсэн үүрэг амлалтыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.<br>Хоёр. ДГБ-ын “Меркатор” хөтөлбөрийн хүрээнд:<br>-Монголын гаалийн байгууллагын худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагаанд онош зүйн шинжилгээ хийсэн тайланд тусгасан 16 зөвлөмжийн хүрээнд 56 арга хэмжээг төлөвлөсөн дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийн нэгдсэн тайланг гаргасан.<br>-Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн зарим заалтын хэрэгжилтийг Үндэсний хороонд хүргүүлэх тайланд тусган, СЯ, ГХЯ, ЭЗХЯ-нд (2025.06.13-ны 01-2487, 01-2488, 01-2493) хүргүүлсэн.<br>Гурав. “Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн хөтөч”:<br>-НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурал (ХХБХ)-ын Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн хөтөч системд 27 арга хэмжээний хэрэгжилт, бусад мэдээллийг оруулж, Үндэсний хорооны гишүүдийн уялдаа холбоог хангаж, уг системд нэвтрэх чиглэлээр сургалт зохион байгуулж, | 95 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 34 шинэ хэрэглэгчийг уг системд бүртгэн, үйл ажиллагааг идэвхжүүлсэн. https://reformtracker.org/site/dashbord/66e577a1f5f38fcda70e3918?page=Dashboard. Хүрсэн үр дүн: Нийт 5 албан бичиг, 73 цахим захидал солилцон, 21 уулзалт, 3 сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулж, гаалийн байгууллагын цахим хуудас, НҮБ-ын ХХБХ-ын Худалдааг хөнгөвчлөх Шинэчлэлийн хөтөч программд 15 мэдээлэл бэлтгэн, олон нийтийн хүртээл болгон, дараах үр дүнд хүрсэн: -ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн нэгдүгээр хэсгийн 12 зүйлийн хүрээнд тодорхойлсон 36 арга хэмжээний хэрэгжилтийг дэлгэрэнгүй байдлаар ГХЯ-нд хүргүүлж, ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтыг биелүүлэхэд дэмжлэг болж, хэлэлцээрийн хэрэгжилтийг 86.4 хувиас 95.2 хувьд хүргэж, 8.8 хувиар нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. https://www.tfadatabase.org/en/members/mongolia. Дээрх тайланд 2025 онд хэрэгжилтийг хангах үүрэг амлалт хүлээсэн “Зүйл 3. Барааны урьдчилсан шийдвэр, Зүйл 10.3 Олон улсын стандарт ашиглах” арга хэмжээний хэрэгжилт тусгагдсан. -Монгол Улсын Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хэрэгжүүлж буй сайн туршлагыг ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хорооны 2025 оны 06 дугаар сарын 04-05-ны өдөр зохион байгуулсан уулзалтад танилцуулж, Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг олон улсад сурталчилсан үр дүнд хүрсэн. -Худалдааг хөнгөвчлөх 36 арга хэмжээ, бусад асуудлыг дэлгэрэнгүй байдлаар тусгаж, хамтран ажиллаж, хэрэгжилтийн үнэлгээ хийх НҮБ-ын ХХБХ-ын “Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн хөтөч” системд 27 арга хэмжээний хэрэгжилт, бусад мэдээллийг оруулж, Үндэсний хорооны гишүүдийн уялдаа холбоог хангаж, 79 хувийг 4 хувиар нэмэгдүүлж, хэрэгжилтийг 83.02 хувьд хүргэсэн. https://reformtracker.org/site/dashbord/66e577a1f5f38fcda70e3918?page=Dashboard. -Уг системд өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд 78 хэрэглэгч бүртгэгдсэнээс 44 гаалийн байгууллагын хэрэглэгч идэвхтэй ажиллаж, 43 үүрэг даалгаврыг уг программын дагуу бүртгэж, хэрэгжилтийг хانган, худалдааг хөнгөвчлөхтэй холбоотой 11 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээллийг оруулж, олон улсад Монголын туршлагыг түгээсэн үр дүнд хүрсэн. Өнөөдрийн 729 удаа өөрчлөлт хийж, 8,265 удаа уг системд хэрэглэгчид хандалт хийсэн нь Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны үйл ажиллагааг ил тод нээлттэй зохион байгуулахад дэмжлэг болсон.<br>ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилт, Меркатор хөтөлбөрийн дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтээр ДГБ-ын “Худалдааг хөнгөвчлөх хөгжлийн загварын үнэлгээ”-ний матрицын дагуу үнэлэхэд 57 хувийг 23.7 хувиар нэмэгдүүлж, 80.7 хувьд хүрч, “Дийлэнх арга хэмжээг хэрэгжүүлсэн” буюу 3 дугаар түвшинд хүрсэн үр дүнтэй байна.<br><br>1. **100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн.<br>2. **85** хувь “Бүрэн хангалттай” гэж үнэлсэн.<br>3. **100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн.<br>Дундаж **95** хувь. | |
| 1.2 | Гаалийн хяналтад эрсдэл тооцох ажлын хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа | Гаалийн хяналтын “Ногоон”, “Улбар шар” төлөвт сонгогдож, бүрдүүлэлт хийгдсэн мэдүүлгийн тооны өсөлт | -Татварын ерөнхий газартай улсын төсвийн орлогоос зайлсхийх эрсдэлийг бууруулах, БДШ-д хамруулах аж ахуйн нэгж, иргэнийг сонгох, шалгалтын үр дүнгийн саналаар худалдаа эрхлэгчдийн хууль сахилтыг дээшлүүлсэн.<br>-Эрсдэлийн удирдлагын программд 2024 онд оруулсан шалгуур үзүүлэлтийн тоог өнгөрсөн оны мөн | -Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн дүн шинжилгээ хийж, хугацаа дууссан болон хэрэглээгүй шалгуурыг хасах, сунгах.<br>-Хууль сахилтын түвшингээр бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамрагдах иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг гарган, холбогдох нэгжид хүргүүлж, үр дүнг тооцох.<br>-Татвар болон бусад төрийн байгууллагын хамтарсан эрсдэл тооцож, холбогдох шалгуур үзүүлэлт боловсруулах.<br>-Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй | 1.Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, эрсдэлт орчныг тодорхойлох, судалгаанд суурилсан шийдвэр гаргах, гаалийн байгууллагын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор макро, микро түвшний 62 судалгаа хийж гүйцэтгэсэн.<br>2.Эрсдэлийн удирдлага”-д суурилсан гаалийн хяналтын үр дүн, бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулахаар харьяа гаалийн газар, хороодоос ирүүлсэн “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”, “Шалгалтын үр дүнгийн санал”, “Зөрчилд холбогдсон байдал”, “Эрсдэлийн дүн шинжилгээний үр дүн” зэргийг үндэслэн 2024 онд 302 аж ахуйн нэгжийн, 2025 оны эхний хагас жилд 36 аж ахуйн нэгжийн мэдээллийг Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газарт тус тус хүргүүлсний дагуу Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газраас 71 аж ахуйн нэгжийг бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулсан байна. Дээрх 71 аж ахуйн нэгжийн эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, эрсдэлийн удирдлагын программд оруулсан. Өмнө онд өгсөн аж ахуйн нэгжийн үр дүн дараа ондоо шилжиж орж ирдэг байна. | 96.25 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | үетэй харьцуулахад 105 шалгуураар илүү буюу 15.04 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>-ЗББНДБ-аас ирүүлсэн санал, тус хэлтсээс хийсэн судалгааны үр дүнд үндэслэн тайлант хугацаанд 460 ААН, БТКУС-ийн ангиллын код буюу барааны 305 шалгуур эрсдэлийн мэдээллийн санд давхардсан байдлаар оруулж, баяжилт хийсэн.<br>- 2024 онд нийт 1,109,566 гаалийн бүрдүүлэлт хийгдсэнээс: Нийт дүнгээр: Улбар шар төлөвт 47%, улаан төлөвт 37%, ногоон төлөвт 16% сонгогдсон. Импортын бүрдүүлэлт: Улаан төлөвт 82% нь сонгогдсон нүүр тулсан харилцаа хэт өндөр, хяналт шалгалт энэ хирээр удаан явагдаж байна. Экспортын гаалийн бүрдүүлэлт: Бараанд хийх | холбоотой одоогийн хэрэглэж буй программ хангамжийн талбар тус бүрээр давуу, болон сул талыг гарган, цаашид сайжруулах арга хэмжээний санал гаргах.<br><br>Нийт: 64% | 3.Татварын ерөнхий газартай 4 удаа уулзалт хийж, дараах мэдээллийг хүргүүлж, 518 иргэн, аж ахуйн нэгжийн хууль сахилтыг тодорхойлсон:<br>-Монгол Улсын 2024 оны импортод барааны тоо, нэр төрөл, статистик дүн, татварын дүнгээр хамгийн их хувь эзэлсэн 150 аж ахуйн нэгж, байгууллага, 149 иргэн (2025.01.21, 02-1/1/320);<br>-Хууль бус худалдаатай тэмцэх (2025.03.14, 02-1/1/1033) хүрээнд дотоодын зах зээлд алт, мөнгөн эдлэл худалдаалдаг иргэн;<br>-БНХАУ-ын ГЕГ-аас Итгэмжлэгдсэн Аж Ахуйн Нэгжийн эрх олгосон компанитай гадаад худалдаа эрхэлдэг Монгол талын хүлээн авагч 218 аж ахуйн нэгж.<br>4. “Хяналтын төлөвийн мэдээ, шалгалтын үр дүнгийн санал, гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацаа”-г дашбоардаар гаргах ажлыг хийсэн. Эрсдэлийн удирдлагын программын “Зорчигч онилох модуль” дэд цэсийн зөрчлийн ангиллыг нэмэгдүүлж, хөгжүүлсэн.<br>"Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа болон агаарын тээврийн зорчигчийн дагалдах ачаанд тавих гаалийн хяналтыг ахисан түвшинд хүргэх төсөл”-д хамрагдах хүсэлтийг 2023 онд БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-д хүргүүлж, 2023, 2024 онд ТЭЗҮ-ийн судалгаа хийж, давуу болон сул талыг гаргасан. Эрсдэлийн удирдлагын программд КОЙКА-ийн төслийн баг мөн ТЭЗҮ-ийн судалгаа хийсэн.<br>Хяналтын төлөвийн мэдээ, шалгалтын үр дүнгийн санал, гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааг дашбоардаар гаргах, зорчигч онилох модулийг ДГБ-ын Зөрчлийн мэдээлэл солилцох мэдээллийн сүлжээнд зөрчлийн мэдээлэл оруулдаг ангиллын дагуу хөгжүүлэлт хийх саналыг тус тус боловсруулж, Мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн.<br><br>1. **100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн.<br>2. **85** хувь “Бүрэн хангалттай” гэж үнэлсэн.<br>3. **100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн.<br>4. **100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шалгалтаас чөлөөлсөн хувь хэмжээ 88% болж, өмнөх оны мөн үеэс 4%-иар өссөн байна.<br>APIS программыг тасалдахгүй авах чиглэлээр ЗМТ-тэй хамтран ажиллаж байна. | | Дундаж **96.25** хувь. | |
| 1.3 | Гаалийн хилээр гаргах барааны бичиг баримтын бүрдүүлэлтийг Бүрдүүлэлтийн цахим төвд үе шаттайгаар төвлөрүүлэх. | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | Бүрдүүлэлтийн цахим төвд гаалийн газар, хороодын хяналтад байгаа хилээр оруулах барааны бичиг баримтын бүрдүүлэлтийг хийж байна. | -УХШИГГ, ЧХОУНБГГ-т хийгдэж байгаа экспортын барааны бичиг баримтын бүрдүүлэлтийг БЦТ-д төвлөрүүлнэ.<br>-Бусад гаалийн газар, хороодод хийгдэж байгаа экспортын барааны бичиг баримтын бүрдүүлэлтийг БЦТ-д төвлөрүүлнэ. | Гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацаа, зардлыг бууруулж, үйл ажиллагааг хялбарчлах, уялдуулах замаар худалдааг хөнгөвчлөх, гаалийн үйл ажиллагааг цахимжуулж, хилийн гаалийн байгууллагын ажлын ачааллыг бууруулах, гаалийн байгууллагын хэмжээнд хийгдэж буй бичиг баримтын шалгалтыг нэг цэгт төвлөрүүлэх зорилгоор Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, Увс аймаг дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газруудын экспортын барааны бичиг баримтын шалгалтын ачааллыг судлахад 759 бүрдүүлэлтийн 401 бүрдүүлэлт нь гаалийн хилээр бүрмөсөн гаргах 100 горимоор хийгдсэн байсан. ГЕГ-ын дэргэдэх Бүрдүүлэлтийн цахим төвд харьяа 5 гаалийн газар, 2 хороонд хийгдэж буй экспортын барааны бүрдүүлэлтийг горим харгалзахгүйгээр төвлөрүүлбэл сард 401 мэдүүлэг буюу 1 өдөрт ойролцоогоор 13 мэдүүлэгт бичиг баримтын шалгалт хийх ажил нэмэгдэх тооцоолол гарсан нь тус төвийн ажлын ачаалалд төдийлөн их нөлөөлөхгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн. Иймд Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, Увс аймаг дахь гаалийн газар, Хөвсгөл аймгийн Ханх дахь гаалийн хороо, Завхан аймгийн Арцсуурь дахь гаалийн хороонд хийж буй экспортын барааны бичиг баримтын шалгалтыг 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн горим харгалзахгүйгээр Бүрдүүлэлтийн цахим төвд төвлөрүүлэх шийдвэрийг гаргаж, программын хөгжүүлэлтийг хийж, CAIS системд бүрэн нэвтрүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тайлант хугацаанд 6,051 гаалийн мэдүүлгээр, 24428 бараанд экспортын барааны бүрдүүлэлтийн бичиг баримтын шалгалтыг хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад статистик дүн 156 сая ам.доллараар их буюу 45.81 хувь, бүрдүүлэлтийн тоо 3,375 буюу 126.12 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.<br><br>1. **100** хувь "Бүрэн хангалттай" зорилтот түвшиндээ хүрсэн.<br>2. **100** хувь "Бүрэн хангалттай" зорилтот түвшиндээ хүрсэн.<br><br>Дундаж **100** хувь. | |
| 1.4 | Татварын албанаас CAIS-т ирүүлсэн мэдээллийг үндэслэн гадаад жуулчны бараанд тавих хяналтыг сайжруулах | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | CAIS-ийн Гадаад жуулчны эрсдэлтэй барааны мэдээлэл хэсэгт шаардлагатай мэдээлэл байхгүй учраас СМТТ УТҮГ-аас тодруулж асуудаг. | СМТТ УТҮГ-аас бүртгүүлсэн хэрэглэгчдийн тоон мэдээлэл, борлуулагч байгууллагын тоо, буцаан олголт авсан гадаад жуулчдын тоон мэдээллийг CAIS-т хүлээн авах хөгжүүлэлт хийлгэж, хяналтыг сайжруулна. | 1.Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 445 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Гадаадын жуулчны хувийн хэрэгцээнд зориулж худалдан авсан бараанд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын төлбөрийн баримтыг бүртгэх, түүнд хяналт тавих журам"-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Дээрх журамд заасны дагуу Гаалийн байгууллага нь гадаадын жуулчны худалдан авалтад төлсөн албан татварыг буцаан олгох харилцаанд оролцохдоо энэ журмын 2.3.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд буцаан олголтын хүсэлтийг хянан, баталгаажуулахаар, 2.4.1-д заасны дагуу хянан, баталгаажуулсан талаарх мэдээллийг гаалийн системээр дамжуулан татварын нэгдсэн системд тухай бүр мэдэгдэх чиг үүрэгтэй оролцох зохицуулалттай. Мөн дээрх журмын 3.8-д гаалийн улсын байцаагч нь энэ журмын 3.7-д заасан эрсдэлтэй нөхцөл үүсэж, гадаадын жуулчны ачаа, тээшинд тулган баталгаажуулалт хийж, гадаадын жуулчны гаргасан хүсэлт хууль тогтоомжид нийцээгүй нь баталгаажсан тохиолдолд худалдан авалтад төлсөн албан татварыг буцаан олгохгүй бөгөөд энэ талаар гадаадын жуулчинд мэдэгдэж, тухайн барааны буцаан олголтыг цуцлах мэдээллийг цахимаар нэгдсэн санд илгээнэ гэж заасан. 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар гаалийн байгууллагын автоматжуулсан CAIS-ийн Зорчигч онилох модуль, Гадаад жуулчны эрсдэлтэй барааны мэдээлэл хэсэгт ирүүлсэн мэдээлэл байхгүй.<br>Мөн цахим төлбөрийн баримтын системд бүртгүүлсэн гадаадын жуулчны тоон мэдээлэл, бүртгүүлсэн | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баримтын тоо, үүнээс буцаан олголт авсан гадаадын жуулчны тоон мэдээллийг гаалийн байгууллагын автоматжуулсан CAIS-т хүлээн авах боломжийг бүрдүүлж, программын хөгжүүлэлт хийлгэх хүсэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 02-1/500 албан бичгээр СМТТ УТҮГ-т хүргүүлсэн. Дээрх ажлын хүрээнд эрсдэлтэй гадаадын жуулчны барааг шалгах цэгийг тогтоолгохоор Чингис хаан олон улсын нисэх буудалд гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа эрхэлж буй “НУБИЭ” ХХК-тай хамтран ажиллаж байна.<br>2.“Гааль, татварын байгууллагын цахимжилт түүний үр нөлөө ба иргэн, хуулийн этгээдийн цахим системтэй холбоотой санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр СЯ, АТГ, ТЕГ, СМТТ УТҮГ-тай хамтран зохион байгуулах хөтөлбөр батлагдсан. Дээрх хэлэлцүүлгээр “Гадаадын жуулчны хувийн хэрэгцээнд зориулж худалдан авсан бараанд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын төлбөрийн баримтыг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг хангаж, гаалийн байгууллагын автоматжуулсан CAIS-д шаардлагатай мэдээллийг ирүүлэх асуудлыг танилцуулна.<br><br>**30** хувь “Хангалтгүй” удирдлага, зохион байгуулалт хангалтгүй. | |
| 1.5 | Тээврийн хэрэгслийг рентгенээр шалгасан дүрс зургийг ОХУ-ын ХГА-тай солилцох шинэ нөхцөл, боломжийг судлах. | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | Уфа хотноо 2015.07.09-ний өдөр байгуулсан ”Гаалийн хяналтын үр дүнг сайжруулах зорилгоор рентген тоног төхөөрөмж ашиглан авсан мэдээллийг солилцох тухай Монгол Улсын ГЕГ, ОХУ-ын ХГА хоорондын хэлэлцээр”-ийг рентгены дүрс зургийг солилцох | Алтанбулаг, Хиагт боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийг рентгенээр шалгасан дүрс зургийг ОХУ-ын ХГА-тай солилцох шинэ нөхцөл, боломж, аргыг судалж, ОХУ-ын ХГА-д санал хүргүүлнэ. | ОХУ-ын ХГА-ны Монгол дахь төлөөлөгч Чагдуров Алексей Викторовичтэй 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Гаалийн ерөнхий газрын Хяналт бүрдүүлэлтийн газар, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс, Мэдээллийн технологийн газрын албан хаагч нар уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар:<br>-Талуудын экспортын гаалийн мэдүүлэг болон цахим манифест солилцохтой холбоотой асуудлаар;<br>-Алтанбулаг, Хиагт боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийг рентгенээр шалгасан дүрс зургийг ОХУ-ын ХГА-тай солилцох асуудлаар санал солилцсон.<br>2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 16:00 цагаас ОХУ-ын ХГА-ны төлөөлөгч нартай цахим уулзалт зохион байгуулж, талуудын экспортын гаалийн мэдүүлэг болон цахим манифест солилцохтой холбоотой асуудлыг үргэлжлүүлэх ажлын талаар хэлэлцсэн. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шинэ нөхцөл, боломж, арга барилыг зөвшилцөн тохиролцох хүртэл хугацаанд түр зогсоохоор талууд 2021.12.16-ны өдөр Москва хотноо болсон ОХУ-ын ХГА-ны дарга В.И.Булавин, Монгол Улсын ГЕГ-ын дарга Б.Асралт нарын уулзалтаар тохирч Протоколын 3-д тусгасан. | | Рентгенээр шалгасан дүрс зургийг ОХУ-ын ХГА-тай солилцох асуудлыг 2025 оны 9 дүгээр сард зохион байгуулагдах Гаалийн ерөнхий газрын Хяналт, бүрдүүлэлтийн газар болон ОХУ-ын ХГА-ны Сибирийн гаалийн газар, Алс дорнодын гаалийн газар хоорондын хилийн холбоо баригч дарга нарын уулзалтаар хэлэлцэхээр ажиллаж байна.<br>Дээрх ажлын хүрээнд Гаалийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн газраас гаалийн байгууллагад хяналтын зорилгоор ашиглаж байгаа рентгений дата мэдээллийг хадгалах, боловсруулалт хийх зориулалттай сервер тоног төхөөрөмжийн судалгааг хийж, санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.<br><br>**30** хувь “Хангалтгүй” удирдлага, зохион байгуулалт хангалтгүй. | |
| 1.6 | Гадаад худалдаа эрхлэгчид барааны ангиллын кодын талаар мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | БТКУС-д үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт болон БТКУС-ийн Тайлбар бичгийн тайлбарыг Гаалийн цахим үйлчилгээний системээс авах боломж бүрдсэн. | Гадаад худалдаа эрхлэгчид барааны ангиллын кодын талаарх мэдээллийг цахимаар авах боломжийг бүрдүүлсэн байна. | -Гаалийн албан татвараас чөлөөлөгдөх спортын зориулалтын тоног төхөөрөмж, хэрэглэл нийт 602, эрчим хүчний төслийн татвар төлөх хугацааг сунган импортлох 1603, нийт 2205 нэр төрлийн барааны ангиллын кодыг тодорхойлж, хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж ажилласан.<br>-ДГБ-ын УСХ-оос гаргасан нийт 55 барааны ангиллын шийдвэрийг англи хэлнээс монгол хэлнээ орчуулан CAIS-д оруулснаар барааны ангиллын нэг мөр шийдвэр гарган хэрэгжүүлэхэд гаалийн алба хаагчдад дөхөм болсон.<br>-Платформын туршилтаар зарим барааны ангиллын код тодорхойлох магадлалын хувь буруу байгааг илрүүлэн дахин сайжруулах, мөн эхний ээлжид хэрэгжих улсын чанартай 6 мега төслийн хүрээнд импортолсон 4850 барааны мэдээллийн сан үүсгэн платформыг сайжруулах чиглэлээр ажиллаж байна.<br>-БТКУС-ийн конвенц, тайлбар дүрэм, хавсралт жагсаалтын 2022 оны хувилбарыг “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн тусгай дугаарт хэвлэн нийтлүүлэх зорилгоор 465 нүүр хэвлэлийн эхийг бэлтгэн, СЯ, ГХЯ, УИХ-ын тамгын газарт холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. | 85 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах 4 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт, 2 аж ахуйн нэгж, байгууллагын ангиллын кодын тайлбар, тодруулга авах хүсэлт, 2 газар, хороо, 3 зохион байгуулалтын бүтцийн нэгжээс ирүүлсэн, нийт 31 барааны ангиллын кодын талаарх хүсэлтийг шийдвэрлэж, зөвлөгөө өгч ажилласан.<br>-ДГБ-аас 05 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд зохион байгуулсан “Уялдуулсан систем болон ангиллын урьдчилсан шийдвэр” сэдэвт үндэсний хэмжээний сургалтыг амжилттай зохион байгуулж нийт 30 алба хаагчдад 11 хичээлийн 512 слайдыг орчуулан сургалтын материалыг англи монгол хэлнээ орчуулан хүргүүлж мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн.<br>Дээрх арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд "Гааль зөвшөөрөв” төлөвөөс барааны ангилалтай холбоотой буцааж засварласан бичлэгийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 хувиар буурсан байна.<br><br>**85** хувь "бүрэн хангалттай". | |
| 1.7 | Зарим барааны гаалийн үнийн хяналтыг цахимжуулах ажлыг өргөжүүлнэ. | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | ГЕГ-ын даргын А/533 тоот тушаалаар “Автомашины гаалийн үнийг системээс автоматаар шалгах түр заавар”-ыг батлуулж, Япон улсаас импортолж буй Toyota, Prius маркийн суудлын автомашиныг системээс шалгах программыг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн туршилтын журмаар нэвтрүүлсэн. Мэргэжлийн | 1.Үнийн хяналтыг цахимжуулах боломжтой барааны судалгааг хийсэн байна.<br>2. Цахимжуулах барааны бичиглэлийг ижилсгэх, гаалийн бүрдүүлэлтийн программд лавлах сан үүсгэсэн байна.<br>3. Шалгуур мэдээллийг гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан системд оруулж, барааны гаалийн үнийг системээс автоматаар хянасан байна. | Үнийн хяналтыг цахимжуулах боломжтой барааны судалгааг хийж, экспортын төмрийн хүдэр болон баяжмал, зэсийн хүдэр болон баяжмалыг биржийн гэрээтэй тохиолдолд системээс автоматаар шалгаж, баталгаажуулах программын даалгаврыг боловсруулж, Мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн. Программын хөгжүүлэлтийг хийж эхлээгүй байна.<br>Бүрдүүлэлтийн цахим төвөөс БНХАУ-аас импортолж буй чирэгч, чиргүүл, өөрөө буулгагч, АНУ болон БНСУ-аас импортолж буй ачааны болон суудлын автомашины нийт 506 үнийн мэдээллийг хүлээн авч, хянан ижилсүүлсэн. Ингэснээр мэдээллийг CAIS системийн 7 үнийн судалгааны хавтсанд баталгаажуулан, лавлах сан үүсгэсэн ба үнийн хяналтын зорилгоор ашилгах бүрэн боломжтой болсон.<br>Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/739 дүгээр тушаалаар “Зарим нэр төрлийн барааны гаалийн үнийг системээс шалгах заавар”-ыг батлуулсан. Тус зааврын дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Aqua, Sai маркийн автомашин, 2025 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн Alphard, Velfire, Lexus LX250 маркийн автомашинууд дээр холбогдох судалгаа хийж, CAIS | 96 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зөвлөлийн хуралдааны 09/06 дугаартай шийдвэрээр “Зарим нэр төрлийн барааны гаалийн үнийг системээс шалгах заавар”-ыг батлуулах шийдвэр гарсан. | | системд шалгуурыг оруулан, үнийн хяналтыг цахимжуулсан. Ингэснээр нийт 6 маркийн автомашиныг системээс автоматаар хянаж, 2025 оны 06 сарын 10-ны өдрийн байдлаар Япон улсаас импортолсон 53,046 автомашины 6056 автомашин буюу 11.4%-ийг системээс хянаж баталгаажуулсан байна. Автомашины гаалийн үнийг системээс шалгаж, баталгаажуулах программыг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн “Журамд нэмэлт оруулах тухай” А/17, А/18 дугаар тушаалуудыг батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд хүргүүлж, бүртгүүлсэн.<br>Гаалийн үнэнд хяналт дүн шинжилгээ хийх зорилгоор Tablue программд автомашины үнэлгээний мэдээлэл хянах дашбоард, давхар нэхэмжлэх хянах дашбоардын хөгжүүлэлт хийж нэвтрүүлсэн нь өдөр тутмын хяналт тавих, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлсэн.<br><br>1. **90** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн.<br>2. **100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн.<br>3. **100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн.<br><br>Дундаж **96** хувь. | |
| 1.8 | Гаалийн үнийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг цахимжуулна. | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | Гаалийн үнийн мэдээллийн санд жилд дунджаар 250,000 барааны үнийн мэдээллээр баяжуулдаг бөгөөд мэдүүлгийн бүх хүснэгт дэх мэдээлэл болон дагалдах бичиг баримт зэргийг хүний оролцоотойгоор нэг бүрчлэн хянаж, баталгаажуулдаг | 1.Программын бодлогын даалгавар боловсруулна.<br>2.Гаалийн бүрдүүлэлтийн программд шалгуур мэдээллийг оруулна.<br>3.Холбогдох эрх зүйн актад нэмэлт өөрчлөлт оруулна.<br>4.Системээс автоматаар урьдчилан оруулсан шалгуур үзүүлэлтийг харьцуулан хянаж, зарим барааны үнийн | Зарим барааны гаалийн үнийн мэдээллийг автоматаар “Баталгаажсан үнийн сан”-д оруулах программыг нэвтрүүлсэн. Баталгаажсан үнийн санд 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 5941 автомашины үнийн мэдээлэл, ангиллын хэмжих нэгж кг-аар илэрхийлэгдэх 2156 бичлэг автоматаар баталгаажсан байна. Энэ нь 2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар баталгаажсан үнийн санд орсон нийт бичлэгийн 9.25 хувийг эзэлж байгаа бөгөөд 1 гаалийн улсын байцаагчийн өдөрт баталгаажуулах ёстой бичлэгийн 35 хувийг хөнгөвчилж байна.<br>Үнийн мэдээллийн санг бүрдүүлж, хил орчмын болон төрөлжсөн үнийн судалгааг хянаж баталгаажуулан, гаалийн үнийн хяналтыг хэрэгжүүлсний үр дүнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 160.7 тэрбум төгрөгийн татварыг гаалийн бүрдүүлэлтийн үед улсын | 75 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээллийг автоматаар “Баталгаажсан үнийн сан”-д оруулах боломжийг бүрдүүлнэ. | төсөвт нэмж төвлөрүүлээд байна. Үүнээс 50.6 тэрбум төгрөг буюу 31.6 хувийг үнийн мэдээллийн санд үндэслэн гаалийн үнийг тодорхойлж гаалийн болон бусад албан татварыг нэмж төвлөрүүлсэн байна.<br><br>1. **100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн.<br>2. **100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн.<br>3. **0** хувь "хангалтгүй".**75** “хангалттай” шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй.<br>4. **100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн.<br><br>Дундаж **75** хувь. | |
| 1.9 | Цахим худалдаанд тавих гаалийн хяналт шалгалтыг хялбарчлах зорилгоор цахим мэдээлэл солилцох технологи ажиллагааг нэвтрүүлнэ. | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | Upost системийг цаашид ашиглах боломжгүй нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор шуудангийн тусгай зөвшөөрөлтэй Аж ахуйн нэгжүүдээс өөрийн ашиглаж буй мэдээллийн системийг Гаалийн байгууллагын мэдээллийн системтэй шууд холбох технологийн шийдлийг гаргаж өгөхийг илэрхийлсэн. Тус хүсэлтийн дагуу агаарын болон газрын шуудан илгээмжийн задаргааны мэдээллийг гаалийн байгууллагын мэдээллийн | Шуудан илгээмжээр илгээгдэж буй цахим худалдааны импортын барааны эргэлтэд хяналт тавих | Улс хоорондын шуудан илгээмжийн хяналтыг сайжруулах зорилгоор илгээмжийн мэдээллийг хүлээн авах гаалийн байгууллагын нээлттэй сервисийг 2024 оны 10 дугаар сараас шинээр гаргаж, нэвтрүүлсэн. 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар ХХЗХ-оос олгосон шуудангийн тусгай зөвшөөрөлтэй 35 аж ахуйн нэгжийн ашиглаж буй мэдээллийн системийг тус аж, ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу гаалийн байгууллагын мэдээллийн системтэй холбосон.<br>Үүний үр дүнд улс хоорондын шуудан илгээмжийг рентгенээр шалгахаас өмнө илгээмжийн мэдээллийг урьдчилан авч “YES”, “NO” төлөвт оруулах үйлдлийг хийхдээ дагалдах бичиг баримтуудтай нэг бүрчлэн тулгаж, цаг алдахгүй, шалгалтын хугацааг бууруулах ач холбогдолтой.<br>Улс хоорондын шуудан илгээмжээр илгээгдэж байгаа цахим худалдааны барааны хяналт, цахимаар солилцож буй мэдээллийг сайжруулах чиглэлээр ХХЗХ-оос олгосон шуудангийн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж байна.<br>Мөн Гаалийн ерөнхий газраас ОУВС-ийн багтай 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр хийх уулзалтын хэлэлцэх асуудалд цахим худалдааны барааны хяналттай холбоотой асуудлыг тусгуулан, санал солилцохоор ажиллаж байна.<br>Хил дамнасан цахим худалдааны бараа улс хоорондын шуудангийн илгээмжээр илгээж байгаа илгээмжийн нэгэн адил ХХЗХ-оос олгосон шуудангийн илгээмжийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | системд цахимаар илгээх буюу ААН-ийн мэдээллийн системээс гаргах сервес хөгжүүлсэн. | | үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр дамжиж улсын хилээр нэвтэрдэг.<br>Иймд Монгол Улсад хүлээн авагчтай БНХАУ-ын TEMU цахим дэлгүүрээс захиалсан барааны тээвэрлэлт 2024 оны 11 дүгээр сараас эхэлсэнтэй холбогдуулан нийт 107 удаагийн тээвэрлэлтээр улсын хилээр оруулсан 350000 гаруй хүлээн авагчийн 49 сая орчим юанийн үнийн дүнтэй бараанд гаалийн байгууллага хяналт тавьж ажилласан мэдээлэлд үндэслэн хил дамнасан цахим худалдааны хяналтыг сайжруулж, шалгалтад зарцуулах хугацааг бууруулах, цахим худалдааны барааг хүлээн авагч нарт нь хугацаа алдалгүй хүргэхийн тулд Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийцүүлэн манай улсын ХХЗХ-оос олгосон шуудангийн илгээмжийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр тээвэрлүүлэн, БНХАУ-ын хилийн боомтын тусгай гарцаар нэвтрүүлж, зориулалтын гаалийн хяналтын бүсэд гаалийн хяналтад оруулах боломжийг бүрдүүлэн хамтарч ажиллах хүсэлтийг 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 02/1838 албан бичгээр “Марин нью пост” ХХК-д хүргүүлсэн.<br><br>**100** хувь “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 1.10 | Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тусгай зөвшөөрлийн системд гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох сунгах асуудлыг шийдвэрлэх | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | 1. Шинэчилсэн журмын төслийг МЗХ-аар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн.<br>2. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний өөрийн үнэлгээний хуудсыг цахимаар хянаж ажиллаж байна.<br>3. Тусгай зөвшөөрлийн цахим системд 16 ААН-ийн зөвшөөрлийн хугацааг сунгасан, | 1.Журмыг ХЗЯ-нд хүргүүлж, бүртгэлжүүлнэ.<br>Гаалийн газар, хороод, гаалийн зуучлагч байгууллага, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдэд сурталчлан таниулах сургалтыг зохион байгуулсан байна.<br>2.Тусгай зөвшөөрлийн цахим системд баталгааны хуудас, гаалийн зуучлагчийн үйл ажиллагааны хэрэгжилтийг дүгнэх | Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны А/19 дүгээр тушаалаар “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ыг батлуулж, гаалийн газар, хороод болон Монголын гаалийн зуучлагч мэргэжлийн холбоогоор дамжуулан гаалийн зуучлагч, гаалийн бүрдүүлэлтийн мэргэжилтнүүдэд хүргүүлэн Гаалийн ерөнхий газрын цахим хуудсанд байршуулсан. Журмыг ХЗДХЯ-нд бүртгүүлэхээр 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/365 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 1/646 дугаартай албан бичгээр Захиргааны ерөнхий хуулийн 59.1-д заасны дагуу “... хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр дагаж мөрдөх шинж”-ийг агуулаагүй, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалт, дотоод хяналт, зохицуулалтын шинжтэй байх тул Захиргааны ерөнхий хуулийн 66.3.3-т заасны дагуу | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 18 ААН-д зөвшөөрөл олгож, хугацаандаа сунгалтын хүсэлт ирүүлээгүй 1ААН-ийн 2 ГБМ-ийн эрхийг хааж ажилласан. | хуудсыг тусгаж, цахимжуулна.<br>3.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах асуудлыг тусгай зөвшөөрлийн цахим системд шийдвэрлэсэн байна. | улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх шаардлагагүй гэж хариу ирүүлсэн.<br>Журам батлагдсантай холбогдуулан 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Гаалийн ерөнхий газрын Бүрдүүлэлтийн цахим төв, харьяа гаалийн 8 газруудтай онлайн хурлаар дараах агуулгын хүрээнд чиглэл, зөвлөмж хүргүүлж ажилласан. Үүнд:<br>- Журмын танилцуулга,<br>- Гаалийн зуучлагч байгууллага, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнд хяналт тавьж ажиллах талаар,<br>- Журмын зүйл, заалт дахь агуулгыг нэг мөр ойлгох талаар.<br>Тайлант хугацаанд гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны 3, давтан 3 сургалтад нийт 356 мэргэжилтэн хамрагдаж, журмын хэрэгжилтийн талаар сургалт зохион байгуулсан.<br>Тусгай зөвшөөрлийн цахим системд нэмэлт хөгжүүлэлт, өөрчлөлт хийх ажлын хүрээнд системийн хөгжүүлэлтүүдийг амжилттай гүйцэтгэж дараах ажлыг хэрэгжүүлж байна. Үүнд:<br>- Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний өөрийн үнэлгээний хуудасны үзүүлэлтийг 18-аас 9 болгож оновчтой болгосон,<br>- Баталгааны хуудас, банкны баталгааг PDF хэлбэрээр хавсаргаж оруулах боломжийг нэмсэн,<br>- Эрсдэлийн сангийн дүнг автоматаар татах боломжийг бүрдүүлсэн.<br>Цаашид зуучлагчийн үйл ажиллагааны хэрэгжилтийг дүгнэх хуудсыг 3, 4 дүгээр улиралд хийхээр төлөвлөн ажиллаж байна.<br>Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах асуудлыг тусгай зөвшөөрлийн цахим системд бүрэн шийдвэрлэсэн. 2025 оны эхний хагас жилийн байдлаар тусгай зөвшөөрлийн цахим системээр дамжуулан 3 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг хянаж, Сангийн сайдын тушаалаар зөвшөөрөл олгож, 2 аж ахуйн нэгжийн шинэ хүсэлт болон 1 аж ахуйн нэгжийн сунгалтын хүсэлтийг шалгаж Сангийн яаманд тус тус хүргүүлсэн.<br><br>1. **100** хувь “Бүрэн хангалттай”.<br>2. **70** хувь буюу "хангалтгүй".<br>3. **100** хувь “Бүрэн хангалттай”. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дундаж **90** хувь. | |
| 1.11 | Гадаад худалдаанд оролцогч аж ахуйн нэгж, байгууллагад эрсдэлийн удирдлагад суурилсан бүрдүүлэлтийн дараах шалгалтыг хийх | Үйл ажиллагаа | Бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулсан аж ахуйн нэгжийн тоо, улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн, төгрөгөөр | 2024 оны эрсдэлийн судалгаа, дүн шинжилгээний үр дүнгээр 102 аж, ахуйн нэгжид бүрдүүлэлтийн дараах шалгалт хийж, 3.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. | 110 аж ахуйн нэгж, байгууллагад бүрдүүлэлтийн дараах шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт өгөн, илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж, улсын төсөвт 4 тэрбум төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна. | 2025 онд нийт 110 аж ахуйн нэгж, байгууллагад бүрдүүлэлтийн дараах шалгалт хийж, улсын төсөвт 4 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс эхний хагас жилд 50 аж ахуйн нэгж, байгууллагад бүрдүүлэлтийн дараах шалгалт хийж, улсын төсөвт 0.8 тэрбум төгрөг, сүүлийн хагас жилд 60 аж ахуйн нэгж, байгууллагад бүрдүүлэлтийн дараах шалгалт хийж, улсын төсөвт 3.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөн ажиллаа.<br>2025 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн байдлаар нийт 86 аж ахуйн нэгж, байгууллагад */2024 оны удирдамжаар 4, 2025 оны удирдамжаар 82/* эрсдэлд суурилсан бүрдүүлэлтийн дараах шалгалт хийснээс 61 аж ахуйн нэгж, байгууллагад хийсэн шалгалт бүрэн дууссан, 25 аж ахуйн нэгж, байгууллагад шалгалт хийгдэж байна. Шалгалтын үр дүнгээр 44 аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох 29.6 тэрбум төгрөгийн зөрчлийг илрүүлж, шалган шийдвэрлэж, 2.0 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн. Үүнд:<br>- 3 аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох 19.5 тэрбум төгрөгийн дүн бүхий зөрчил нь Эрүүгийн хуулийн 18.3 дахь зүйлийн дагуу их хэмжээний татвараас зайлсхийх гэмт хэргийн шинжтэй зөрчил байсан тул Нийслэлийн прокурорын газрын хяналт дор харьяаллын дагуу Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн;<br>- 41 аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох 10.1 тэрбум төгрөгийн дүн бүхий зөрчлийг Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу Захиргааны журмаар шалган шийдвэрлэж, нийт 2.4 тэрбум төгрөгийн нөхөн татвар, торгуулийг оногдуулсан.<br>2025 оны эхний хагас жилд 50 аж ахуйн нэгж, байгууллагад шалгалт хийж, 0.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 61 аж ахуйн нэгж, байгууллагад шалгалт хийж, 2 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн нь шалгалт хийгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо 22 хувиар өссөн, төсөвт төвлөрүүлсэн орлого 150 хувиар биелсэн гүйцэтгэлтэй байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тайлант хугацаанд хийсэн бүрдүүлэлтийн дараах шалгалт болон бүрэн дууссан шалгалтын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад хийсэн шалгалт 34.4 хувиар, дууссан шалгалт 35.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.<br><br>**100** хувь “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 1.12 | Автозамын хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэх | БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн буцалтгүй тусламж,<br><br>АХБ-ны хөнгөлөлттэй зээл, бусад хөрөнгө оруулалт, | Хэрэгжилт, хувиар | -Алтанбулаг боомтын барилга байгууламжийн 2-р ээлжийн барилгын ажлыг гүйцэтгэгчээс тодорхой шалтгааны улмаас 2024.05.12-ны өдрөөс зогсоосон.<br><br>-Бичигт боомтын барилга байгууламж гүйцэтгэл 10%, автозам, инженерийн шугам сүлжээ 25%<br><br>-АХБ-ны BEST төслийн хүрээнд Хавирга боомтыг өргөтгөж шинэчлэхээр төлөвлөгдсөн. ТХАГ-ын даргын тушаалаар | -Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх шийдвэр гарсны дараа барилгын ажил 100%-д хүрч дууcна. Боомтын барилга, байгууламжийн дотоод тохижилт, хаягжилт, тэмдэг, тэмдэглэгээ, тоноглол, гаалийн хяналт шалгалтын зарим тоног төхөөрөмжийг суурилуулж ашиглалтад хүлээж авах ажлыг зохион байгуулсан байна.<br><br>-Бичигт боомтын бүтээн байгуулалтын барилга байгууламжийн ажил 20%, авто зам, гадна инженерийн шугам сүлжээний ажил 40%-д хүрнэ.<br><br>-Хавирга боомтын бүтээн байгуулалтын гүйцэтгэгч болон захиалагчийн хяналтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, барилгын ажлыг эхлүүлнэ. | Алтанбулаг боомтын бүтээн байгуулалт 2025 оны 4 дүгээр сард эхэлсэн. Гаалийн ерөнхий газрын ажлын хэсэг 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр ажлын явцтай танилцаж RIBS төсөл, гүйцэтгэгч “Монкон констракшн” ХХК-тай мэдээлэл солилцон, дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан. Шалган нэвтрүүлэх барилгын ажлын гүйцэтгэл 97%-тай, 2025 оны 6-р сард багтаан дуусгахаар урьдчилан төлөвлөсөн. Алтанбулаг боомтод ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулахаар байршлыг тодорхойлох бэлтгэл ажил хийгдэж байна. Бичигт боомтод Гаалийн ерөнхий газрын ажлын хэсэг ажиллаж барилга, байгууламжийн ажил бүрэн зогссон, гүйцэтгэл жигд бус, газар шорооны ажлууд дуусаагүй, автозамын ажил замын түвшин жигд бус, мөн ажил нь бүрэн зогссон байдалтай газар дээр нь танилцсан. Тус асуудлаар төслийн нэгжтэй мэдээлэл солилцож хамтран ажилласан. RIBS төслийн нэгж, хяналтын зөвлөх компанийн зүгээс гүйцэтгэгчид өгсөн удаа дараагийн шаардлагын дагуу арга хэмжээ авч ажиллаагүй, гэрээний болон барилгын хуулийг зөрчсөн тул гэрээ цуцлах саналыг захиалагчаас АХБ-нд хүргүүлсэн. АХБ-ны зээлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “BEST төслийн дэд төсөл болох Хавирга боомтын өргөтгөл шинэчлэлийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд тус боомтын батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөлд өөрчлөлт оруулахтай холбогдуулан барилга байгууламж, хяналт шалгалтын тоног төхөөрөмж, тавилгын судалгааг нэгтгэн Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ажлын албанд 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 01-3.1/2369 тоот албан бичгээр хүргүүлсэн. ТХАГ-ын даргын тушаалаар Хавирга боомтын бүтээн байгуулалтын гүйцэтгэгч болон захиалагчийн хяналтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах батлагдсан шалгуурыг АХБ-нд хүргүүлсэн. | 65 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Үнэлгээний хороо байгуулагдаж, Хавирга боомтын бүтээн байгуулалтын гүйцэтгэгч болон захиалагчийн хяналтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах шалгуурыг боловсруулсан. | | Барилгын чанарын хяналтын зөвлөх компанийн сонгон шалгаруулалтын 1-р үе шат явагдаж дууссан бөгөөд 98%-ийн гүйцэтгэлтэй байна.<br><br>1. **97** хувь “бүрэн хангалттай”<br>2. **0** хувь “ажил зогссон хангалтгүй”<br>3. **98** хувь “бүрэн хангалттай”<br><br>Дундаж **65** хувь. | |
| 1.13 | Автозамын хилийн боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэнэ | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | Замын-Үүд гаалийн газрын Зорчигч, ачаа тээврийн шалган нэвтрүүлэх цогцолбор, Шивээхүрэн боомт, Гашуунсухайт боомтын ухаалаг гарцыг нэвтрүүлсэн. “Хилийн удирдлагын нэгдсэн систем ХУН” төслийн хүрээнд гаалийн байгууллага болон хил хамгаалах байгууллагын тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын системийг уялдуулж, автозамын хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн | Ухаалаг гарцыг шинээр нэвтрүүлэх боомт болон хяналтын бүсүүдэд программ хангамжийн дэмжлэг үзүүлэх | Хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийг RFID-ээр нэвтрүүлэхдээ эрсдэлийн удирдлагын программд урьдчилж оруулсан шалгуурын дагуу шалгах системийг Замын-Үүд боомтын зорчигчийн терминалд 3 сарын хугацаатай туршилтаар нэвтрүүлэх асуудлыг 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлсэн. CAIS-т Эрсдэлийн удирдлагын хэлтсээс боловсруулсан шалгуур үзүүлэлтийн дагуу ухаалаг гарцын системд тээврийн хэрэгсэлд эрсдэл тооцох тооцооллыг оруулж, туршилтаар 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 14:00 цагт Замын-Үүд боомтын зорчигчийн терминалд нэвтрүүлснээр 18478 тээврийн хэрэгсэл улаан, 3572 тээврийн хэрэгсэл ногоон төлөвт сонгогдсон байна.<br>Мөн дараах программын даалгавруудыг боловсруулж, Мэдээллийн технологийн газар хүргүүлсэн. Үүнд:<br>-Ухаалаг гарцын заавартнийцүүлэн экспорт, импортын бараа ачих, буулгах, гаалийн хяналт, шалгалт хийх зориулалтаар аж ахуйн нэгжийн тогтоолгосон гаалийн хяналтын бүсүүдэд суурилуулсан RFID тоног төхөөрөмжүүдийг гаалийн байгууллагын системтэй холбох, CAIS, CEPS, Smartgate.ecustoms.mn системд хийгдэх шаардлагатай программын даалгаврыг боловсруулж, 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01101/13 дотоод зурвасаар хүргүүлсэн. Мөн дээрх ажлыг эрчимжүүлэх талаар 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 01101/337 дотоод зурвас хүргүүлсэн.<br>-Эрсдэлд суурилсан зарчимд үндэслэн гаалийн хяналт, шалгалтаас чөлөөлөгдсөн (ногоон) тээврийн хэрэгсэл, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэдээлэл солилцох программыг Замын-Үүд боомтод туршилтаар нэвтрүүлсэн. | | зорчигчийн автобусанд зориулсан гарцыг smartgate.ecustoms.mn систем дээр хэрэглэгч өөрөө буюу хяналт шалгалт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч тохируулдаг байх нэмэлт өөрчлөлт хийлгэхээр 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 01101/365 дотоод зурвасыг хүргүүлсэн.<br><br>**70** хувь "хангалттай" зорилтот түвшиндээ хүрээгүй. | |
| 1.14 | Гадаад худалдааны статистик мэдээллийг түгээх, боловсронгуй болгох | Үйл ажиллагааны зардал | -Гадаад худалдааны статистик мэдээллийг хүлээн авсан хэрэглэгчийн тоо болон цахим лавлагаа авсан хэрэглэгчийн нийт тоо, гадаад худалдааны статистикийн ухаалаг хайлтын программыг сайжруулсан модулийн тоо | Гаалийн цахим үйлчилгээний систем *https://gaali.mn/* -ээс "Барааны экспорт, импортын статистикийн мэдээлэл"-ийг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 481 аж ахуй нэгж, иргэн авсан хандалт хийсэн бол 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 1867 аж ахуй нэгж, иргэн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1386 хэрэглэгчээр буюу 4 дахин өссөн үзүүлэлттэй байна. /Эх сурвалж: *Gaali.mn Статистик цонхон дахь хандалтын тоогоор*/<br>Мөн Гаалийн цахим үйлчилгээний систем *https://gaali.mn/-* | -Гадаад худалдааны статистик мэдээллийг хүлээн авсан хэрэглэгч /хандалт/, цахим лавлагаа авсан хэрэглэгчийн тоо өмнөх оны мөн үеэс өссөн байна.<br>-Гадаад худалдааны статистикийн ухаалаг хайлтын программыг сайжруулсан байна. | 1.1.Гаалийн цахим үйлчилгээний систем www.gaali.mn-ны Статистик цонхонд Гадаад худалдааны барааны статистик мэдээллийг сар бүр байршуулж ажиллаж байна. 2025 оны 6 дугаар сарын 12-ны байдлаар 3,180 аж ахуй нэгж, иргэн тус системээс экспорт, импортын статистик мэдээллийг авч, хандалт хийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2531 хэрэглэгчээр буюу 390 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>1.2.Гаалийн цахим үйлчилгээний системээр https://gaali.mn/ 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 23420 /5768 аж ахуйн нэгж, 17652 иргэн/ аж ахуй нэгж, иргэн гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн лавлагаа авсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16619 хэрэглэгчээр буюу 244 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>2.Гадаад худалдааны статистикийн ухаалаг хайлтын программд 3 чиглэлээр сайжруулалт хийж ажилласан. Үүнд:<br>-Гаалийн цахим үйлчилгээний систем www.gaali.mn/statistic цэсэд байршиж буй хайлтын системийг сайжруулах бодлогын даалгавар боловсруулж 2025 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 02-2.2/1949 албан бичгээр "Аствишн" ХХК-д системд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг явуулсны үр дүнд ухаалаг хайлтын систем сайжирч ашиглахад хялбар болсон.<br>-Tableau системийн "Customs 360 Dashboard"-ийн "Гаалийн ерөнхий газар-Экспортын статистик мэдээлэл", "Гаалийн ерөнхий газар-Импортын статистик мэдээлэл"-ийн дашбоард буюу мэдээллийн самбарыг сайжруулах саналыг Мэдээллийн технологийн газарт хүргүүлж, хамтран ажилласны үр дүнд тус дашбоард ашиглах боломжийг бүрдүүлсэн.<br>-Гаалийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх ажлын хэсгийг мэдээллээр хангах ажлын хүрээнд "Орлогын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ээс “Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа” авахаар 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 19934 аж ахуй нэгж, иргэн хандсан бол 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 39754 аж ахуй нэгж, иргэн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 99%-аар өссөн үзүүлэлттэй байна. | | дүн шинжилгээ”-ний дашбоардыг санаачлан Мэдээллийн технологийн газартай хамтран боловсруулж, ашиглаж байна. "Статистик, дүн шинжилгээний программ"-ын Дүн шинжилгээ->Импортын гаалийн мэдүүлгийн төлөв гэдгээр орж гаальд мэдүүлсэн огнооны интервал болон татвартай горимоор буюу импортын статистикийн аргачлалаар, мөн гаалийн газар, хороодоос сонгож гаргах боломжтой модулийг хөгжүүлж, нэвтрүүлсэн. Мөн нийт импортын макро дүн, татварын дүнгийн харьцуулалтыг өмнөх оны мөн үетэй, барааны бүлэг газар хороодоор, барааны зүйл газар хороодоор гэсэн 3 нөхцөлөөр боловсруулж хийдэг модульд нэмэлт хөгжүүлэлт хийж, нэвтрүүлсэн.<br><br>**100** хувь “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 1.15 | Гадаад орны гаалийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд гадаад худалдааны мэдээлэл солилцох үйл ажиллагааг хөгжүүлэх | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | 2023 оны БНХАУ болон ОХУ-тай хийх зэрэгцүүлэлтийн мэдээллийг боловсруулан ГХАХ-р дамжуулан БНХАУ, ОХУ-аас мэдээллээ ирүүлэх талаар албан хүсэлт тавьсаны үндсэн дээр ОХУ-аас 2023 оны мэдээллийг ирүүлсэн. Харин БНХАУ-ын талаас 2023 оны гадаад худалдааны статистикийн зэрэгцүүлэлтийг хийх боломжгүй гэж ГЕГ-ын ГХАХ- | -Худалдааны түнш орнуудтай гадаад худалдааны мэдээллийг цахим хэлбэрээр солилцсон байна.<br>-БНХАУ-тай 2024 оны гадаад худалдааны статистикийн зэрэгцүүлэлтийг протоколд тусгасан хугацааны дагуу хийнэ. | -ОХУ-ын ХГА-нд 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 01-1.3/762 албан бичгээр 2024 оны болон 2025 оны 01 дүгээр сарын статистик мэдээ, 2025 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 01-1.3/1675 албан бичгээр 2024 оны болон 2025 оны 01 дүгээр улирлын Монгол-Оросын гадаад худалдааны статистикийн мэдээг хүргүүлсэн.<br>-БНХАУ-ын Гаалийн ерөнхий газарт 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр цахим шуудангаар Монгол-Хятадын 2024 оны болон 2025 оны 01 дүгээр улирлын гадаад худалдааны статистик мэдээг хүргүүлсэн. Түүнчлэн БНХАУ-тай хиллэдэг 5 боомт (Зүүнхатавч, Ганцмод, Мандал, Сэхээ, Эрээний төмөр замын болон автозам)-ын 2024 оны Монгол-Хятадын гадаад худалдааны статистик мэдээг цахим шуудангаар 2025 оны 2 болон 4 дүгээр сард цахим шуудангаар хүргүүлсэн. БНХАУ-ын Гаалийн ерөнхий газрын зүгээс Монгол Улсад хүрэлцэн ирж хоёр орны гадаад худалдааны статистикийн зэрэгцүүлэлтийг хийх төсөв 2025 оны Хятадын гаалийн байгууллагын төсөвт ороогүй тул энэ онд зэрэгцүүлэлтийг хийх боломжгүй гэдгийг урьдчилсан байдлаар мэдэгдсэн. | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ээр дамжуулан мэдэгдсэн. Монгол улс, ОХУ хооронд 2023 онд хийсэн гадаад худалдааны барааг БТКУС-ийн орон тус бүрээр зөрүүг гаргах, их зөрүүтэй барааг тогтоох, зөрүүг нарийвчлан шалгах, учир шалтгааныг тогтоох зэрэгцүүлэлтийн ажлыг 2024 оны 9 дүгээр сарын 10-аас хийж эхэлсэн. Зэрэгцүүлэлт хийх барааг сонгон БТКУС-ийн 4 орны түвшингээр /экспортын 6 бараа, импортын 9 бараа /гарган ОХУ-ын **Холбооны гаалийн албанд** хүргүүлсэн. ОХУ-ын талаас экспортын 4, импортын 3 барааны жагсаалт ирүүлсэн. Монгол улс, ОХУ-ын хооронд 2023 онд хийсэн гадаад худалдааны статистикийн зэрэгцүүлэлт хийх экспертүүдийн 4 дүгээр уулзалт 2024.10.03-аас | | **50** хувь “зохион байгуулалт хангалтгүй”. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2024.10.04-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан бөгөөд 2 талын санал солилцсон экспортын 10, импортын 12 барааны зэрэгцүүлэлтийг хийж, зөрүү үүссэн шалтгааныг нарийвчлан тогтоосон. Зэрэгцүүлэлтийн уулзалтыг протокол үйлдэн баталгаажуулан ГХАХ-т хадгалуулсан. Монгол улс, ОХУ хооронд хийсэн гадаад худалдааны 2023 оны статистикийн зэрэгцүүлэлт хийсэн тайланг ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн хуралд танилцуулсан. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.16 | Австрали, Катар, Бүгд Найрамдах Узбекистан Улс, БНХАУ-ын гаалийн байгууллагатай гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | Австрали улсын Сидней хотноо энэ оны 04 дүгээр сард зохион байгуулагдсан ДГБ-ын АНДБН-ийн Гаалийн байгууллагын дарга нарын ээлжит уулзалтаар Тайландын Хаант Улсын гаалийн байгууллагатай “Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай хэлэлцээрийг байгуулсан. | “Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай хэлэлцээрийг 3 Улсын гаалийн байгууллагатай байгуулах. Үүнд:<br>· Австрали Улс; Катар Улс;<br>· Бүгд Найрамдах Узбекистан Улс.<br>БНХАУ-ын ГЕГ-тай “Амьтан, ургамал хилээр оруулах, гаргах үеийн хорио цээрийн техникийн хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгуулах. | “Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Австрали, Катар, Бүгд найрамдах Узбекистан Улстай байгуулахаар төслийг хянан үзэж нөгөө талтай тохиролцон хэлэлцээрийг байгуулахад шаардлагатай арга хэмжээ болон СЯ, ГХЯ-аар хянуулан дотоодын процессыг дуусгасан.<br>Дээрх Хэлэлцээрүүдийг Засгийн газар хооронд байгуулах тул өндөр дээд, хэмжээний айлчлалын хүрээнд зурагдахыг хүлээж байна.<br><br>**85** хувь “зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй”. | 85 |
| 1.17 | Гаалийн төв болон салбар лабораторийг үндэсний болон олон улсын итгэмжлэлд хамруулах | Үйл ажиллагаа | Гаалийн төв болон салбар лаборато-риуд нь Үндэсний болон олон улсын итгэмжлэлд хамрагдсан байна. | - Гаалийн төв лаборатори нь эрдэс түүхий эд, нүүрс, газрын тос, химийн бодис, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, бэлдмэл, согтууруулах ундаа, тамхи, ноос ноолуур малын гаралтай ширхэгт бүтээгдэхүүний магадлан шинжилгээний чиглэлээр Үндэсний итгэмжлэлд, уул уурхайн хүдэр баяжмал, | <u>Гаалийн төв лаборатори:</u><br>- Үндэсний итгэмжлэлийн үнэлгээний байгууллага /MNAS/<br>- БНХАУ-ын итгэмжлэлийн үнэлгээний байгууллага /CNAS/<br>Үнэлгээнд тус тус хамрагдаж, итгэмжлэлийн эрхээ сунгуулсан байна.<br><br><u>Гаалийн салбар лабораториуд:</u><br>Үндэсний итгэмжлэл:<br>- ЗҮГГ, ОРГГ, СШГГ-ын гаалийн салбар лабораториудыг химийн бодис, | 1.1.2025 оны 06 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд Үндэсний итгэмжлэлийн төв (MNAS) болон Ази номхон далайн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (APAC)-ын хамтарсан “Гаалийн төв болон салбар лабораторийг эрдэс түүхий эд, нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис, бэлдмэл, хар тамхи мансууруулах бодис, согтууруулах ундаа, тамхи, тамхин бүтээгдэхүүн, ноос ноолуур малын гаралтай ширхэгт бүтээгдэхүүн, ээрмэл, сүлжмэл материалын шинжилгээний чиглэлээр давтан итгэмжлүүлэх, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүйн үзүүлэлт, ургамал хорио цээрийн шинжилгээний чиглэлээр итгэмжлэлийн хүрээг өргөтгөх” үнэлгээнд амжилттай хамрагдав. Урьдчилсан дүнгээр 2 үл тохиролтойгоор тэнцсэн бөгөөд уг үл тохирлыг залруулан, баримтжуулж, “Үл тохирлыг залруулсан тухай тайлан” (23 хуудас )-г Гаалийн төв лабораторийн 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 02-2.3/534 дугаар албан бичгээр Үндэсний итгэмжлэлийн төвд хүргүүлсэн. 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн ҮИТ-ийн техникийн хорооны хурлаар хэлэлцэж итгэмжлэлийн эрхээ 4 жилийн хугацаатайгаар /2025- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нефтийн бүтээгдэхүүн, нүүрсний шинжилгээний чиглэлээр БНХАУ-ын итгэмжлэлийн үнэлгээний байгууллага/CNAS/-ын үнэлгээнд хамрагдаж сорилт хийх эрхийг авсан.<br>- ЗҮГГ-ын гаалийн салбар лаборатори нь хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр Үндэсний итгэмжлэлд хамрагдсан. | бэлдмэл, эрдэс түүхий эд, нефтийн бүтээгдэхүүн, нүүрсний шинжилгээний чиглэлээр үндэсний итгэмжлэлд хамруулсан байна. | 2029 он/ сунгаж, хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн шинжилгээний чиглэлээр хүрээг өргөтгөх шийдвэр гарсан.<br>1.2.Гаалийн төв лаборатори нь уул уурхайн хүдэр баяжмал, нефтийн бүтээгдэхүүн, нүүрсний шинжилгээний чиглэлээр БНХАУ-ын Итгэмжлэлийн байгууллага болох CNAS (China National Accreditation Service for Conformity Assessment)-ийн давтан үнэлгээнд 2025 оны 4 дүгээр сарын 18-21-ний өдрүүдэд амжилттай хамрагдаж, итгэмжлэлийн эрхээ амжилттай хамгаалж баталгаажуулсан.<br>2.Гаалийн 12 салбар лабораториудыг эрдэс түүхий эд, нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис, бэлдмэл, хар тамхи мансууруулах бодис, согтууруулах ундаа, тамхи, тамхин бүтээгдэхүүн, ноос ноолуур малын гаралтай ширхэгт бүтээгдэхүүн, ээрмэл, сүлжмэл материал, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүйн үзүүлэлт болон ургамал, хорио цээрийн шинжилгээний чиглэлээр итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтыг салбар тус бүрээр гаргаж, ҮИТ-ийн техникийн хорооны хурлаар орж, итгэмжлэлийн бичиг баримтаар 4 жилийн хугацаатайгаар /2025-2029 он/ амжилттай итгэмжлүүлэхээр шийдвэрлэгдсэн.<br><br>**100** хувь “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 1.18 | Гаалийн хяналтад эрэлч нохойн ашиглалтыг нэмэгдүүлнэ. | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн зэрэг үзүүлэлт | Харьяа гаалийн 13 газар хороодод эрэлч нохойг хяналт шалгалтад ашиглаж байна. | -Гаалийн газар хороодын эрэлч нохойн ашиглалтын 6 сарын мэдээг цуглуулж үнэлгээ өгсөн байна.<br>-Албаны эрэлч нохойн ашиглалтын мэдээг нэгтгэж, CAIS программд мэдээллийн санг үүсгэнэ. | 1.Гаалийн ерөнхий газрын харьяа 16 гаалийн газар, 3 гаалийн хорооноос 13 гаалийн газар 3 хороонд эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч ажиллахаар бүтэц орон тоо батлагдсанаас 2025 оны эхний хагас жилийн байдлаар 11 гаалийн газар 2 хороонд 33 эрэлч нохойг гаалийн хяналт шалгалтад тогтмол ашиглаж байна. 2025 оны 01-05 дугаар саруудад албаны эрэлч нохойгоор 37,306 тээврийн хэрэгсэл, 268,242 зорчигчийн гар тээш, дагалдах ачаа бараанд гаалийн хяналт шалгалтыг хийж, ашигласан байна.<br>2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар эрэлч нохой ашиглан нийт 20 удаагийн зөрчил илрүүлснээс эрүүгийн 3 зөрчил байна. Үүнд:<br>1. Замын-Үүд дэх гаалийн газар 5 зөрчил,<br>2. Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар 10 зөрчил,<br>3. Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар 3 зөрчил, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4. Шивээхүрэн дэх гаалийн газар 1 зөрчил,<br>5. Дорнод аймаг дахь гаалийн газар 1 зөрчил тус тус илрүүлэн ажилласан.<br>Эрэлч нохой ашиглан илрүүлсэн зөрчлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 42.86 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>2.Гаалийн байгууллагад ажиллаж байгаа эрэлч нохойн ашиглалтын мэдээг нэгтгэх, мэдээллийн санг үүсгэх зорилгоор Захиргаа, дотоод ажлын систем /https://cerp.ecustoms.mn/-ийн хилийн хөдөлгөөний мэдээ дэд цэсэд эрэлч нохой ашиглалт нэртэй баганыг шинээр нэмж тээврийн хэрэгсэл орсон гарсан, гар тээш, дагалдах ачаа, бараа орсон гарсан, илрүүлсэн зөрчил орсон гарсан гэсэн 6 төрлийн үзүүлэлтүүдээр тоон мэдээллүүдийг нэгтгэх программын хөгжүүлэлтийг хийлгэн ашиглаж байна. Хилийн хөдөлгөөний мэдээний эрэлч нохой ашиглалт хэсэгт орж байгаа мэдээллийн санд эрэлч нохойн сургалтын төвийн гаалийн улсын ахлах байцаагч 1, гаалийн улсын байцаагч 4, нийт 5 албан хаагч тогтмол хяналт тавин ажиллаж байна.<br>Хилийн хөдөлгөөний мэдээ цэсээр дамжуулан авч байгаа тоон үзүүлэлтүүдийг нэгтгэн нийт гаалийн хяналт шалгалтад эрэлч нохойн эзлэх хувийн жинг тодорхойлоход 2025 оны 01-05 дугаар сарuудын дундаж 1.06 хувьтай байна.<br><br>**100** хувь “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 1.19 | Байгууллагын үйл ажиллагааг үндэсний болон олон улсын стандартад нийцүүлэх | Үйл ажиллаг аа | Гаалийн байгууллагы н гадаад, дотоод үйл ажиллагаа стандартад нийцсэн байдал /өссөн дүнгээр/ | -Эрсдэлийн удирдлагын стандарт 31000:2020;<br>- Дэлхийн худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байлгах тухай багц стандартыг гадаад худалдааг хөнгөвчлөх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, Гаалийн | Эрсдэлийн удирдлагын стандарт 31000:2020;<br>-Дэлхийн худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байлгах тухай багц стандартыг үйл ажиллагаанд ашиглана.<br>Хэрэгжилт нийт: 34.3% | Нэг.Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг Олон улсын стандартын байгууллагын Эрсдэлийн удирдлагын зарчим ба стандарт ISO 31000:2018, Монгол Улсын Эрсдэлийн удирдлагын стандарт 31000:2020 баримт бичигт үндэслэн хэрэгжүүлэх чиглэлээр Эрсдэлийн удирдлагын хэлтсээс харьяа гаалийн газар, хороод, Ёс зүйн дэд хороог мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан.<br>Хоёр. Дэлхийн худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байлгах тухай багц стандартын “Гааль-Бизнесийн түншлэл” тулгуур баганын ИААН хөтөлбөрийн цар хүрээг нэмэгдүүлэх хүрээнд:<br>-Бизнес эрхлэгчдэд сурталчлах: Гааль-бизнесийн түншлэлийг бэхжүүлэх зорилгоор МҮХАҮТ-тай хамтран хууль сахилт сайн үндэсний үйлдвэрлэгч 15 аж ахуйн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн баталгаажуулалт хийхэд ашигласан. Стандартыг хэрэгжүүлсэн хувь: 10.3% | | нэгж (МАК ХК, Тод оймс, Лоро Пьяно Монгол, Монголын экспортын кластерийн холбоо ТББ, Урбанек, Янмал, Есөн Од фүүдс гэх мэт)-д итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрт хамрагдах урилгыг хүргүүлж, хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаң, 8 сургалт зохион байгуулж, 30 худалдаа эрхлэгчдэд гаалийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан.<br>-Цахим программд өөрчлөлт оруулах чиглэлээр: Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (AEO)-ийн гаалийн бүрдүүлэлт хамгийн түрүүнд болон өөр өнгөөр бусад бүрдүүлэлтээс ялгарч харагдах байдлаар программд нэмэлт, өөрчлөлт оруулсан.<br>-Гаалийн мэдээллийн удирдлагын систем (Cims.gaali.mn)-ийн Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж цэсний "Гадаадын гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж бүртгэх", “Дотоодын гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж бүртгэх” хэсгийн талбарт нэмэлт өөрчлөлт оруулах талаар бодлогын даалгаврыг боловсруулж, Аствижн ХХК-аар холбогдох ажлыг гүйцэтгүүлж байна.<br>Сургалт, сурталчилгааны чиглэлээр:<br>Монголын Увс хүнс ХХК, Лхамур ХХК, Агни ХХК, Монголиан кашимер ХХК, Гурван сор ХХК, Монголын гоо сайхны /косметикийн/ кластерийн 8 аж ахуйн нэгжийн 10 ажилтан, АПУ ХК-ийн гадаад худалдаа хариуцсан удирдлага, менежерийн албан тушаал бүхий 20 ажилтанд ГИААН хөтөлбөрийн талаар цахим болон танхимын сургалтыг зохион байгуулсан.<br>-Гаалийн байгууллагын https://customs.gov.mn/ веб сайт болон Монголын гааль фэйсбүүк хуудсанд “Монгол, БНХАУ-ын гаалийн байгууллага Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (AEO)-ийг Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг эрчимжүүлэх цахим уулзалт зохион байгуулсан тухай /2025.04.01/”, “БНХАУ-тай байгуулсан Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (AEO)-ийг Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхлэх тухай /2025.05.27/” гэсэн мэдээллийг нийтлүүлж, олон нийтэд сурталчилсан.<br>Гурав.Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх чиглэлээр БНХАУ, БНСУ, Хонг-Конг, ОХУ, Тажикистан Улсын гаалийн байгууллагатай 23 | |
| | | | ИААН-ийн хөтөлбөрт хамруулсан ААН-ийн тоо /тоогоор/ | “Говь” ХК, “АПУ” ХК, “Ханбогд Кашимер” ХХК-ын баталгаажуулалтын үр дүнд 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 09/02 дугаар шийдвэрээр тус аж ахуйн нэгжүүдийн экспорт, импортын үйл ажиллагаанд 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн гурван жилийн хугацаагаар гаалийн итгэмжлэл олгохоор шийдвэрлэсэн.<br>Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын гаалийн итгэмжлэлийн хугацааг ГЕГ-ын даргын 2024 оны 12 сарын А/718 дугаар тушаалаар сунгасан. | Гадаад орнуудтай Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх чиглэлээр байгуулсан хэлэлцээр, бусад баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх<br><br>Нийт: 37% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахим захидал солилцож, 7 уулзалтыг зохион байгуулсан:<br>-Монгол, БНХАУ-ын гаалийн байгууллага Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (AEO)-ийг Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг эрчимжүүлэх цахим уулзалт зохион байгуулж, 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс албан ёсоор хэрэгжүүлсэн.<br>-БНСУ-ын гаалийн байгууллагатай “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр”-ийн хэрэгжилт, 2025 онд хамтран ажиллах чиглэлийг тодорхойлох цахим уулзалтыг 3 удаа хийсэн.<br>-Беларусь Улстай байгуулахаар төлөвлөсөн ИААН-ийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийн төсөлд өгөх саналыг Хуулийн хэлтэст хүргүүлсэн.<br>-Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Гааль татварын газартай Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг байгуулах ажлыг 2025 оны 04 дүгээр сараас эхлүүлсэн.<br>Хүрсэн үр дүн:<br>-Эрсдэлийн удирдлагыг олон улсын стандарт (ISO 31000:2018)-ын дагуу хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, Гаалийн байгууллагын Авлигын эрсдэлийн зураглал гаргах аргачлалыг боловсруулж, үйл ажиллагаандаа ашиглан, Авлигатай тэмцэх газар, Ёс зүйн хороонд хүргүүлж, ГЗДАС-ийн Ёс зүйн дэд хороо талбарт байршуулж, Гаалийн байгууллагын Ёс зүйн эрсдэлийн үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлж, сайн туршлагыг Монгол Улсын Ёс зүйн хороо, Удирдлагын академитай хуваалцсан.<br>-ИААН хөтөлбөрийн цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор үндэсний үйлдвэрлэл эрхлэгч 15 ААН-д урилга хүргүүлж, хөтөлбөрийг сурталчлан, 5 ААН-д удирдамжийг батлуулж, 2 ААН-ийн ажлын байрны үнэлгээ, баталгаажуулалтыг хийж, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд танилцуулах бэлтгэл ажлыг хангасан.<br>Гаалийн төв лабораторид ИААН-ийн барааны дээжийг дараалал харгалзахгүй магадлан шинжилгээнд хамруулах, сорилтын дүн, дүгнэлт гаргах үйл ажиллагааг аль болох богино хугацаанд гаргах, магадлан шинжилгээний дүгнэлтийн хугацааг 3 сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүчинтэй байхаар зохицуулалт хийснээр бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацаа, зардлыг бууруулж худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн.<br>Мал эмнэлгийн ерөнхий газарт "ИААН-ийн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж чиг үүргийн хүрээнд тулгамдаж байгаа асуудлыг хэлэлцэж, хялбарчлах арга замын шийдлийг олох" талаар хамтын ажиллагааг эхлүүлсэн.<br>-Гадаад орны гаалийн байгууллагатай ИААН-ийг харилцан хүлээн зөвшөөрөх хүрээнд БНХАУ-ын ГЕГ-тай байгуулсан хэлэлцээрийг албан ёсоор эхлүүлж, хоёр орны Гаалийн байгууллагаас итгэмжлэл авсан аж ахуйн нэгж 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс талуудын импортын бүрдүүлэлтэд хөнгөлөлт эдлэх боломжийг бүрдүүлсэн.<br>ОХУ, Беларусь, Хонгконгийн Гаалийн байгууллагатай ИААН-ийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулах идэвхтэй хамтын ажиллагааг хөгжүүлж эхэлсэн.<br><br>**100** хувь "бүрэн хангалттай" зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 1.20 | "Цахим нэг цонхны систем"-ийг бий болгох ажлын хэсэгт ажиллах. | | | ЭЗХЯ-ны ТНБД-ын 2023.10.03-ны өдрийн А/184 тушаалаар байгуулагдсан "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэгт гаалийн | 1.Цахим нэг цонхны мэдээллийн системийг бий болгох ажлын хэсэгт ажиллана.<br>2.Олон улсын зөвлөх үйлчилгээний компанитай хамтран ажиллаж, гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хүргүүлнэ. | ЭЗХЯ-ны ТНБД-ын 2023 оны А/138 дугаар тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасан "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэгт Гаалийн ерөнхий газрын Хяналт, бүрдүүлэлтийн газар, Татвар, орлогын газар, Хорио цээрийн хэлтэс, Мэдээллийн технологийн газрын албан хаагч нар ажиллаж байна. Тус ажлын хэсэг 2025 оны эхний 5 сард хуралдаагүй байна.<br>Монгол улсад гадаад худалдааны харилцааг зохицуулах тарифын бус хязгаарлалтын аргаас бүртгэл, зөвшөөрлийн хэлбэрийг хамгийн өргөн хэрэглэдэг бөгөөд улсын хилээр нэвтрүүлэх тодорхой нэрийн бараанд тусгай зөвшөөрөл болон бүртгэл олгох замаар төрөөс хяналт тавьж байна. Иймд гадаад худалдаатай холбоотой дээрх зөвшөөрлийг олгодог байгууллагууд цахим нэг цонх мэдээллийн системийг ашиглаж, олон төрлийн үйлчилгээ, мэдээллийг нэг дор төвлөрүүлснээр | 71 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгууллагын 7 албан хаагч ажиллаж байна. АХБ-ны гадаад зөвлөх тендерийн баримт бичгийг боловсруулж байгаа ба 2024 оны 10 дугаар сард Цахим нэг цонхны зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдсан. Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн нэгжээс Цахим нэг цонхны системийг бий болгоход удирдаж явах болон цаашид дараа авч явах агентлагийг сонгох ажил хүлээгдэж байна. | | гаалийн байгууллагын үйл ажиллагааг хялбарчилж, гадаад худалдаанд оролцогч нарт чирэгдэлгүй орчин бүрдүүлэхээр ажиллаж байна.<br>Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу ХЗДХЯ, ЦЕГ-аас олгодог галт зэвсэг, сум, адилтгах хэрэгсэл, дагалдах хэрэгсэлд олгодог тусгай зөвшөөрлийг цахимаар олгох болон гаалийн байгууллагын CAIS-т гаалийн мэдүүлэгт цахимаар татах интеграци хийж, харилцан мэдээлэл солилцох, хяналт бүртгэлийг сайжруулах ажлыг эхлүүлсэн. Иргэний зориулалтаар хилээр оруулах галт зэвсэгт Цагдаагийн байгууллагаас олгодог зөвшөөрлийг CAIS-т гаалийн мэдүүлэгт цахимаар татах асуудлаар ХЗДХЯ-ны мэргэжилтэн Энх-Эрдэнэ, СМТТ УТҮГ, ЦЕГ-ын төлөөлөлтэй 2025 оны 02 дугаар сарын 11, 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр уулзалт зохион байгуулж, дараах ажлуудыг хэрэгжүүлж байна. Үүнд:<br>--Гаалийн байгууллагын автоматжуулсан CEPS, CAIS системд нэмэлт хөгжүүлэлт хийж, эм, эмнэлгийн хэрэгслийн импортын мэдүүлгийг E-mongolia болон эмийн бүртгэл, мэдээллийн Licemed системээс цахимаар татаж, гаалийн бүрдүүлэлт хийдэг болгосон;<br>-Онцгой албан татвартай барааны хяналтыг сайжруулах зорилгоор тусгай зөвшөөрөл, онцгой албан татварын тэмдэгтэй холбоотой мэдээллийг ХХААХҮЯ, Татварын ерөнхий газартай солилцох системийн хөгжүүлэлтийг хийлгэж байна;<br>-Озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан, ашигласан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрлийг цахимжуулан, CAIS-т холбож, мэдээлэл солилцох системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд БОУАӨЯ-ны ОУА-тай хамтран ажиллаж байна.<br>-ХЗДХЯ болон ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төвөөс олгож буй галт зэвсгийн тусгай зөвшөөрлийг цахимжуулах программын даалгавар боловсруулах,<br>-Гаалийн байгууллагын цахим системтэй холбох, ингэхдээ БТКУС-ийн ангиллын кодоор “заавал” татахгүйгээр, эхний байдлаар шаардлагатай тохиолдолд олгосон зөвшөөрлийг мэдүүлэгт татаж оруулж байх; | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Цаашид Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, галт зэвсэг, дагалдах хэрэгслийн ялгааг нарийн тодорхойлох боломжтой болсны дараа “заавал” татаж оруулдаг болгохоор программд өөрчлөлт оруулах ажлуудыг хэрэгжүүлж байна.<br>-Мөн галт зэвсгийн зөвшөөрлийг гаалийн мэдүүлэгт цахимаар татах хөгжүүлэлт хийгдэж байгаатай холбогдуулан БТКУС-ийн жагсаалтыг СМТТ УТҮГ-т хүргүүлсэн.<br>Цахим нэг цонхны ажлын хэсгийн хурлыг 2025 оны эхний хагас жилийн байдлаар зохион байгуулаагүй. Цахим нэг цонхыг бий болгох зөвлөх үйлчилгээний тендер зохион байгуулах ажил ЭЗХЯ дээр хүлээгдэж байна.<br>1. **71** хувь “хангалттай” шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах.<br>2. **71** хувь “хангалттай” шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах<br><br>Дундаж **71** хувь. | |
| 1.21 | Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд стандарт нэвтрүүлэх | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | Байгууллагын үйл ажиллагаанд стандарт нэвтрүүлээгүй байна. | Байгууллагын үйл ажиллагаанд стандарт нэвтрүүлэх ажлын холбогдох судалгааг хийнэ. | Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх шаардлагатай стандартуудыг судалсны үндсэн дээр ISO 9001:2015 “Чанарын менежментийн тогтолцоо”, ISO 27001:2022 “Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо” стандартуудыг үе шаттайгаар нэвтрүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж, дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээд байна. Үүнд:<br>-Стандартыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд мэргэжлийн зөвлөх байгууллагын дэмжлэг авах шаардлагатай гэж үзэж, 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр “Менежмент ба ур чадварын хүрээлэн” төрийн бус байгууллагатай ГЕГ-ын 30/25 дугаар бүхий “Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулсан.<br>-Дээрх стандартуудыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үндсэн ажлын хэсгийг байгуулж, хийж гүйцэтгэх чиг үүргээр нь ялган 8 ажлын багт 55 албан хаагчийг, туслах чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийг мөн 8 багт хуваан байгуулж, Гаалийн ерөнхий газрын нийт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албан хаагчдыг хамруулсан. Эдгээр ажлын хэсгийг Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны А/250 дугаар тушаалаар байгуулсан.<br>-Одоогоор үндсэн ажлын хэсгийн багийн гишүүд зөвлөх байгууллагаас зохион байгуулсан сургалт, танилцуулгад хамрагдаж, тухайн стандартуудын хүрээнд байгууллагын өнөөгийн байдлыг үнэлэх зөрүүгийн шинжилгээг хийж байна. Уг шинжилгээний үр дүнд үндэслэн дараагийн шатны нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.<br><br>**100** хувь “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 2 | Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах | | | | | | |
| 2.1 | Гаалийн зөрчилтэй тэмцэх үйл ажиллагааг сайжруулах | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн ээрэг үзүүлэлт | 1.Tableau, Dashboard программыг ашиглах эрхийг МТГ-т хандаж нээлгэсэн.<br>2.Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж болзошгүй, эрсдэлтэй 3 төрлийн барааны талаарх холбогдох мэдээллийг Монголын гааль цахим хуудсаар түгээсэн.<br>3.2024 онд нийт 1206 зөрчил илрүүлснээс хориглосон, хязгаарласан барааг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн зөрчил 684, | 1.Зөрчлийн мэдээллийг Tableau, Dashboard программыг ашиглан боловсруулж, мэдээллээр хангах ажлыг бүрэн нэвтрүүлсэн байна.<br>2. Зөрчлийн мэдээлэлд үндэслэн хориглосон, хязгаарласан бараатай бусдын дайвар ачааг улсын хилээр нэвтрүүлэх зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.<br>3. Хориглосон, хязгаарласан барааг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийсэн зөрчил илрүүлэлтийн тоо хэмжээний нийт илрүүлсэн зөрчилд | 1.Зөрчлийн мэдээллийг Tableau, Dashboard программыг ашиглан боловсруулж, мэдээллээр хангах ажлын хүрээнд Мэдээлэл технологийн газраас 2025 оны 05 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулсан Tableau-Дата аналистикийн ахисан түвшний сургалтад Зөрчилтэй тэмцэх газрын гаалийн улсын байцаагч Ц.Ануужин оролцож, Tableau болон CUSTOMS 360 Dashboard-ийн талаарх ахисан түвшний ойлголтыг авч ажил үүрэгтээ хэрэгжүүлэх боломжоор хангагдсан.<br>Customs 360 Dashboard дээр Зөрчлийн мэдээллийг нэгтгэсэн байдлаар Гаалийн байгууллагын хэмжээнд нийт дүнгээр харах, болон харьяа гаалийн газар хороогоор ангилж харах зөрчлийн тоо, торгуулийн дүн, нөхөн төлүүлсэн татварын дүн, зөрчлийн улмаас хураагдсан барааны Dashboard бэлтгэх, мөн зөрчлийн зүйлчлэлээр нарийвчилж харах Dashboard угсрахаар төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.<br>2.Зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ажил зохион байгуулсан байна. Үүнд:<br>- Гаалийн байгууллагын хэмжээнд 2024 оны байдлаар илрүүлэн шийдвэрлэж, холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн зөрчлийн мэдээллийг “Монголын гааль” цахим хуудсанд 2 удаа нийтэлж гаалийн харилцаанд оролцогч иргэд, аж ахуйн нэгжид сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэсэн.<br>- “Хуурамч, хортой” гэх архи, согтууруулах ундааны зүйлсийг улсын хилээр нэвтрүүлэхээс урьдчилан | 93,3 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийсэн зөрчил 683 тус тус илрүүлсэн. | эзлэх хувийг 2 хувиар нэмэгдүүлнэ. | сэргийлэх ажил зохион байгуулах тухай 01-2/659 албан бичгийг харьяа гаалийн газар, хороодод чиглэл хүргүүлсэн,<br>- Архи, согтууруулах төрлийн ундаа хууль бусаар нэвтрүүлэх зөрчил уламжлалт баяр болох цагаан сарын өдрүүд ойртож байгаатай холбоотойгоор ихсэх хандлагатай байдаг тул улсын хилээр нэвтрэх зорчигч, жолооч, тээвэрлэгч нарт хандаж хууль тогтоомжид заасан тоо хэмжээнээс хэтрүүлсэн эсвэл оюуны өмчийн болон хаяг шошгын зөрчилтэй, хуурамч байж болзошгүй архи, согтууруулах ундааны зүйлсийг улсын хилээр нэвтрүүлэх зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлж, сонор сэрэмжтэй байхыг анхааруулсан мэдээллийг “Монголын гааль” цахим хуудсаар нийтэлсэн.<br>- Улсын хилээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хууль бусаар нэвтрүүлсэн үйлдлийн талаарх мэдээллийг сэрэмжлүүлэг болгон “Монголын гааль” цахим хуудсаар 2 удаа нийтэлсэн.<br>- Тусгай зөвшөөрөлтэйгөөр улсын хилээр нэвтрүүлдэг Салютыг хууль бусаар нэвтрүүлбэл хуулийн хариуцлага хүлээх тухай мэдээллийг Монголын гааль цахим хуудсаар нийтэлсэн.<br>- CITES конвенцэд орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг хууль бусаар нэвтрүүлэхэд хүлээлгэх хариуцлагын талаар сэрэмжлүүлэг мэдээг Монголын гааль цахим хуудсаар нийтэлсэн.<br>3.Гаалийн байгууллагын хэмжээнд 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 1768 зөрчил илрүүлэн 4048.18 сая төгрөгийн татвар нөхөн төлүүлж, 2813.7 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан байна. Үүнээс:<br>- 1673 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж 3892.98 сая төгрөгийн татвар нөхөн төлүүлж, 2711.6 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан байна.<br>- 50 зөрчлийн хэрэг бүртгэлт хийж, 155.2 сая төгрөгийн татвар нөхөн төлүүлж, 102.1 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан байна.<br>- 45 гэмт хэргийн шинжтэй үйлдлийг харьяаллын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлсэн байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <table><tr><td></td><td>2024.06.10</td><td>2025.06.10</td></tr><tr><td>Зөрчлийн тоо</td><td>1194</td><td>1768</td></tr><tr><td>Торгуулийн дүн</td><td>1777.8</td><td>2813.7</td></tr><tr><td>Нөхөн төлүүлсэн татвар</td><td>2519.2</td><td>4048.18</td></tr></table> Нийт зөрчлийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 48 хувиар, торгуулийн дүн 58.2 хувиар, нөхөн төлүүлсэн татвар 61 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.<br>Гаалийн болон бусад татвараас зайлсхийх 615 зөрчил, тарифын бус хязгаарлалттай барааг хууль бусаар нэвтрүүлсэн 459 зөрчил илрүүлсэн нь нийт зөрчлийн 61 хувийг эзэлж байна. Гаалийн болон бусад татвараас зайлсхийх зөрчил өнгөрсөн оны мөн үеэс 85.2 хувиар, хориглосон, хязгаарласан барааг хууль бусаар нэвтрүүлсэн зөрчил 26.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.<br><br>1. **80** хувь зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн.<br>2. **100** “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн.<br>3. **100** “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн.<br><br>Дундаж **93.3** хувь. | |
| 2.2 | Хяналтын нэгдсэн төвийг гаалийн хяналт, шалгалтад үр бүтээлтэй ашиглах | Үйл ажиллагаа | Зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, нэгдсэн системийг ашиглан илрүүлсэн зөрчлийн тоо, хувиар | Теле хяналтын нэгдсэн системийг ашиглан, мэдүүлэгт дүн шинжилгээ хийж, зөвлөмж мэдээллээр хангаж ажилласнаар, гаальд мэдүүлсэн барааны нэр төрөл, тоо хэмжээ зөрүүтэй 87 зөрчил илэрсэн тул зөрчлийн арга хэмжээгээр 510.77 сая.төгрөгийн татварыг нөхөн | Хяналтын нэгдсэн төвийг ашиглан гаалийн хяналт шалгалтад эрсдэл тооцож, илрүүлсэн зөрчлийн тоо өмнөх оныхоос 3 хувиар өссөн байна. | Тайлант хугацаанд CAIS-д мэдүүлсэн бараа тээврийн хэрэгслийн өгөгдлийг Таблью дата аналитик платформ ашиглан, бодит цагаар боловсруулан сонгогдсон эрсдэлтэй гаалийн мэдүүлэгт Теле хяналтын нэгдсэн систем болон рентген тоног төхөөрөмж, ухаалаг гарц, дугаар таних системд хүлээн авсан мэдээлэлд давхар дүн шинжилгээ хийн, эрсдэл тооцож, CAIS Зөвлөмжийн программаар харьяа гаалийн газар, хороодод 62 зөвлөмжийг гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд илгээсэн байна. Үүнээс 59 буюу 95.2 хувьд нь татвараас зайлсхийсэн болон зайлсхийхийг завдсан, эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрлөөр улсын хил нэвтрүүлэх шаардлагатай хориглосон хязгаарласан барааг хууль бусаар хил нэвтрүүлэхийг завдсан зөрчлүүдийг илрүүлсэн байна.<br>Зөвлөмжийн дагуу илрүүлсэн 59 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.21 дүгээр зүйлийн 1.1, | 100 |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>төлүүлж, 246.57 төгрөгийн торгууль ногдуулан төлүүлсэн.</td>
<td></td>
<td>1.2 дахь заалтын дагуу арга хэмжээ авагдаж, 369.93 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 150.08 сая төгрөгийн торгууль ногдуулж барагдуулсан.<br><table><tr><th>Он</th><th>2024.06.10</th><th>2025.06.10</th><th>Хувь</th></tr><tr><td>Зөвлөмжийн тоо</td><td>60</td><td>62</td><td>3.3</td></tr><tr><td>Зөрчлийн тоо</td><td>47</td><td>59</td><td>21.5</td></tr><tr><td>Нөхөн төлүүлсэн татвар /сая.төг/</td><td>257.3</td><td>369.9</td><td>43.7</td></tr><tr><td>Торгууль /сая.төг/</td><td>119.9</td><td>150.08</td><td>25.2</td></tr></table>Зөвлөмжөөр илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татвар, торгуулийн дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зөрчил 21.5 хувиар, нөхөн төлүүлсэн татвар 43.7 хувиар, торгууль 25.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.<br>Тайлант хугацаанд илрүүлсэн томоохон зөрчлүүдээс дурдвал:<br>-1 удаагийн үйлдлээр 3 тээврийн хэрэгсэл "хар цаас" гэж мэдүүлсэн 89.75 тн хориглосон хязгаарласан барааг /хөрстэй мод/ улсын хилээр хууль бусаар, худал мэдүүлж нэвтрүүлснийг илрүүлж таслан зогсоосон.<br>-1 удаагийн үйлдлээр 2 тээврийн хэрэгсэл "цемент" гэж мэдүүлсэн 83,37тн бараа нь зөвлөмж илгээснээр хяналт шалгалтаар /полистирол 48370кг, полиэтилен 35000кг/ улсын хилээр худал мэдүүлж нэвтрүүлснийг илрүүлж, эрүүгийн хуулийн 18.3-р зүйл харьяаллын дагуу Замын-Үүд сумын сум дундын цагдаагийн хэлтэст шилжүүлж, 76.0 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэн.<br><br>100 хувь “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн.</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>2.3</td>
<td>Дотоод хяналт, шалгалт, гомдол мэдээлэл болон гаалийн байгууллагын дотоод эрсдэлийн түвшинд тулгуурласан төлөвлөгөөт</td>
<td>Үйл ажиллагаа</td>
<td>Хэрэгжилт, гүйцэтгэлээр</td>
<td>1.Гаалийн байгууллага, албан тушаалтантай холбоотой нийт 72 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаж, хуулийн хүрээнд бүрэн</td>
<td>1.Гаалийн байгууллагын үйл ажиллагаа болон албан хаагчидтай холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэл шалгагдаж шийдвэрлэгдсэн байна.</td>
<td>1.Гаалийн байгууллагын үйл ажиллагаа болон албан хаагчидтай холбоотой аж ахуй нэгж, иргэдээс болон Засгийн газрын 11-11 төв, Гаалийн ерөнхий газрын 1800-1281 гомдол мэдээлэл хүлээн авах тусгай дугаарт нийт 25 гомдол мэдээлэл ирүүлснийг хүлээн авч, тус гомдол, мэдээлэлтэй холбогдуулан 36 албан хаагчдаас тайлбар, мэдээлэл авч албаны дотоод хяналт, шалгалт явуулсан. Үүнээс 16 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах саналтайгаар Гаалийн ерөнхий газрын сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, 13 албан</td>
<td>100</td>
</tr>
</table>

<table>
<tr>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2">болон төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн шалгалтуудыг хэрэгжүүлэх</td>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2"></td>
<td>шийдвэрлэсэн байна.</td>
<td></td>
<td rowspan="2">хаагчдын сахилга, ёс зүйн зөрчилд нь сахилгын шийтгэл ногдуулсан байна.<br>Тайлант хугацаанд албан хаагчидтай холбоотойгоор ирүүлсэн гомдол, мэдээллийн тоо 21.8 хувиар, шалгагдсан албан хаагч 57.6 хувиар, сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр шилжүүлсэн албан хаагчдын тоо 36 хувиар тус тус буурсан байна. Харин сахилгын шийтгэл оногдуулсан албан хаагчийн 44.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>2.Нийт 25 удаагийн гомдол мэдээллийн дагуу 36 албан хаагчдаас тайлбар мэдээлэл авч ажилласан байна. Үүнээс:<br>-Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн 16 албан хаагч,<br>-Сахилгын хорооны хуралдаанаас сахилгын арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн 13 албан хаагч,<br>Нийт 25 удаагийн ирүүлсэн гомдол, мэдээллийг мэдээллийн эх сурвалжаар нь харуулбал:<br>-Засгийн газрын 11-11 төвөөс ирүүлсэн 2,<br>-Гаалийн лавлах 1800-1281 дугаарт ирүүлсэн 6,<br>-Гаалийн ерөнхий газрын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагаас дотоод албан бичгээр ирүүлсэн 5,<br>-Албан бичгээр хандаж гаргасан 10,<br>-Бичгээр өргөдөл гомдол гаргасан 2,<br>Тайлант хугацаанд албан хаагчдад оногдуулсан сахилгын шийтгэлийн төрлөөр нь ангилбал:<br>-Албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар 20 хувиар бууруулах 3,<br>-Сануулах 4,<br>-Гаалийн улсын байцаагчийн эрхийг хасах 4,<br>-Гаалийн улсын байцаагчийн зэрэг дэвийг бууруулах 1,<br>-Гаалийн албанаас халах 1.<br>Гомдол мэдээлэл, шалгагдсан албан хаагч, сахилгын хороонд шилжүүлсэн албан хаагч, сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчдын тоог өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.<br><table><tr><th>Төрөл</th><th>2024.06</th><th>2025.06</th><th>Хувь</th></tr><tr><td>Гомдол, мэдээллийн тоо</td><td>32</td><td>25</td><td>21.8</td></tr><tr><td>Шалгагдсан албан хаагч</td><td>85</td><td>36</td><td>57.6</td></tr></table></td>
<td rowspan="2"></td>
</tr>
<tr>
<td>2.ГЕГ-ын ЗБББНДБ, харьяа гаалийн газар, хороодын гэмт хэрэг зөрчилд холбогдсон, сахилга ёс зүйн зөрчил гаргасан нийт 38 албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан бол үүнээс 18 албан хаагчийн үйлдлийг ГЕГ-ын сахилгын хороогоор хэлэлцүүлэн хариуцлага тооцсон.</td>
<td>2.Гаалийн албан хаагчдын сахилга, ёс зүйн зөрчилд хариуцлага тооцсон байна.</td>
</tr>
</table>

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td><table><tr><td>Сахилгын хороонд шилжүүлсэн</td><td>25</td><td>16</td><td>36</td></tr><tr><td>Сахилгын шийтгэл ногдуулсан</td><td>9</td><td>13</td><td>44.4</td></tr></table>1. 100 хувь “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн.<br>2. 100 хувь “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн.<br><br>Дундаж 100 хувь</td><td></td></tr>
<tr><td>2.4</td><td>Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод аудит хийж, холбогдох зөвлөмжийг хүргүүлнэ.</td><td>Үйл ажиллагаа</td><td>Хэрэгжилт, хувиар</td><td>1.2024 онд 6 дотоод аудит гүйцэтгэсэн.<br>2.Дотоод аудитын үр дүнгээр нийт 90 зөвлөмжийг хүргүүлснийг эргэн хянаж дүгнэхэд 74.74 хувиар үнэлэгдсэн.<br>3.Дотоод аудитын гүйцэтгэлийг ОУ-ын стандартад нийцүүлэх зорилгоор анх удаа чанарын үнэлгээг зохион байгуулан “Хэсэгчлэн нийцсэн” дүгнэлт авсан.</td><td>1.Нийт дараах нэгжийн үйл ажиллагаанд дотоод аудит хийнэ. Үүнд:<br>-Татвар орлогын газар,<br>-Статистик, дүн шинжилгээний хэлтэс,<br>-Хуулийн хэлтэс,<br>-Мэдээллийн технологийн газар,<br>-Улаанбаатар хот дахь гаалийн газар,<br>-Замын-Үүд дэх гаалийн газар,<br>-Улс хоорондын шуудан илгээмж дэх гаалийн газар,<br>-Увс аймаг дахь гаалийн газар.<br>2. Дотоод аудит хийсэн нэгж, газар хороодод тайлан, зөвлөмжийг хүргүүлэн, эргэн хянаж, хэрэгжилтийг хангуулна.<br>3.Өмнөх 2023, 2024 онуудад аудит хийгдсэн нэгж, байгууллагуудыг хамруулсан чанарын</td><td>1.2025 оны эхний хагас жилд 4 аудит гүйцэтгэсэн. Үүнд:<br>-№2025-01 дугаартай удирдамжийн дагуу Сэлэнгэ аймаг дахь гаалийн газарт гүйцэтгэлийн аудитын 2025 оны 01 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд хийж гүйцэтгэж үр дүнг Гаалийн ерөнхий газрын Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн хэрэгжилт хангалтгүй 4 зөвлөмжийг тус газарт албан бичиг болон Захиргаа, дотоод ажлын систем программаар хүргүүлсэн.<br>-Гаалийн ерөнхий газрын даргын баталсан №2025/02 дугаартай удирдамжийн дагуу Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газарт 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 04 дүгээр сарын 02-ны өдрүүдэд дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн. Аудитын үр дүнгээр нийт 12 асуудал илэрч, “Сайжруулалт шаардлагатай” гэж дүгнэн үр дүнг Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хуралдааны шийдвэрээр холбогдох 12 зөвлөмжийг хүргүүлэхийн өмнө зөвлөмж өгөх Гаалийн ерөнхий газрын нэгжүүдтэй холбогдож, хэрэгжүүлэх боломжит хугацааг тодорхойлсны дараа зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд Хяналт, бүрдүүлэлтийн газар болон Мэдээллийн технологийн газарт шуудангийн манифесттай холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжит хугацааг тооцон ирүүлэх талаар дотоод зурвасыг хүргүүлсэн. Дотоод зурвасын хариуг ирсний дараа зөвлөмжүүдийг дахин нэмэлт өөрчлөлт оруулан удирдлагад танилцуулан холбогдох нэгж болон Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газарт хүргүүлнэ.</td><td>90</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үнэлгээг зохион байгуулсан байна. | -Гаалийн ерөнхий газрын даргын баталсан №2025/03 дугаартай удирдамжийн дагуу Хуулийн хэлтсийн 2024 он болон 2025 оны нэгдүгээр улирлын үйл ажиллагаанд дотоод аудитыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 05 дугаар сарын 14-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Аудитын үр дүнгээр нийт 9 асуудал илэрч “Сайжруулалт шаардлагатай” гэж дүгнэсэн. Аудитын тайланг Гаалийн ерөнхий газрын Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх хугацаа болоогүй байгаа бөгөөд холбогдох зөвлөмжийг боловсруулан тайланд тусган бэлэн болгосон. Тайлан Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэгдсэний дараа зөвлөмжийг баталгаажуулан хүргүүлнэ.<br>-Гаалийн ерөнхий газрын даргын баталсан №2025/04 дугаартай удирдамжийн дагуу Татвар орлогын газрын 2023 он болон 2024 оны үйл ажиллагаанд дотоод аудитыг 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 05 дугаар сарын 05-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Аудитын үр дүнгээр нийт 11 асуудал илэрч “Сайжруулалт шаардлагатай” гэж дүгнэсэн. Аудитын тайланг Гаалийн ерөнхий газрын Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх хугацаа болоогүй байгаа бөгөөд холбогдох 28 зөвлөмжийг боловсруулж, тайланд тусган бэлэн болгосон. Тайлан Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэгдсэний дараа зөвлөмжийг баталгаажуулан хүргүүлнэ.<br>-Статистик дүн шинжилгээний хэлтэс, Мэдээллийн технологийн газар, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Замын-Үүд дэх гаалийн газар, Увс аймаг дахь гаалийн газарт хийгдэх дотоод аудит сүүлийн хагас жилд төлөвлөгдсөн.<br>2.Сэлэнгэ аймаг дахь гаалийн газарт хийгдсэн гүйцэтгэлийн аудитын үр дүнгээр хэрэгжилт хангалтгүй 4 ажлын холбогдох зөвлөмжийг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 01-4/1435 албан бичгээр болон Захиргаа, дотоод ажлын систем программаар хугацаатай хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх хугацаа болоогүй.<br>Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газарт хийгдсэн аудиттай холбоотой зөвлөмжийн хугацааг нарийвчлан тодорхойлохоор Хяналт, бүрдүүлэлтийн газар, Мэдээллийн технологийн газарт дотоод зурвас хүргүүлсэн бөгөөд хариу ирсний дараа зөвлөмжүүдийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар болон Мэдээллийн технологийн газар, Хяналт, бүрдүүлэлтийн газарт хүргүүлнэ.<br>Хуулийн хэлтэс болон Татвар, орлогын газарт хийгдсэн аудитын үр дүн Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэгдэж баталгаажаагүй байгаа тул зөвлөмжүүдийг хүргүүлээгүй байна.<br>3.Гаалийн байгууллагын хэмжээнд 2023, 2024 онд дотоод аудитад хамрагдсан Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодын албан хаагчдаас дотоод аудитын талаар тодорхой ойлголттой албан хаагчдыг сонгон, Чанарын үнэлгээний багийн бүрэлдэхүүнд оруулах боломжтой хүний нөөцийн судалгааг гарган ажиллаж байна. Уг судалгаанд үндэслэн Чанарын үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг бүрдүүлж, 2025 оны сүүлийн хагас жилд чанарын үнэлгээг зохион байгуулахаар төлөвлөсөн болно.<br>1. **90** хувь зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн.<br>2. **90** хувь зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн.<br>3. 3-р арга хэмжээний хугацаа болоогүй.<br><br>Дундаж **90** хувь. | |
| 2.5 | Нийгмийн эрүүл мэндийн аюулгүй байдлын өөрийн үнэлгээний аргачлалыг боловсруулж батлуулан, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагаа | Үнэлгээний аргачлал Өөрийн үнэлгээ хийгдсэн боомтын тоо Үнэлгээний тайлан | 2023 онд ДЭМБ-ын хөндлөнгийн шинжээч нарын хийсэн үнэлгээний тайлан | Үнэлгээний аргачлал -1 Олон улсын шинжтэй автозамын 2 боомт, хоёр талын шинжтэй автозамын 2 боомт, олон улсын агаарын хилийн 1 боомт-Нийт 5 боомт<br>Үнэлгээний тайлан-1 | ДЭМБ-ын хөндлөнгийн шинжээч нарын үнэлгээний аргачлалд үндэслэн үндэсний хэмжээний хилийн боомтуудыг үнэлэх асуумж боловсруулан 2025 оны 04 сарын 28-ны өдөр ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн мэргэжилтнүүдийн түвшинд хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн дунд гарсан санал зөвлөмжийг тусган нийт 95 асуулт бүхий асуумжийг нэгтгэж, 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 02-1.2/1889, 1890, 1891, 1892, 1893 дугаартай албан бичгээр Замын-Үүд дэх гаалийн газар, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Сэлэнгэ дэх гаалийн газар, Ханги дахь гаалийн газар, Завхан аймгийн Арцсуурь дахь гаалийн хороо руу хүргүүлсэн. Замын-Үүд, Чингис хаан, Ханги боомтуудад “Хилийн нэвтрэх цэгийн нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ авах, үйл явдлыг илрүүлэх, эрт сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд стратегийн эрсдэлийн үнэлгээ”-г | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ХӨСҮТ, ЗӨСҮТ, ОБЕГ, ДЭМБ-тай хамтран 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулсан. Эрсдэлийн үнэлгээгээр Ханги боомт 64,5 хувь буюу 3-р түвшинд, Замын-Үүд боомт 77,3 хувь буюу 4-р түвшинд, Чингис хаан боомт 70,3 хувь буюу 4-р түвшинд тус тус үнэлэгдсэн. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавхын хувьд Ханги боомт нь чадавхжиж байгаа, Замын-Үүд боомт, Чингис хаан боомтууд нь чадавхтай гэж үнэлэгдсэн. Үнэлгээний дүнд цаашид тухайн боомтын чадавхыг сайжруулах зөвлөмжийг боловсруулж, 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 02/2347, 02/2348, 06 дугаар сарын 21-ний өдрийн 02/2620 албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>Үлдсэн боомтуудын үнэлгээг 2025 оны сүүлийн хагас жилд багтаан хэрэгжүүлэхээр ажиллаж байна.<br><br>**90** хувь зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн. | |
| 2.6 | Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт | Үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хууль хяналтын байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож гаалийн хяналтын бүст хяналт шалгалтын ажил зохион байгуулж АНУ, Вьетнам, Англи, Малайз зэрэг орнуудаас улс хоорондын шуудан илгээмж ашиглан хууль бусаар | 1. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хууль хяналтын байгууллагуудтай 2025 оны хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, харьяа гаалийн газар хороодын байцаагч нарыг мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан байна. | Тайлант хугацаанд хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан дараах 13 удаагийн үйлдлийг таслан зогсоож, эзэн холбогдогч болон нотлох баримтын хамт эрх бүхий байгууллагуудад харьяаллын дагуу шилжүүлэн өгөхтэй холбоотой зөвлөмж, чиглэлээр харьяа гаалийн газар, хороодын ханган ажилласан.<br>1.Делта-9 THC Дроп – 8 шилэн бортого буюу 24 мл /Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу тухайн илгээмжид дүн шинжилгээ хийхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1 дэх заалтыг үндэслэн илгээмжийг эзэнд нь олгуулахаар тагнуулын байгууллагатай хамтран ажиллаж, илгээмж хүлээн авагчийг Монгол таун карго компанийн байрнаас дайчлан баривчилсан./<br>2.Метамфетамин – 89.11 грамм (Чингисхаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын) /Тагнуулын байгууллагаас ирүүлсэн мэдээллийн дагуу тус байгууллагын алба хаагчидтай хамтран Истанбул-Улаанбаатар чиглэлийн нислэгээр зорчин ирсэн зорчигчийн гар тээш, дагалдах ачаанд хяналт шалгалт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан 14 удаагийн үйлдлийг таслан зогсоож, эзэн холбогдогч болон нотлох баримтын хамт эрх бүхий байгууллагуудад харьяаллын дагуу шилжүүлж өгсөн. | | явуулахад тухайн зорчигчийн дагалдах ачаанаас шоколадны уутанд нуун далдалсан 89.11 грамм Мөс буюу Метамфетаминыг илрүүлсэн бөгөөд Тагнуулын байгууллагад хүлээлгэн өгсөн./<br>3.Каннабис – 33 грамм (Чингисхаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын) /Гаалийн автоматжуулсан удирдлагын систем (CAIS)-ын Эрсдэлтэй зорчигчийн санд бүртгэлтэй иргэн Бангкок-Улаанбаатар чиглэлийн нислэгээр зорчин ирсэн бөгөөд тухайн иргэнийг нягтлан шалгах чиглэлийг Чингисхаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын Зөрчилтэй тэмцэх албанд өгсөн. Хяналт шалгалтын ажиллагааг явуулахад тус иргэний гар тээшнээс Каннабис илэрсэн ба харьяаллын дагуу цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгсөн. /<br>4.Фенобарбитал – 200 ширхэг /Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын Зөрчилтэй тэмцэх албанаас ХБНГУ-аас ирсэн зорчигчийн ачаанаас үл мэдэгдэх эм гарч ирлээ гэсэн мэдээллийн дагуу нягтлан шалгахад Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны конвенцийн дөрөвдүгээр хавсралтад багтсан фенобарбитал гэх бодис байсан тул харьяаллын дагуу цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгсөн. /<br>5.Делта-9 THC Дроп – 12 шилэн бортого буюу 36 мл /Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу тухайн илгээмжид дүн шинжилгээ хийхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1 дэх заасан заалтыг үндэслэн илгээмжийг эзэнд нь олгуулахаар тагнуулын байгууллагатай хамтран ажиллаж, илгээмж хүлээн авагчийг Монгол таун карго компанийн байрнаас дайчлан баривчилсан./<br>6.Делта-9 THC Дроп – 7 шилэн бортого буюу 21 мл /Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу тухайн илгээмжид дүн шинжилгээ хийхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1 дэх заалтыг үндэслэн илгээмжийг эзэнд нь олгуулахаар тагнуулын байгууллагатай хамтран ажиллаж, илгээмж хүлээн авагчийг Монгол таун карго компанийн байрнаас дайчлан баривчилсан./ | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 7.Делта-9 THC Vape – 5 мл /Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу тухайн илгээмжид дүн шинжилгээ хийхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1 дэх заалтыг үндэслэн илгээмжийг эзэнд нь олгуулахаар тагнуулын байгууллагатай хамтран ажиллаж, илгээмж хүлээн авагчийг Монгол таун карго компанийн байрнаас дайчлан баривчилсан./<br>8.Хашиш – 100 грамм /Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу тухайн илгээмжид дүн шинжилгээ хийхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1 дэх заалтыг үндэслэн илгээмжийг эзэнд нь олгуулахаар тагнуулын байгууллагатай хамтран ажиллаж, илгээмж хүлээн авагчийг Монгол таун карго компанийн байрнаас дайчлан баривчилсан./<br>9.Хашиш – 840 грамм /Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу тухайн илгээмжид дүн шинжилгээ хийхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1 дэх заалтыг үндэслэн илгээмжийг эзэнд нь олгуулахаар цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж, илгээмж хүлээн авагчийг дайчлан баривчилсан./<br>10.Метамфетамин – 510 грамм (Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар) /Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн мэдээллийн дагуу хамтарсан хяналт, шалгалтын арга хэмжээг хэрэгжүүлж Лаос Улсаас БНСУ-аар дамжин ирсэн зорчигчийн дагалдах ачааг рентген төхөөрөмжөөр оруулан шалгахад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1 дэх заалтыг үндэслэн дагалдах ачааг эзэнд нь олгуулж цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж, илгээмж хүлээн авагчийг дайчлан баривчилсан./<br>11.Каннабис – 0.39 грамм (Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар) /Тагнуулын байгууллагаас ирүүлсэн мэдээллийн дагуу тус | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын алба хаагчидтай хамтран Истанбул-Улаанбаатар чиглэлийн нислэгээр зорчин ирсэн зорчигчийн гар тээш, дагалдах ачаанд хяналт шалгалт явуулахад тухайн зорчигчийн гар тээшнээс 0.39 грамм Каннабис гэх бодисыг илрүүлсэн бөгөөд Тагнуулын байгууллагад хүлээлгэн өгсөн./<br>12.Делта-9 THC агуулсан охь – 250 мл /Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу тухайн илгээмжид дүн шинжилгээ хийхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1 дэх заалтыг үндэслэн илгээмжийг эзэнд нь олгуулахаар тагнуулын байгууллагатай хамтран ажиллаж, илгээмж хүлээн авагчийг Монгол Шуудан ХК-ийн 19-р салбараас дайчлан баривчилсан./<br>13.Хашиш – 180 грамм /Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу тухайн илгээмжид дүн шинжилгээ хийхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1 дэх заалтыг үндэслэн илгээмжийг эзэнд нь олгуулахаар тагнуул, цагдаагийн байгууллагуудтай хамтран ажиллаж, илгээмж хүлээн авагчийг Монгол Шуудан ХК-ийн 25-р салбараас дайчлан баривчилсан./<br>Энэ төрлийн хэрэг, зөрчил илрүүлэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 55 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br><br>**100** хувь “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 2.7 | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр алба хаагчдад мэдлэг, мэдээлэл олгох замаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх | Үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Гаалийн байгууллагын хэмжээнд 2024 оны байдлаар бэлэн мөнгө /валют/-ийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан 384.5 сая төгрөгтэй тэнцэх | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр алба хаагчдад сургалт зохион байгуулж энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн ойлголт, мэдлэг мэдээлэлтэй болгох замаар хууль бус үйлдлийн | Тайлант хугацаанд Бэлэн мөнгө (валют)-тай холбоотой 2 удаагийн зөрчлийн үйлдлийг илрүүлсэн. Үүнд:<br>1.2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Вьетнам улсын иргэн 15,000 доллар буюу (51.3 сая төгрөгтэй тэмцэх хэмжээний валютыг)-ийг гаальд мэдүүлэхгүйгээр улсын хилээр авч орохыг завдсан зөрчлийг илрүүлж гаалийн байгууллагад мэдүүлээгүй зөрчилд холбогдсон бараа болох 15,000 америк долларыг улсын орлогод хураах, 7,688,947.50 төгрөгийн торгууль ногдуулж шийдвэрлэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэмжээний үнийн дүн бүхий зөрчлийн 2 удаагийн үйлдлийг илрүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан. Шүүхийн шийдвэрээр зөрчилд холбогдох 333.2 сая бэлэн мөнгө /валют/ буцаан олгогдсон байна. | илрүүлэлтийг нэмэгдүүлэх, мэргэжил арга зүйгээр тогтмол хангаж ажиллана. | 2.2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр БНХАУ-ын иргэн 60,000 юань буюу (28.5 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний валют)-ийг гаальд мэдүүлэхгүйгээр улсын хилээр авч орохыг завдсан зөрчлийг илрүүлж, 4.2 сая төгрөгөөр торгож, хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн.<br>-Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Үндэсний зөвлөлийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/04 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-149 дэх ажлын хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх чиглэлээр “Гаалийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн-2025” арга хэмжээний үеэр Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хороод болон зөвлөгөөнд оролцогч нарт улсын хилээр нэвтэрч буй бэлэн мөнгө (валют)-ийн гаалийн хяналт, шалгалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар зөвлөмж, арга зүйн зөвлөгөөг өгсөн.<br>Мөн ГЕГ-ын 2019 оны А/223 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журамд” заасны дагуу 15 сая төгрөгөөс дээш хэмжээгээр хилээр нэвтрүүлж буй бэлэн мөнгө (валют)-ийг хилээр нэвтрэх зорчигчид зайлшгүй гаалийн байгууллагад мэдүүлэх үүрэгтэй гэдгийг алба хаагч нар нэг мөр ойлгох талаар зөвлөмж, арга зүйгээр хангаж ажиллаж байна.<br><br>**100** хувь “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 2.8 | Гаалийн мэдээллийн системүүдийг боловсронгуй болгож, мэдээллийн сүлжээний аюулгүй байдлыг бий болгох | Үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Захиргаа дотоод ажлын системд ЗББНДБ-ын програмын даалгаврын дагуу 11 удаагийн нэмэлт хөгжүүлэлт болон засвар өөрчлөлтүүдий | 1. ЗДАС, иДок зэрэг дотоод ажлын системүүдэд нэмэлт хөгжүүлэлт болон засвар өөрчлөлтүүдийг ЗББНДБ-ын дотоод зурвасын дагуу хийж гүйцэтгэнэ.<br>2. Гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааны | 1.Захиргаа дотоод ажлын системд 16, edoc системд 6 удаагийн нэмэлт хөгжүүлэлт болон засвар өөрчлөлтүүдийг хийж гүйцэтгэсэн.<br>2.Гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагааны системүүдэд шинэчлэх, сайжруулах хөгжүүлэлтийг хийх ажлын хүрээнд CAIS системд 48, gaali.mn, CEPS системд 6 удаагийн засвар өөрчлөлт, нэмэлт хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.<br>3.Гаалийн байгууллагын мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагаа, нууцлал, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | г хийж гүйцэтгэсэн.<br>2. Гаалийн автоматжуулсан мэдээллийн системийг шинэчлэх, сайжруулах хөгжүүлэлтийг хийх ажлын хүрээнд 67 удаагийн засвар өөрчлөлт, нэмэлт хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.<br>3. Систем, сүлжээ, серверүүдэд мониторинг хийх, тасралтгүй хэвийн найдвартай ажиллагаа, нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд 7 удаагийн засвар өөрчлөлтийг хийсэн. 2014 оноос хойш шинэчлэл хийгдээгүй байсан сүлжээний дэд | системүүдэд шинэчлэх, сайжруулах хөгжүүлэлтийг ЗББНДБ-ын дотоод зурвасын дагуу хийж гүйцэтгэнэ.<br>3. Гаалийн байгууллагын мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагаа, нууцлал, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах<br>4. Дата төвийн өргөтгөл шинэчлэл, хэвийн найдвартай ажиллагааг хангах | - Гаалийн байгууллагын дата төвийн сүлжээ болон серверийн аюулгүй байдал, шинэ сервер тоног төхөөрөмжийн судалгааг хийж, 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт, Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл” -ийн хүрээнд сервер болон сүлжээний тоног төхөөрөмжийг худалдан авах ажлыг зохион байгуулж, ажилласан. Дата төвд шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр “Саммит компьютер технологи ХХК” шалгарсан бөгөөд тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг эхлүүлэн ажиллаж байна.<br>- Дата төвийн системийн кибер аюулгүй байдлын талаарх дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.<br>- Домэйн нэрийн удирдлагын системийг 2008 оны хувилбараас дээшлүүлж 2012 оны хувилбарт шилжүүлснээр хэт амархан тайлагдаж болох нууцлал шифрлэлт SSL v1.0 SSL v2.0 SSL v3.0 TLS v1.0 ашиглан өгөгдөл солилцохоос үүдэн системийн эмзэг байдал бий болохоос сэргийлсэн.<br>- Мөн уг домэйн нэрийн модуль контроллерийн хувилбарыг дээшлүүлж, 2019 оны багц нууцлал шифрлэлт TLS v1.3 AES256 SHA256 хувилбарт шилжүүлэхээр тохируулга туршилтыг хийж ажилласан.<br>4.Дата төвийн өргөтгөл шинэчлэл, сүлжээ, сервер тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах ажлын хүрээнд шинээр Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 17, 2025 оны улсын төсвийн хөрөнгөөр 16 ширхэг сүлжээний төхөөрөмж, серверийг худалдан авч, суурилуулсан.<br><br>**100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүтцийг бүрэн сольж, сүлжээний 12, сервер 2, нийт 32 тоног төхөөрөмжийг шинээр суурилуулсан. Гаалийн 21 газар хороод болон 160 хяналтын бүс, баталгаат агуулах, чөлөөт бүсүүдийн сүлжээний тохиргоог шинэчлэн хийж хэвийн ажиллагаанд оруулсан.<br>Дата төвийн өргөтгөл шинэчлэл, хэвийн найдвартай ажиллагааг хангах ажлын хүрээнд 7 удаагийн засвар үйлчилгээг хийж, Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраар 2024.02.26-2024.03.01-ны хооронд Гаалийн байгууллагын нэгдсэн сүлжээ болон Дата төвд Кибер аюулгүй байдлын | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн. | | | |
| 3 | Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | | | | | | |
| 3.1 | Улсын төсвийн гаалийн орлогыг хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй бүрдүүлнэ. | Үйл ажиллагаа | Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт төгрөгөөр, хувиар | Гаалийн байгууллага нь 2024 онд 6792.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс Улсын төсөвт нийт 6743.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 99.3 хувийн биелэлттэй байна. Орлогын төлөвлөгөөний биелэлт тус бүрээр авч үзвэл.<br>-Татварын орлого 6642.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 6583.1 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.2 хувиар өссөн.<br>-Хураамжийн орлого 135.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 146.3 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.5 хувиар өссөн.<br>-Өөрийн орлого 15.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 13.8 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлж өнгөрсөн оны мөн үетэй | Төсвийн тухай хуульд заасан гаалийн байгууллагын улсын төсөвт оруулах 7872.5 тэрбум төгрөгийн орлогын төлөвлөгөөг биелүүлсэн байна. Гүйцэтгэл 100 хувьтай байна. | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар гаалийн байгууллага нь 7.87 их наяд төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх үүрэг хүлээсэн. 2025 оны эхний 6 сарын байдлаар 3635.98 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 3358.0 тэрбум төгрөг төвлөрүүлж 92.4 хувийн явцтай. Үүнээс:<br>-Татварын орлого 3557.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 3284.2 тэрбум төгрөг төвлөрүүлж 92.3 хувь,<br>-Хураамжийн орлого 67.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 65.2 тэрбум төгрөг төвлөрүүлж 97.0 хувь,<br>-Өөрийн орлого 11.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 8.6 тэрбум төгрөг төвлөрүүлж 78.4 хувийн тус тус явцтай байна.<br>Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 302.27 тэрбум төгрөгөөр буюу 10.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>Гаалийн болон НӨАТ-ын орлого импортын хэмжээ, бүтэц, гаалийн үнэлгээнээс шууд хамаардаг. Импорт буурч, чингэлгийн тоо буурсан, уул уурхайн хамаарах бараа /шатахуун/-ны импорт буурахын зэрэгцээ, БНХАУ-ын арматур, барилгын бүтээц төмрийн зах зээлийн үнэ буурснаар орлогын гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэв.<br>Улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:<br>1.Гаалийн байгууллага нь улсын төсвийн орлогын гүйцэтгэлийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч, нэмэлтээр 103.3 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Үүнд:<br>-Эрсдэлтэй бараа, байгууллагыг нарийвчлан судалж, хяналтыг эрчимжүүлсэн.<br>-Буруу үнэлгээ, гаалийн зөрчил, зардлын дутуу тайлагналтай холбоотой нөхцөл байдлыг засварласан.<br>-Бүрдүүлэлтийн хяналт, гүйцэтгэлийн хяналтыг давхаржуулсан.<br>-Автозамын хилийн боомт дээр суурилагдсан рентгений ашиглалтыг сайжруулж, хилээр ачаатай нэвтэрсэн барааны 90 гаруй хувийг рентгений хяналтад бүрэн хамруулсан. | 93 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | харьцуулахад 1414.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн буюу 26.5 хувийн өсөлттэй байна. | | -Гаалийн газар, хороодын гаалийн хяналтын бүс, талбай, гаалийн баталгаат агуулах зэрэгт хугацаа хэтэрсэн, гаалийн горимд байршуулаагүй бараанд тавих хяналтыг сайжруулсан.<br>-Бүрдүүлэлтийн цахим төвийн бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч нарын гаалийн үнэлгээг дахин бууруулах замаар татварын орлогыг бууруулж байгааг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлд холбогдох ажлыг хийж эхэлсэн.<br>-Гаалийн бүрдүүлэлтийн түр "500" горимд байршуулсан барааны гаалийн үнийн хяналт, хугацаанд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр заавар, зөвлөмж өгсөн.<br>2.Бүрдүүлэлтийн цахим төвийн бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч нар “Бичиг баримтын шалгалт хийгдсэн” төлөвийн дараа барааны үнийг бууруулан давхар нэхэмжлэх үүсгэж, нийт 7192 мэдүүлэгт 247.8 тэрбум төгрөгийн орлогын алдагдал үүсгэсэн талаарх судалгааг хийсэн. Иймд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар Татвар орлогын газраас санал болгож байна. Үүнд:<br>-“Давхар нэхэмжлэх” үүсгэх боломжийг CAIS системд хаах.<br>-Үнэлгээтэй холбоотой журам, зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах.<br>-Гомдол, хүсэлтийг цахимаар шийдвэрлэж, системд шийдвэрийн мэдээллийг оруулах зохицуулалт хийх.<br>Эдгээр арга хэмжээ нь улсын төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.<br>Мөн ГЕГ-ын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 02-2/809 албан бичгээр Замын-Үүд дэх гаалийн газарт танилцуулгыг хүргүүлсэн.<br>3.Гаалийн ерөнхий газраас газар, хороодын орлогын гүйцэтгэлийг сар бүр хянаж, татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг шахах, зохион байгуулалтын арга хэмжээ авах зорилгоор төлөвлөгөөг албан бичгээр хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.<br>4.Гаалийн байгууллага нь Төсвийн орлогын гүйцэтгэлийг 7 хоног бүр мэдээлэх зорилгоор Сангийн яамны Төсвийн бодлогын газрын Орлогын хэлтэст тогтмол тайлан хүргүүлж, танилцуулж байна.<br>5.“Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулах тухай” Сангийн сайдын 2024 оны 22 дугаар тушаалын дагуу авч | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжүүлсэн ажлын тайланг 2024 оны жилийн эцсээр гаргаж, 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02/214 албан бичгээр хүргүүлсэн.<br>6.Сангийн сайдын 2025 оны 18 дугаар тушаалаар батлагдсан "Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний дагуу төлөвлөгөөний биелэлтийг мөн хүргүүлсэн.<br>Гүйцэтгэл тасарсан шалтгаан, нөлөөлөл:<br>Татварын орлогын дийлэнхийг бүрдүүлдэг гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татварын биелэлт нь татвартай бараа, бүтээгдэхүүний импортын хэмжээ, барааны бүтэц, гаалийн үнэлгээтэй шууд хамааралтай.<br>Эхний 5 сарын гүйцэтгэлээр татварын орлого тасрахад дараах гадаад болон дотоод хүчин зүйлүүд нөлөөлсөн:<br>-Гадаад улс орны эдийн засгийн савлагаа, тарифын өөрчлөлт, худалдааны тодорхой бус байдал нь манай улсын экспортод суурилсан импортод сөргөөр нөлөөлсөн. Мөн Тяньжин боомтын чингэлгийн тоо өмнөх оны мөн үеэс 1425-1500 чингэлгээр буурч, төмөр замын тээвэрлэлт саарсан.<br>-Уул уурхайн хамааралтай тоног төхөөрөмж, машин механизмын импорт багассан.<br>-Барилгын гол нэрийн материал болох арматурын БНХАУ дахь зах зээлийн үнэ буурсан нь дотоод үнэд мөн нөлөөлж, татварын суурийг бууруулсан.<br>-Автобензин, дизель түлшний импорт тогтворгүй, хэмжээ багатай байна. Иймд уг төрлийн татварууд (ОАТ болон албан татвар) төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй.<br><br>**93** хувь “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй үр дүн гарч эхэлсэн. | |
| 3.2 | Өгөгдлийн дүн шинжилгээ, их өгөгдөл, хиймэл оюун ухаан зэрэг дэвшилтэт технологийг ашиглана. | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | Tableau программыг ашиглан дараах дашбоардуудыг боловсруулж, сервер дээр байршуулж, тайлан мэдээнд дүн шинжилгээ | -Их өгөгдөлд суурилсан Гааль-360 дашбоард хөгжүүлэх;<br>-Хиймэл оюу ухаанд суурилсан БТКУС санал болгох систем хөгжүүлэх;<br>-Хиймэл оюу ухаанд суурилсан автомат | Их өгөгдөлд суурилсан Гааль-360 дашбоард хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>- Татвар орлогын гүйцэтгэлийн мэдээ,<br>- Бараа эргэлтийн тайлан,<br>- Хилийн хөдөлгөөний мэдээ,<br>- Экспортын статистик мэдээ,<br>- Импортын статистик мэдээ,<br>- Орлогын дүн шинжилгээ,<br>- Бүрдүүлэлтийн цахим төвийн өдөр тутмын мэдээ,<br>- Татвар орлогын хөнгөлөлт, чөлөөлөлт, хойшлуулалт. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хийх боломжийг бүрдүүлсэн.<br>- Гаалийн орлогын гүйцэтгэлийн мэдээ<br>- Бараа эргэлтийн тайлан<br>- Хилийн хөдөлгөөний мэдээ<br>- Экспортын статистик мэдээлэл<br>- Импортын статистик мэдээлэл | хариулагч /Чатбот/ хөгжүүлэх; | Туршилтаар зарим барааны ангиллын код тодорхойлох магадлалын хувь буруу байгааг илрүүлэн дахин сайжруулах, мөн эхний ээлжид хэрэгжиж эхлээд буй улсын чанартай 6 мега төслийн хүрээнд импортолсон 4850 барааны мэдээллийн сан үүсгэн платформыг сайжруулах чиглэлээр ажилласан. Хиймэл оюунд суурилсан БТКУС санал болгох системийн туршилтын хувилбарыг хийж, http://hs.ecustoms.mn/ байршуулсан. Хиймэл оюунд суурилсан БТКУС санал болгох системийн туршилтын хувилбарыг нэвтрүүлсэн боловч БТКУС код хайхад үр дүн хангалтгүй, өөр БТКУС-ийг санал болгож байсан. Энэ нь тухайн сонгосон модель(Doc2Vec) нь Монгол хэл дээрх текстийг сайн танихгүй байх магадлалтай байсан. Иймээс ашиглаж буй моделийг сайжруулах зорилгоор Монгол хэлтэй хамтран ажиллах BERT, Xboost сангуудыг ашиглан машин сургалтын моделийг шинээр үүсгэх хөгжүүлэлт хийн, туршилт хийж байна.<br>Гаалийн цахим үйлчилгээний систем (www.gaali.mn) сайтад байршуулсан Хиймэл оюу ухааны чатботыг сайжруулан сургах зорилгоор, Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудаас нэмэлт санал, авсан. Саналыг нэгтгэн нийт 166 асуулт, хариултаар чатботыг дахин сурган сайжруулсан. Гаалийн цахим үйлчилгээний www.gaali.mn системд AI chatbot-г нэвтрүүлсэн. Мөн Гаалийн ерөнхий газрын гаалийн хяналт, бүрдүүлэлтийн газраас 2025-нд нэмэлт асуулт ирүүлснээр чатботыг сургаж, сайжруулалт хийсэн.<br><br>**100** “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 3.3 | Цахим гарын үсгийг гаалийн байгууллагын хэмжээнд нэвтрүүлнэ. | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | 1. ГЕГ-ын дарга, ахлахууд болон 5 харьяа гаалийн газар хороодын албан хаагчдыг тоон гарын үсэгтэй болгож тоон гарын үсгийг гаалийн мэдээллийн систем рүү нэвтрэх, бичиг | 1. 14 харьяа гаалийн газар хороодын дарга, гаалийн улсын ахлах байцаагч, хяналт шалгалт, бичиг баримтын байцаагч нарыг тоон гарын үсэгтэй болгож тоон гарын үсгийг гаалийн мэдээллийн системд ашиглах | 1.14 харьяа гаалийн газар хороодын дарга, гаалийн улсын ахлах байцаагч, хяналт шалгалт, бичиг баримтын байцаагч нарыг тоон гарын үсэгтэй болгож, тоон гарын үсгийг гаалийн мэдээллийн системд ашиглах боломжийг бүрдүүлсэн. Нийт 167 шинэ тоон гарын үсэг үүсгэж суулгасан, 284 тоон гарын үсгийг сунгасан, 75 албан хаагчийн алдаатай тоон гарын үсгийг зассан байна. | 85 |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>баримтыг үнэлэх, хяналт, шалгалт хийх, зөвшөөрөл өгөх үйлдлүүд болон гаалийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашиглах боломжийг бүрдүүлсэн.<br>2. Төрийн болон төрийн бус хувийн 4000 гаруй байгууллагуудтай тоон гарын үсэг ашиглан тоон гарын үсгээрээ баталгаажуулалт хийж цахимаар албан бичиг солилцохыг бүрэн нэвтрүүлсэн.<br>ОУ-н автозамын холбоо IRU-тай ТИР карнейн урьдчилсан мэдээллийг цахимаар солилцох сервис хөгжүүлэлтэд нууцлал, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад тоон гарын үсгийн токен ашигласан.</td>
<td>боломжийг бүрдүүлнэ.<br>2. Албан бичиг хэрэг хөтлөлтийн edoc системд тоон гарын үсгийг ашиглана.</td>
<td>
<table>
<tr><th>Байгууллагын нэр</th><th>Шинэ үүсгэсэн</th><th>Сунгасан</th><th>Алдаа зассан</th><th>Хүлээлгэн өгсөн</th><th>Хүлээгдэж буй</th></tr>
<tr><td>ЗҮГГ, БЦТ</td><td>80</td><td>–</td><td>–</td><td>80</td><td>–</td></tr>
<tr><td>ГСГГ, ШХГГ</td><td>–</td><td>–</td><td>–</td><td>–</td><td>20</td></tr>
<tr><td>УХШИГГ, ЗҮГГ</td><td>–</td><td>99</td><td>–</td><td>99</td><td>–</td></tr>
<tr><td>ГЕГ-ын ГУАБ</td><td>23</td><td>–</td><td>–</td><td>23</td><td>–</td></tr>
<tr><td>УБГГ</td><td>35</td><td>35</td><td>75</td><td>145</td><td>–</td></tr>
<tr><td>ЧХОУНБГГ</td><td>–</td><td>150</td><td>–</td><td>25</td><td>125</td></tr>
<tr><td>Орхон ГГ</td><td>25</td><td>–</td><td>–</td><td>25</td><td>–</td></tr>
<tr><td>Бичигт (Сүхбаатар)</td><td>4</td><td>–</td><td>–</td><td>4</td><td>баталгаажуулалт хийгдэх</td></tr>
</table>
2.Албан бичиг хэрэг хөтлөлтийн edoc системд тоон гарын үсгийг ашиглана.<br>2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс тоон гарын үсгийг edoc системд албан ёсоор нэвтрүүлж, ГЕГ-ын 27 дарга, гаалийн улсын ахлах байцаагч 18, Газар хороодын дарга, албаны дарга 25, гаалийн улсын ахлах байцаагч 11, нийт 81 албан хаагч нар тоон гарын үсгээр баталгаажуулалт хийн Төрийн болон хувийн 3500 гаруй байгууллага руу цахимаар бичиг солилцож байна.<br><br>1. 70 хувь “хангалттай” зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй.<br>2. 100 хувь “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн.<br><br>Дундаж 85 хувь.
</td>
<td></td>
</tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4 | Гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм, журам, түүнийг зохицуулсан үйл ажиллагаа, гадаад худалдааны статистик мэдээллийг монгол, англи хэл дээр түгээх, гадаад худалдааны нэгдсэн портал бий болгох, хэрэглэгчдэд холбогдох мэдээллийг түргэн шуурхай, энгийн байдлаар хүргэнэ. | Үйл ажиллагаа | Цахим хуудсаар лавлах цэгээр түгээсэн мэдээллийн тоо, Цахим хуудасны хандалтын тоо, Лавлах цэгээр үйлчлүүлсэн хэрэглэгчийн тоо, хувиар, Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.Гаалийн болон бусад хууль тогтоомжийн мэдээллийг тухай бүр цахим хуудсаар дамжуулан түгээсэн. | Хууль зүй дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэлтэй ГЕГ-ын дарга баталж гаалийн хяналт, шалгалт бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хэрэгжиж байгаа нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний 35 актад хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, шаардлагатай эрх зүйн актыг хүчингүй болгох, нэгтгэх, өөрчлөх, дахин боловсруулж батлуулан, хүчин төгөлдөр болмогц нийтэд цахим хуудсаар дамжуулан түгээх. | ХЗДХЯ-аас 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Захиргааны хэм хэмжээний актын жагсаалтыг шинэчлэн гаргах тухай” 3/80 албан бичгээр ирүүлсэн 36 акт бүхий жагсаалтыг гаалийн байгууллагын эрхийн актын сантай тулгаж, нягтлан шалгаж, холбогдох мэдээллийг хүргүүлсэн.<br>Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд 2025 оны эхэнд бүртгэлтэй ГЕГ-ын дарга баталж гаалийн хяналт, шалгалт бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хэрэгжиж байгаа нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний 36 акт бүртгэлтэй байснаас тайлант хугацаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, ГЕГ-ын даргын баталсан 3 эрх зүйн актыг хүчингүй болгосон. Нэмэлт өөрчлөлт оруулах 2 захиргааны хэм хэмжээний актыг гаргасан.<br>Захиргааны ерөнхий хуульд заасан хугацаанд багтаан Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд 2024 онд өөрчлөлт орсон актын мэдээллийг тулган шалгаж өөрчлөлт ороогүй талаар ГЕГ-ын дэд даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн “Захиргааны хэм хэмжээний актын жагсаалтыг нягталсан тухай” 02/294 албан бичгээр уламжлан хүргүүлсэн.<br>Үүнээс ГЕГ-ын даргын 2022 оны А/341 дүгээр тушаалаар батлагдсан “Зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих нийтлэг журам” нь ГЕГ-ын даргын 2025 оны А/19 дүгээр тушаалаар хүчингүй болсон ба ХЗДХЯ-ны 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 1/646 дугаар албан бичгээр “Шийдвэрийг буцаан хүргүүлэх, улсын нэгдсэн санд хөдөлгөөн хийсэн тухай” албан бичгээр хуулийн үндэслэлийг дурдаж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх шаардлагагүй гэж үзэн буцаан ирүүлсэн тул нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн сангаас хасагдсан.<br>Санд бүртгэлтэй ГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан нийтээр дагаж мөрдөх 31 захиргааны хэм хэмжээний акт Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн. Үүнээс 10 актад оруулсан 20 нэмэлт, өөрчлөлт, 2 захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгож, шинэчлэн баталсан 2 шийдвэрийг тухай бүр нэгдсэн санд бүртгүүлсэн. ХЗДХЯ-нд захиргааны хэм хэмжээний акттай холбоотой 2 албан бичиг хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **100** хувь “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 3.5 | Авто зам, төмөр зам, агаарын замын тээврийн хэрэгсэл шалгах заавар боловсруулж, батлуулсан байна. | Үйл ажиллагаа | Батлуулсан эрх зүйн актын тоо | Авто зам, төмөр зам, агаарын замын тээврийн хэрэгсэл шалгах заавар, гарын авлага байдаггүй. | Авто зам, төмөр зам, агаарын замын тээврийн хэрэгсэл шалгах зааврын төслийг МЗХ-д танилцуулж, ГЕГ-ын даргын тушаалаар батлуулсан байна. | Авто зам, төмөр зам, агаарын замын тээврийн хэрэгсэл шалгах заавар боловсруулж, батлуулах зорилгоор АТҮТ-д дараах албан бичгүүдийг хүргүүлсэн. Үүнд:<br>-Агаарын боомтоор нэвтрүүлэх онгоц, нисдэг тэрэгний хяналт, шалгалтыг сайжруулахтай холбоотой сургалтад ашиглах, мөн гаалийн хяналт, шалгалтад анхаарах асуудлыг харуулсан зураг, схем бүхий заавар, зөвлөмжийг ирүүлэх, мөн Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын албан хаагч нарт онгоц, нисдэг тэрэгт гаалийн хяналт, шалгалт хийхдээ анхаарах зөвлөмж өгөх ажлын байрны сургалтыг зохион байгуулж, хамтран ажиллах хүсэлтийг 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 02-1/1318 албан бичгээр;<br>-Автозамын боомтуудаар нэвтрэх тээврийн хэрэгслийн хяналт, шалгалтыг сайжруулахтай холбоотой сургалтад ашиглах тээврийн хэрэгслийн төрөл, бүтэц, гаалийн хяналт, шалгалтад анхаарах асуудлыг харуулсан зураг, схем бүхий заавар ирүүлэх хүсэлтийг 02-1/1632 албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>Тээвэрлэгч байгууллагуудад ашиглагдаж буй вагонд үзлэг хийх схем, агаарын хөлөгт шалгалт хийж, тэсрэх бодис илрүүлэх үзлэгийн хуудсыг судалж, төслийг урьдчилсан байдлаар боловсруулсан.<br><br>**70** хувь “хангалтгүй” зохион байгуулалт хангалтгүй үр дүнд хүрээгүй. | 70 |
| 3.6 | Хорио цээр эрүүл ахуй чанарын тохирлын хяналтын эрх зүйн орчин боловсронгуй болгоно. | Үйл ажиллагаа | Батлуулсан эрх зүйн баримт бичгийн тоо | Хуулийг шинэчилсэн санал-2, Протокол-2<br>ГЕГ-ын даргын тушаал-3<br>- | Хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, протокол- 2-г боловсруулах.<br>ГЕГ-ын даргын тушаал -2-г боловсруулах.<br>ЗГ-ын тогтоолоор батлуулах журмын төслийн санал-2-г боловсруулах. | 1.“Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/30 дугаар тушаалыг боловсруулан баталсан. (Тушаалын 1 дүгээр хавсралт ”Хүнсний сүлжээн дэх тээвэрлэлтийн ерөнхий шаардлага”, 2 дугаар хавсралтаар “Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хаяг шошгожилт”)<br>2.“Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ын төсөлд Хорио цээрийн хэлтсээс оруулах саналын хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулж, саналыг тусгасан.<br>3.Гаалийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний 1.2.3 дахь заалт болох “Нийгмийн эрүүл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэндийн хариу арга хэмжээний болон барааны аюулгүй байдал” хэсгийг эцэслэн боловсруулж, Сангийн сайдаар 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлуулж, уг стратегийг хэрэгжүүлэх, аргачлалыг баталсан 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/64 дүгээр тушаалыг мөрдүүлж ажилласан.<br>4.Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих тусгай шаардлага”, “Тээврийн хэрэгсэлд хийгдэх халдваргүйжүүлэлтийн журам”-ын төслийг боловсруулж, санал авч, байгууллагын вэб хуудаст 1 сарын хугацаатай байршуулж, Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээч, амьтан ургамал тэдгээрийн гаралтай түүхийн эд бүтээгдэхүүнийг импортлогч, экспортлогч, тээвэрлэгч, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан санал сонсох, мэдээлэл авах сонсголыг 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгууллаа. Уг сонсголд 41 иргэн аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцож, ЭМЯ, ЗӨСҮТ, МЭЕГ-аас санал авч саналыг журмын төсөлд тусгаж ажиллахаар шийдвэрлэн, төлөвлөгөөний дагуу Мэргэжлийн зөвлөлийн хурлаар оруулахаар шийдвэрлэсэн.<br>5.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх хэсэгт заасан амьтны гоц халдварт өвчин болон ургамлын хорио цээртэй хөнөөлт организм улсын хилээр нэвтрэн тархах эрсдэл үүссэн болон үүсэж болзошгүй нөхцөл байдал бүрдсэн үед баримтлах нийтлэг журам /дэглэм/, Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын хавсралт "Ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр, хөврөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудын жагсаалт", "Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт хийх журам", "Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам"-ын төслүүдийг тус тус боловсруулж, журмын төслүүдэд Мал амьтны эрүүл мэндийн асуудал, Ургамлын хорио цээрийн асуудал эрхэлсэн төрийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагуудаас холбогдох мэргэжилтнийг оролцуулахаар 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 02-1.2/2426, 02-1.2/2427 албан бичгүүдийг хүргүүлсэн.<br>6.“Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах төсөл боловсруулах ажлын удирдамж”-ийн дагуу Гаалийн тухай хуулийн төсөлд хорио цээрийн чиглэлийн саналыг хүргүүлсэн.<br>7.ГЕГ-ын даргын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/176 дугаар тушаалын дагуу МУ-ын ГЕГ, БНХАУ-ын ГЕГ хооронд байгуулсан “2022 оны Хилийн эрүүл ахуй, хорио цээрийн хамтын ажиллагааны протокол”-ын хэрэгжилтийг хангуулах хүрээнд ЗӨСҮТ, ХӨСҮТ-тэй хамтран, БНХАУ-ын Хөх хот, Эрээний гаалийн газартай хамтран 2025 оны 05 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд БНХАУ-ын Эрээн хотод болсон уулзалтад ГЕГ-ын хорио цээрийн хэлтэс, Замын-Үүд дэх гаалийн газрын хорио цээрийн албаны төлөөллүүд оролцож, дээрх протоколын хэрэгжилтийн талаар Монголын талын илтгэл хэлэлцүүлэв.<br>Уулзалтын мөрөөр 4 заалтаар /Монгол, Хятадын хилийн боомтуудын мэрэгчээр дамжих зоонозын халдварт өвчний хамтарсан тандалт, хилийн эрүүл ахуй, хорио цээрийн асуудлаар хэлэлцээр, эрдэм шинжилгээний хурал, үзүүлэх сургууль/ 2025 онд ажлыг төлөвлөж, хамтын ажиллагааны протоколыг үйлдэж, Хөх хотын гаалийн газар, МУ-ын ГЕГ-ын хорио цээрийн хэлтэс, ӨМӨЗО-ны Өвчнөөс урьдчилан сэргийлэх төв, МУ-ын ЗӨСҮТ-ийн талаас баталгаажуулав.<br><br>**100** хувь “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 3.7 | ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, зорчигчид гаалийн хяналт | Үйл ажиллагаа | Батлуулсан эрх зүйн баримт бичгийн тоо | ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаартай тушаалаар батлагдсан хяналтын нийтлэг журмын төслийг боловсруулж, ГЕГ-ын бүтцийн нэгж, харьяа гаалийн газар, хороодын | 1.ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, зорчигчид гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ыг шинэчлэн | ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ыг шинэчлэх төслийг боловсруулж, Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодоос 2023-2025 онд ирүүлсэн саналыг нэгтгэн, тусгаж, эцэслэн боловсруулсан.<br>АТГ-аас албан бичгээр болон Мөрдөгчийн мэдэгдэл хэлбэрээр “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-д | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тавих нийтлэг журам"-ыг шинэчлэн боловсруулсан төслийг батлуулсан байна. | | | дарга нарт албан бичгийн хавсралтаар хүргүүлж, мөн гаалийн байгууллагын customs.gov.mn-д байршуулж олон нийтээс санал авч, ГЕГ-ын МЗХ-д танилцуулахад бэлтгэсэн. Гэвч дээрх журмын төсөлд холбогдох зохицуулалтуудыг нарийвчлан тусгаж, төслийг АТГ-т хүргүүлж, хянуулах үүргийг АТГ-аас 2024.10.31-ний өдрийн 01/17563 дугаартай албан бичгээр ирүүлсэн. Иймд дээрх төсөлд дахин нэмэлт оруулж, АТГ-т хүргүүлж, хянуулахаар ажиллаж байна. | боловсруулсан төслийг АТГ-т хүргүүлж, хянуулсан байна.<br>2.Хяналтын нийтлэг журмын төслийг МЗХ-д танилцуулж, батлуулсан байна. | гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааны үе шат бүрд оролцож байгаа албан хаагчдын албан тушаал бүрээр гүйцэтгэх үүргийг тодорхой зааж тусгах чиглэл өгсөн тул тус саналыг журмын төсөлд тусгаж, эцэслэн боловсруулсан төслийг танилцуулж, санал авах зорилгоор АТГ-т 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 02/850 албан бичгээр хүргүүлсэн.<br>Журмын төсөлд ирүүлсэн саналыг судалж, хууль тогтоомжид нийцүүлэн тусгаж, Гаалийн ерөнхий газрын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.<br>Тус хуралдаанаас журмын төслийг зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдэд дахин танилцуулах чиглэл өгч буцаасан тул нэгжийн дарга нарт дахин хүргүүлсэн. Ирүүлсэн саналыг судалж, саналын дагуу төсөлд зарим нэмэлт, өөрчлөлтийг тусгахын зэрэгцээ, зарчмын зөрүүтэй зарим саналын талаар танилцуулга бичиж, Гаалийн ерөнхий газрын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлж, 07/03 дугаартай шийдвэрээр дэмжигдсэн.<br><br>1. **100** хувь "бүрэн хангалттай" зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн.<br>2. **90** хувь "хангалттай" зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй.<br><br>Дундаж **95** хувь. | |
| 3.8 | ГЕГ-ын даргын 2016 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг нөхөн бичих заавар", "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны | Үйл ажиллаг аа | Батлуулсан эрх зүйн баримт бичгийн тоо | ГЕГ-ын даргын 2016 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан Гаалийн мэдүүлгийг нөхөн бичих заавар", Гаалийн мэдүүлгийг шалгах заавар"-ыг шинэчлэхээр төслийг гаалийн цахим хуудаст | ГЕГ-ын даргын 2016 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг нөхөн бичих заавар", "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар"-ыг шинэчлэн боловсруулсан төслийг | 1.ГЕГ-ын даргын 2016 оны А/82 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар" болон тус зааврын дор дурдсан хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагаас 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01101/59 дотоод зурвасаар авч, 13 нэгжээс ирүүлсэн саналыг нэгтгэсэн.<br>2."Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар"-ын "Хоёр. Гаалийн мэдүүлгийн маягтыг нөхөн бичих" хэсэгт заасан гаалийн мэдүүлгийг нөхөн бичих хүснэгт дэх мэдээлэл гаалийн автоматжуулсан удирдлагын системд /CAIS/ байгаа | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдүүлгийг шалгах заавар”-ыг шинэчлэн боловсруулсан төслийг батлуулсан байна. | | | байршуулан Захиргааны ерөнхий хуулийн дагуу олон нийтээс санал авч байна. Төслийг хяналтын нийтлэг журамтай уялдуулж, эцэслэхээр ажиллаж байна. | МЗХ-д танилцуулж, батлуулсан байна. | мэдээлэлтэй тохирч байгаа эсэх, нэмэлт, өөрчлөлт орсон байдлыг хүснэгт нэг бүрээр, Гаалийн мэдүүлгийн маягтыг нөхөн бичих үед энэ хэсэгт заасан мэдээллийн хэд дэх хүснэгтийн аль үзүүлэлтүүдийг гараар нөхөн бичдэг, мөн программаас татаж оруулдаг эсэх, тухайн хүснэгт дэх мэдээллийг тоогоор, эсхүл үсгээр илэрхийлэх зэрэг мэдээллийг гаргаж, хамтран ажиллах тухай 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 01101/160 дотоод зурвасыг Мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн.<br>3.Тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар”-ыг шинэчлэн боловсруулсан төслийг зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагад 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 01101/185 дотоод зурвасаар хүргүүлж, санал авсан. Мөн журмын төслийг харьяа гаалийн газар, хороодод 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 02-1/1222 албан бичгээр хүргүүлж, санал авсан. Зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодоос ирүүлсэн саналыг судлан төсөлд тусган Гаалийн ерөнхий газрын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, 07/04 дугаартай шийдвэрээр дэмжигдсэн.<br><br>**90** хувь “хангалттай” зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй үр дүн гарч эхэлсэн. | |
| 3.9 | Гаалийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний судалгааг зохион байгуулна. | 20 сая | Судалгааны үнэлгээ | ХҮС-ны дундаж үнэлгээ 75%-аар үнэлэгдсэн. | 1.Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны үр дүнг зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодод хүргүүлж сайжруулах чиглэлд ажил зохион байгуулна.<br>2.Цахим судалгааны хяналт шинжилгээ, үнэлгээ | 1.Гаалийн байгууллагын 2024 оны хэрэглэгчийн үнэлгээний судалгааны үр дүнгийн тайланг, 2025 онд үнэлгээг өсгөхөд чиглэсэн өөрийн нэгжийн онцлогт тохирсон арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тайлагнан ажиллах талаар чиглэлийн хамт ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагад 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн дотоод зурвасаар, харьяа гаалийн газар, хороодод 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01-4/666 тоот албан бичгээр хүргүүлсэн. Чиглэлийн хүрээнд зохион байгуулсан ажлын үр дүнг 2025 оны эхний хагас жилийн зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хорооны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх явцад үнэлнэ. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Гаалийн байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа”-г 2025 оны 4 дүгээр улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.<br>2.Гаалийн байгууллагын мэдээллийн технологийн үйл ажиллагаа, программын өөрчлөлт, хөгжүүлэлт хийлгэхээр программын даалгавар хүргүүлсэн. Программын даалгаврын гүйцэтгэлийн үр дүнг тооцох зорилгоор боловсруулах үйл ажиллагаа явагдаж байгаа тул 2025 оны эхний хагас жилд ямар нэгэн санал асуулга явагдаагүй.<br>Харин харьяа газар, хороод болон ГЕГ-ын нэгжүүд гаалийн байгууллагын үйл ажиллагаанд албан хаагч, иргэн, олон нийт болон гаалийн харилцаанд оролцогчдоос өгч буй үнэлгээ, санал бодлыг тогтмол судалж, түүний үр дүнг бодлого, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх зорилгоор 2025 оны эхний хагас жилийн хугацаанд нийт 26 төрлийн цахим судалгааг зохион байгуулж, 3040 орчим албан хаагч, иргэн, гаалийн харилцаанд оролцогчдыг хамруулсан байна.<br>Эдгээр судалгаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд судалгааны дундаж үнэлгээ 74.4 хувь байгаа бөгөөд судалгааны үр дүнг харгалзан дараах голлох сайжруулалтын чиглэл бүхий 11 зөвлөмжийг ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагад болон харьяа гаалийн газар, хороодод хүргүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:<br>- Судалгааны ажлын давтамжийг нэмэгдүүлэх;<br>- Судалгаанд хамрагдах оролцогчдын хүрээг тэлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх;<br>- Судалгааны асуулгын агуулгыг нарийвчлан боловсруулж, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчлөх;<br>- Судалгааны хариуг ашиглах, дүн шинжилгээ хийх арга зүйг боловсронгуй болгох зэрэг санал багтсан болно.<br>Түүнчлэн судалгааны дүнгээс харахад нийт оролцогчдын 92 хувийг Гаалийн байгууллагын албан хаагчид, үлдсэн 8 хувийг иргэн, олон нийт, гаалийн харилцаанд оролцогчид эзэлж байна. Иймд цаашид иргэн, олон нийтээс авах судалгааг эрчимжүүлэх, оролцоог тэлэх шаардлагатай гэж үзэн холбогдох нэгжүүдэд тусгайлан чиглэл өгч, судалгааны үр дүнд үндэслэн үйлчилгээг сайжруулах төлөвлөгөөг гаргаж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилтийг хангах зөвлөмжийг мөн хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.<br><br>**100** хувь “бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 3.10 | Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцох ажлыг эрчимжүүлсэн байна. | Үйл ажиллагаа | Хэрэгжилт, хувиар | Гаалийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох зорилго бүхий санал асуулгыг нийт 19 газар, хороодын 1069 төрийн төрийн албан хаагчдаас авч нэгтгэсэн. Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцох судалгааг эрсдэл тооцох аргачлалын дагуу хэрэгжүүлж, 67%-ийн үнэлгээгээр үнэлэгдсэн. | Байгууллагын эрсдэлийн удирдлагын үр нөлөөг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн байна. | 1.Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцох, гаалийн байгууллагын эрсдэлийг бууруулах талаар эрсдэлийн удирдлагын олон улсын аргачлал (WCO Risk Management Compendium, ISO 31000) болон холбогдох хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэн эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, сахилгын зөрчил, гомдол мэдээллийг дүгнэх албан хаагчдын хандлага, ажиллах нөхцөл, сэтгэл ханамжийг тодорхойлох, байгууллагын манлайлал, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлд судалгаа дүн шинжилгээ хийж үр дүнд тулгуурласан чиглэл зөвлөмжийг Хүний нөөцийн хэлтэс, харьяа гаалийн газар газар хороодод ажлын чиглэл, зөвлөмж хүргүүлж ажиллаа. Үүнд:<br>1.1.Хууль тогтоомжийн эрсдэлийн судалгаа: Google Form ашиглан 9 асуулгатай судалгаа явуулж, 543 албан хаагч оролцсон. Тус судалгаанаас хууль тогтоомжийн мэдээллийг цаг хугацаанд нь авах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, албан хаагч нарт сургалт зохион байгуулах, хууль тогтоомжид гарч буй эрсдэлийг багасгахад анхаарч ажиллах талаар дүгнэлт гарсан. Судалгаагаар гарсан үр дүнг хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй Замын-Үүд дэх гаалийн газар, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Дорнод аймаг дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар, Гашуунсухайт дахь гаалийн газар, Шивээхүрэн дэх гаалийн газар, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, Ховд аймгийн Булган дахь гаалийн газар, Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар, Сайншанд дахь гаалийн газар, Ханги дахь гаалийн газар, Говь-Алтай аймгийн Бургастай дахь гаалийн хороо, Завхан аймгийн Арцсуурь дахь гаалийн хороо, Хөвсгөл аймгийн Ханх дахь гаалийн хороонд 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01-5/871 албан бичгээр хүргүүлсэн.<br>Судалгааны дүнд илэрсэн гол асуудлууд:<br>-Хууль тогтоомжийн мэдээллийг цаг хугацаанд нь авах<br>-Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Албан хаагч нарт сургалт зохион байгуулах<br>-Хууль тогтоомжид гарч буй эрсдэлийг багасгахад анхаарч ажиллах<br>1.2.Хүний нөөцийн эрсдэлийн судалгаа: Google Form ашиглан 12 асуулгатай судалгаанд 468 албан хаагч оролцсон. Судалгааны тайланг ГЕГ-ын дарга болон Захиргааны удирдлагын газарт болон Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн. Гол эрсдэлтэй асуудлууд :<br>-Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, орон тоог нөхөх<br>-Сэлгэн ажиллуулах журмыг ил тод, шударга болгох<br>-Ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулах<br>-Удирдлагын манлайлал, мэргэшлийг нэмэгдүүлэх<br>-Шударга, ил тод байдал хангах<br>-Албан хаагчдыг мэргэшүүлэх, мэдлэгийг нэмэгдүүлэх<br>-Хууль дүрэм, мэдээллийг түргэн шуурхай хүргэх<br>-Хууль эрх зүйн зохицуулалт шинэчлэх, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх<br>-Тусгай албадын эрх зүйн тэгш байдал хангах.<br><br>**70** хувь "хангалтай" зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй үр дүн тодорхойгүй. | |
| 3.11 | Гаалийн байгууллагын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, холбогдох дээд шатны байгууллагад тайлагнах, | Үйл ажиллагаа | Хэрэгжилт, хувиар | 1.Гаалийн байгууллагын 2023 онд хэрэгжүүлсэн 6 бүлэг бодлогын баримт бичиг, 39 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 69 зүйл заалтын хэрэгжилт, гаалийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний дундаж 88.2 хувиар үнэлэгдсэн.<br>2.Бусад төлөвлөгөөний хяналт шинжилгээ, үнэлгээний дундаж үнэлгээ 85.3 хувь, | 1.Гаалийн байгууллагын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, холбогдох дээд шатны байгууллагад тайлагнах,<br>2.Бусад төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх,<br>3.Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр хүргүүлсэн | 1.Сангийн яамны харьяа агентлагийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлалын дагуу 2024 оны жилийн эцсийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн 25 тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Гаалийн ерөнхий газрын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланд тусган 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01-4/520 албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн ба Сангийн яамнаас 88.5 хувь буюу Сайн гэж үнэлэгдсэн.<br>2.Бусад төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээнд 2025 оны эхний хагас жилд зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагаас ирүүлсэн нийт 7 төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үүнд:<br>-"Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай" Монгол улсын Засгийн газрын 178 дугаар тогтоолын хүрээнд гаалийн байгууллагаас хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 2024 оны биелэлт",<br>-АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсээс ирүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн хүрээнд гаалийн хяналт, шалгалтын үр дүнг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 3.Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр 63 багц 157 зөвлөмж хүргүүлснийг хянаж, 76.5 хувиар үнэлэв. | зөвлөмжийн хяналтыг хэрэгжүүлнэ. | нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөөний 2024 он, 2025 оны 1 дүгээр улирлын биелэлт,<br>-Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын засгийн газар хоорондын комиссын хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын гаалийн байгууллагын чиг үүрэгт хамаарах ажлын биелэлт,<br>-Монгол улс БНХАУ-ын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд Гаалийн байгууллагаас 2024 оны 4 дүгээр улиралд хэрэгжүүлсэн ажлын тайлан,<br>-Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 18 дугаар тушаалаар батлагдсан "Монгол улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний дагуу гаалийн байгууллагын авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт.<br>-Агаарын тээврийг хялбаршуулах зохицуулах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан гаалийн байгууллагын чиг үүрэгт хамаарах ажлын 2 дугаар улирлын биелэлт,<br>-Хүний эрхийн үндэсний комиссын 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 01/19 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө,<br>3.ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын болон харьяа гаалийн газар, хороодын 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн биелэлтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр нийт 930 зөвлөмжийг 2025 оны эхний хагас жилд хэрэгжүүлж тайлагнахаар хүргүүлсэн. Эдгээрээс 515 үүрэг даалгаврын биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дундаж биелэлт 96.2 хувийн хэрэгжилттэй байна. Үлдсэн 415 зөвлөмжийн үнэлэх хугацаа болоогүй байна.<br>4.Сангийн сайдын 2018 оны 143 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад заасны дагуу болон бусад төлөвлөсөн Гаалийн байгууллагын 2025 оны эхний хагас жилийн эрх зүйн акт, бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны хэрэгжилтийн 16 тайланг нэгтгэн боловсруулж, СЯ-нд болон АТГ-т хугацаанд нь хүргүүлэхээр ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 3.12 | Гаалийн байгууллагын хууль тогтоомж, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээллийн ил тод байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх | Үйл ажиллагаа | Олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо, хувиар | Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, цаг үеийн холбогдолтой 409 мэдээ, мэдээллийг түгээсэн. | Гаалийн байгууллагын олон нийтэд хүргэх мэдээллийн төрлийг нэмэгдүүлж, улирал бүр нэвтрүүлгийг бэлтгэн гаргаж, олон нийтэд хүргэх мэдээллийн тоог өмнөх оныхоос 5-аас доошгүй хувиар өсгөнө. | Гаалийн байгууллагын үйл ажиллагаа болон гаалийн холбогдолтой хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, ажлын хүрээнд:<br>-“Монголын гааль” пэйж хуудас болон төрийн мэдээллийн нэгдсэн сайт www.gov.mn сайтад 45 видео, 93 постер, 50 фото зурган мэдээлэл, 33 рийлс буюу нийт 231 мэдээ, мэдээллийг нийтлэн түгээсэн. Мөн “Гаалийн албан хаагчдын мэдээлэл солилцох” дотоод группэд 4 видео, 6 мэдээ, мэдээлэл пост хийж түгээсэн.<br>-“МОНГОЛЫН ГААЛЬ” твиттер хуудаст 33 рийлс, 93 постер, 50 фото зурган мэдээ зэрэг нийт 176 мэдээ мэдээллийг цаг алдалгүй тухай бүр нийтэд түгээж пост хийсэн.<br>-Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчдийн группт мэдээ, мэдээллийг ашиглаж болох байдлаар тогтмол түгээж ажиллаж байна. Тухайлбал, Фейсбүүкээр дамжуулан 244 гишүүнтэй “Хэвлэлийнхэн”, 153 гишүүнтэй “Сэтгүүлч”, 247 гишүүнтэй “Хэвлэлийн төлөөлөгч”, 95 гишүүнтэй “Гаалийн мэдээ, мэдээлэл”, 249 гишүүнтэй “Хэвлэлийн бага хурал”, вайберийн 44 гишүүнтэй “Гаалийн хэвлэлийн тойм”, 248 гишүүнтэй “Хэвлэлийнхэн”.<br>-Тайлант хугацаанд Төрийн мэдээллийн нэгдсэн сайт www.gov.mn сайтад 214 мэдээ, постер нийтлэгдсэн нь өмнөх оны мөн үед customs.gov.mn сайтад байршуулсан мэдээний тооноос 4 хувиар, “МОНГОЛЫН ГААЛЬ” фэйсбүүк хаягт байршуулсан нийт мэдээллийн тоо 231 мэдээ, постер, видео нийтлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 12.7 хувиар, дагагчийн тоо өмнөх оны мөн үеэс 8 мянгаар нэмэгдэж 33 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.<br>-Гаалийн байгууллагын олон нийтэд хүргэх мэдээллийн төрлийг нэмэгдүүлэх, үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомж, албан хаагчдын ажил, амьдралыг эерэг талаас нь сурталчлах зорилгоор "Бидний нэг-Үүрэг хүлээсэн гаальчин” видео контентын хүрээнд Гааль Подкастын 2 дугаар хийж түгээсэн. Уг 2 контентыг нийт 3000 гаруй хүн үзсэн байна.<br><br>**100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.13 | Байгууллагын төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн сахилга батыг хангах | Үйл ажиллагаа | Төсвийн хэмнэлт, хувиар, Үүссэн өглөг, авлага, төгрөгөөр, Гэрээний биелэлтийн үнэлгээгээр, | -Гаалийн байгууллага нь 2024 онд хэвийн үйл ажиллагааг хангахаар 135,4 тэрбум төгрөгийн төлөвлөгөө батлагдаж, 116,8 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гаргасан байна. Мөн үндсэн үйл ажиллагааны орлого нь 4,2 тэрбум төгрөгийг төлөвлөж, 5,1 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.<br>-Монгол Улсын 2024 оны төсвийн тухай тухай хуулиар Гаалийн ерөнхий газрын хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд шилжих ангиллаар 15,285.2 сая төгрөгийн санхүүжилт хийгдэхээр батлагдсан.<br>- Сангийн сайдын 2024 оны 11, 213 дугаар тушаалаар 6,9 тэрбум төгрөгийн 7 арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжин ирсэн. Дээрх хөрөнгө | 1.Байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөн, батлуулж, батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулсны үндсэн дээр үүссэн хэмнэлтийн хувь хэмжээ өмнөх оноос буураагүй байна.<br>2.Тайлант оны худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд нь ил тод нээлттэй зохион байгуулан шинээр өглөг, авлага үүсгээгүй байна.<br>3.Төрийн өмч эзэмшүүлэх гэрээний биелэлт 96 хувиас дээш үнэлэгдсэн байна. | 1.Байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөн, батлуулж, батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулсны үндсэн дээр үүссэн хэмнэлтийн хувь хэмжээ өмнөх оноос буурсан байна.<br>Гаалийн байгууллагын 2025 оны төсвийн төслийн саналд 160,3 тэрбум төгрөгийн саналыг тусган Сангийн яаманд хүргүүлснээс урсгал үйл ажиллагааны зардлын төсөв 147,7 тэрбум төгрөгөөр батлагдсан. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 8,3 хувиар буюу 13,2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан.<br>Гаалийн байгууллагын 2025 оны эхний хагас жилийн байдлаарх урсгал үйл ажиллагааны зардлын төсөв 54.5 тэрбум төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 22 хувиар буюу 15.1 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан. 2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар гүйцэтгэл 44.5 тэрбум төгрөг буюу 9.6 тэрбум төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна. Гаалийн байгууллагын батлагдсан төсвийг харьяа гаалийн газар, хороодод хуваарилахдаа 2024 оны төсвийн гүйцэтгэл, ажиллаж буй орон тоо, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах бусад хэрэгцээ шаардлагыг үндэслэн хуваарилж, Төрийн хэмнэлтийн хууль, Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төсвийн зардлыг хэмнэх, өр авлага үүсгэхгүй байх чиглэлээр төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан ажиллаа.<br>2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаарх урсгал үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлээр 84.3% буюу 37.5 тэрбум төгрөгийг Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ЭМНДШ-ийн зардал, 7.2% буюу 3.2 тэрбум төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 0.8% буюу 0.3 тэрбум төгрөгийг хангамж, бараа материалын зардал, 0.4% буюу 0.2 тэрбум төгрөгийг нормативт зардал, 1.3% буюу 0.6 тэрбум төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардал, 0.2% буюу 0.1 тэрбум төгрөгийг томилолтын зардал, 4% буюу 1.8 тэрбум төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, 0.1% буюу 0.04 тэрбум төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардал, 1.6% буюу 0.7 тэрбум төгрөгийг урсгал шилжүүлгийн зардал тус тус эзэлж байна. | 97.6 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | оруулалт, төсөл арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэгчийн нийлүүлсэн бараа, ажил үйлчилгээг хүлээн авах, гэрээ дүгнэх, санхүүжилтийг олгох зэрэг ажлыг бүрэн зохион байгуулан ажиллалаа.<br>-Төрийн өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 96 хувиар үнэлж ирүүлсэн. | | 2.Тайлант оны худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд нь ил тод нээлттэй зохион байгуулан шинээр өглөг, авлага үүсгээгүй байна.<br>Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулиар гаалийн ерөнхий газрын хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд 11,270.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдэхээр батлагдсан.<br>Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо хэмжээг Гаалийн ерөнхий газрын Захиргааны зөвлөлийн хуралдааны 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дүгээр шийдвэрээр баталгаажуулсан. Уг шийдвэрийн дагуу Гаалийн ерөнхий газрын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/02 тушаалаар 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Гаалийн ерөнхий газрын 2025 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тоног төхөөрөмжийн жагсаалтыг батлуулсан.<br>Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 233 дугаар тогтоолын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газарт худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлэх албан бичгийг худалдан авах тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн үзүүлэлтийн хамт Гаалийн ерөнхий газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01/100 албан бичгээр хүргүүлсэн.<br>Гаалийн ерөнхий газрын урсгал төсвөөр 2025 онд нээлттэй 5, харьцуулалтын аргаар 3, нийт 8 тендер зарлахаар төлөвлөсний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Мөн ерөнхий гэрээгээр 4 худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллалаа.<br>ОХУ-ын “ИСБ.А” ХХК-тай 2019 онд байгуулсан №ISBA-14-10/2019 дугаартай “Хяналтын систем нийлүүлэх, угсрах болон шалгах ажил гүйцэтгэх” гэрээний дагуу Монгол улсын хилийн 11 боомтод 14 иж бүрдэл төхөөрөмж суурилуулахаар гэрээ байгуулсан. Шивээхүрэн боомтод эхний 1 иж бүрдэл болох ISBA-005 сериал дугаартай тоног төхөөрөмжийг 2022 оны 05 дугаар сард, 2023 онд ISBA-006 сериал дугаартай төхөөрөмжийг Замын-Үүд боомтод, ISBA-007 сериал дугаартай төхөөрөмжийг Боршоо боомтод, 2024 онд ISBA-008 сериал дугаартай төхөөрөмжийг Ховд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймгийн Булган дахь гаалийн газар, ISBA-009 сериал дугаартай төхөөрөмжийг Гашуунсухайт дахь гаалийн газарт нүүрсний гарцын экспорт талд суурилуулан хүлээлгэн өгөөд байсан.<br>Гашуунсухайт дахь гаалийн газарт нүүрсний гарцын импорт талд ISBA-011 сериал дугаартай төхөөрөмжийг суурилуулан ашиглалтад оруулж 2025 оны 03 дугаар сарын 20-нд бүрэн ашиглалтад хүлээж авсан. Замын-Үүд боомтын ачаа тээврийн цогцолборын экспорт талд ISBA-010 сериал дугаартай төхөөрөмж суурилуулагдах ажил 2025 оны 06 сарын 10-нд хийгдэж дууссан бөгөөд туршилтын ажил явагдаж байна. Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны А/38 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2025 оны 06 дугаар сарын 16-аас ажиллаж хүлээн авах асуудлыг шийдвэрлэнэ.<br>Гаалийн байгууллагын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийг зохион байгуулах Үнэлгээний хороо байгуулах Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны 8 тушаалыг батлуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.<br>Гаалийн байгууллагын 2025 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг Сангийн яамны PIMIS программд оруулан ТХААГ-аас зохион байгуулсан тендерийн гүйцэтгэгчтэй байгуулсан 6 компанийн гэрээг баталгаажуулан гүйцэтгэл гаргахад бэлэн болсон.<br>3.Төрийн өмч эзэмшүүлэх гэрээний биелэлт 96 хувиас дээш үнэлэгдсэн. Гаалийн ерөнхий газрын Дэд даргаар байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, тайлан бүртгэл, тооцоог сайжруулах ажлуудыг хамруулсан “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөө”-г батлуулсан. Уг төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>-Увс аймаг дахь гаалийн газрын хяналт бүрдүүлэлтийн барилга, Гашуунсухайт дахь гаалийн газрын боомтын бүтээн байгуулалтаар бий болсон зам талбай, барилга байгууламж, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын нэг цэгийн үйлчилгээний төв болон эрэлч нохойн төвийн барилга байгууламж зам талбайг бүртгэлд тусгах саналыг Сангийн яам, Иргэний нисэхийн ерөнхий газар, Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төсөлд хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Авлигатай тэмцэх газрын 2025 оны 03/2734 албан бичгээр Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/11 дүгээр тушаалаар баталсан “Ашиглалтын гэрээний загвар”-ын “Ашиглагч байгууллагын эрх, үүрэг”-т талбайн ашиглалттай холбоотой тогтмол зардал (түлш, халаалт, гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус, цэвэрлэгээ үйлчилгээ)-ний төлбөр тооцоог “Ашиглагч байгууллага” хариуцахаар нэмэлт өөрчлөлтийг тусган хэрэгжүүлэх зөвлөмжийг ирүүлсэн.<br>-Уг зөвлөмжийн хүрээнд харьяа гаалийн газар, хороодын өмчлөлийн байранд байрлаж байгаа төсөвт байгууллагуудад ногдох байр ашиглалтын зардлын тооцооллыг гарган Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн харьяатын газар, Тагнуулын ерөнхий газар, Хилийн боомтын захиргаа, Оюуны өмчийн газарт тус тус хүргүүлж байгууллагынхаа 2026 оны төсөвт тусган хэрэгжүүлж хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлж ажилласан.<br>-“Горхи мэлхий хад” амралтын газрыг Гаалийн байгууллагын “Зайн сургалтын төв” байгуулах төслийн боловсруулах ажлын хүрээнд тус амралтын газрын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгэхээр судлан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын burtgel.pcsp.gov.mn цахим хуудсанд 2024 оны хөрөнгийн хөдлөлтэй холбоотой мэдээ тайланг газар, хороодын хэмжээнд бүрэн оруулсан.<br>-Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сангийн сайдын 2024 оны 213 дугаар тушаалын дагуу худалдан авсан тээврийн хэрэгслүүдийг ГЕГ-ын даргын 2025 оны А/31 дүгээр тушаалаар Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Дорнод аймаг дахь гаалийн газар, Хөвсгөл аймаг Ханх дахь гаалийн хороонд тус тус хуваарилсан.<br>-Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн хүрээнд Гаалийн ерөнхий газар, Сүхбаатар, Алтанбулаг, Боршоо хилийн боомтуудад нийт 767,8 сая төгрөгийн хөрөнгийг Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны А/32 дугаар тушаалаар бүртгэлд тусгасан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Сангийн сайдын багцын IX.2.3.1 хуулийн дугаартай "Тоног төхөөрөмж" /Улсын хэмжээнд/ төслийн санхүүжилтээр Замын-Үүд, Гашуунсухайт хилийн боомтуудад суурилуулсан нийт 2,2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг ГЕГ-ын даргын 2025 оны А/33 дугаар тушаалаар бүртгэлд тусгасан.<br>-Эдийн засаг, хөгжлийн яам, Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем /cais/-ийг Хилийн удирдлагын нэгдсэн системд холбосон хөгжүүлэлтийн ажлыг ГЕГ-ын даргын 2025 оны А/104 дүгээр тушаалаар Гаалийн ерөнхий газар бүртгэлд тусгасан.<br>-Монгол Улсын Засгийн газрын 2025 оны үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай 89 дүгээр тогтоолын дагуу ГЕГ-ын даргын 2025 оны А/103 дугаар тушаалаар Сайншанд дахь гаалийн газрын балансад бүртгэлтэй нийт 3,9 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгө, газар эзэмших эрхийг Ханги дахь гаалийн газарт шилжүүлсэн.<br>-Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гашуунсухайт хилийн боомтын экспорт болон импортын хэсэгт суурилуулсан нийт 11,9 тэрбум төгрөгийн иж бүрдэл хяналтын систем / ачааны автомашин шалгах рентген тоног төхөөрөмж/-ийг ГЕГ-ын даргын 2025 оны А/183 дугаар тушаалаар Гашуунсухайт гаалийн газарт хуваарилсан.<br>-ГЕГ-ын даргын 2025 оны А/105, А/182 дугаар тушаалуудаар харьяа гаалийн газар, хороод хооронд нийт 400,0 сая төгрөгийн хөрөнгийг хуваарилсан.<br><br>**97.6** хувь"Бүрэн хангалттай" зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй байна. | |
| 3.14 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, шударга ёсыг эрхэмлэн ажиллах | Үйл ажиллагаа | ХАСХОМ, ХАСУМ мэдүүлсэн тухай баталгааны маягтын тоо, хувиар, Гаалийн | Гаалийн байгууллагын нийт 1,447 албан хаагчийн 2023 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд бүрэн мэдүүлж, тайланг нэгтгэн | 1.Хөрөнгө орлогоо мэдүүлбэл зохих төрийн тусгай албан хаагчийн ХАСХОМ, ХАСУМ мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хуулийн хугацаанд хүлээн авч, | 1.Нийтийн албан тушаалтны 2024 оны ХАСХОМ шинэчлэн мэдүүлэх 1524 албан хаагчдын нэрсийг гарган тулгалт хийж 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01-1/11 дугаартай албан бичгээр АТГ-т хүргүүлсэн.<br>-Гаалийн байгууллагын нийт 1524 албан хаагчийн 2024 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд бүрэн мэдүүлж, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллагын шударга байдлын үнэлгээг өсгөх зорилгоор зохион байгуулах ажлын тоо, хэрэгжилт гүйцэтгэлээр. | 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр 01/714 дугаартай албан бичгээр АТГ-т хүргүүлсэн. Мөн 3 албан хаагч их хэмжээний өөрчлөлт мэдүүлж, цахим санд баталгаажуулсан. Гаалийн байгууллагад томилогдохоор шинээр, шилжин болон дэвшин томилогдохоор нэр дэвшсэн 502 албан хаагчийн ХАСУМ-ийг шинээр нээж, бүртгэл хөтлөн, холбогдох материалын хамт АТГ-т хянуулахаар хүргүүлж, 496 ХАСУМ хянагдан ирснээс 3 зөрчилтэй, 17 зөрчил үүсэж болзошгүйг анхааруулсан, 1 мэдүүлгийг буцаасан бол 4 албан хаагчийг албан тушаалд томилохоос татгалзсан байна. | 100 хувь баталгаажуулсан байна. | тайланг нэгтгэн 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01-1/817 дугаартай албан бичгээр АТГ-т хүргүүлсэн.<br>-Гаалийн байгууллагад шинээр болон шилжин, дэвшин томилогдохоор нэр дэвшсэн 123 албан хаагчийн ХАСУМ-ийг шинээр нээж, бүртгэл хөтлөн холбогдох материалын хамт 23 удаагийн албан бичгээр АТГ-т хүргүүлсэн.<br>-2025 онд ХАСУМ хянуулсан 113 албан хаагчийн хариуг meduuleg.iaac.mn цахим санд шивж, албан тушаал шилжсэн 28 албан хаагчийн мэдүүлгийн шилжилт хөдөлгөөнийг хийсэн.<br>-Шинэчлэн мэдүүлснээс хойш Гаалийн ерөнхий газарт албан тушаалд томилогдсон 7, их хэмжээний өөрчлөлт мэдүүлсэн 5, нийт 12 албан хаагчдын ХАСХОМ-ийг гаргуулан авч, бүртгэл хөтлөн баталгаажуулсан.<br>2.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:<br>-Гаалийн байгууллагын хэмжээнд АТГ-аас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн 16, ГЕГ-ын Олон нийттэй харилцах албанаас боловсруулж, бэлтгэсэн 21, АТГ-ын цахим хуудаснаас харьяа гаалийн газар, хороодын цахим хуудсанд шэйрлэсэн 23 мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, видео контентуудыг “Монголын гааль” фэйсбүүк пэйж хуудас, “Монголын гааль” твитер хуудас, gov.mn вэб сайт, ГЕГ-ын 1 дүгээр давхарт байрлах электрон самбар, “Гаалийн албан хаагчдын мэдээлэл солилцох албан ёсны групп”-д тогтмол шинэчлэн байршуулж, нийт 60 мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, видео контентуудыг олон нийтэд түгээн ажилласан. Мөн 2 подкаст, 1 видео контент,1 анимейшн хийж, олон нийтэд түгээсэн.<br>-Тайлант хугацаанд төлөвлөгөөний дагуу нийт 12 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулж, 5126 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг хамруулан ажиллаж, өдөрлөг арга хэмжээнд оролцсон нийт 683 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөллөөс гаалийн байгууллагын үйл ажиллагаа дахь авлигын эрсдэл, хэлбэр, шалтгаан нөхцөлийг тодорхойлох зорилгоор судалгаа авч, нийт 7 төрлийн гарын авлагыг түгээн ажилласан. | |
| | | | | Гаалийн байгууллагын албан хаагч нарт болон гаалийн | 2.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүртгэгдсэн мэргэжилтэн нарт АТГ-ын “Авлигын гэмт хэрэг, шалтгаан, хор хөнөөл” сэдвээр нийт 4 удаагийн 8 цагийн, “Гаалийн улсын байцаагчийн ёс зүй ба авлигаас урьдчилан сэргийлэх нь” сэдвээр 40 цагийн буюу нийт 48 цагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 987 суралцагч /АТГ -ын сургалтад -207/ хамрагдсан. | сурталчилгааны ажлыг зохион байгуулна. | -АТГ-ын УССГХ-тэй хамтран “Төрийн албан хаагчийн ёс зүй, авлига ашиг сонирхлын<br>зөрчлөөс ангид байх, авлигын гэмт хэрэг” сэдэвт 10 удаагийн 22 цагийн сургалтыг тус тус зохион байгуулж, 580 албан хаагчдыг хамруулсан. Мөн 19 харьяа гаалийн газар, хороод тухай бүр нь сургалтуудыг зохион байгуулан ажилласан байна.<br>3.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан Гаалийн байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны тайланг 2025.01.31-ний өдрийн 01/538 албан бичгээр АТГ-ын АТҮХ-ийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар М.Даваатогтоход, 2025.01.31-ний өдрийн 01/539 албан бичгээр ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга, Б.Солонгоод тус тус хүргүүлсэн. Мөн АТГ-ын khutulbur.iaac.mn программд биелэлтийг хугацаанд нь оруулсан. АТГ-ын АТҮХ-ийн хэрэгжилтийн үнэлгээгээр ГЕГ нь ЗГ-ын 34 агентлагаас 3-р байрт орсон байна.<br>“Гаалийн байгууллагын авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-г ГЕГ-ын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэлийг холбогдох нэгжүүдэд хүргүүлж ажилласан. Эхний хагас жилийн явцын тайланг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр khutulbur.iaac,mn программд оруулсан.<br>4.“Гаалийн байгууллагын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулж, АТГ-аар хянуулан 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр ГЕГ-ын даргаар батлуулсан.<br>“Гаалийн байгууллагын Шударга байдлын үнэлгээг 2025 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр ГЕГ-ын даргаар батлуулсан.<br>-“Гаалийн байгууллагын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” болон “Гаалийн байгууллагын Шударга байдлын үнэлгээг 2025 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодод хүргүүлж ажилласан. | |
| | | | | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор тусгайлсан төлөвлөгөө боловсруулж батлуулан, хэрэгжилтийн биелэлтийг сар бүр АТГ-т хүргүүлсэн. | 3.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангасан байна. | | |
| | | | | Гаалийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 2024 оны | 4.Гаалийн байгууллагын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эхний хагас жил 100% үнэлэгдсэн. | хэрэгжилтийг хангaн ажилласан байна. | Тайлант хугацаанд дээрх 2 төлөвлөгөөний хэрэгжилтийг хангaн ажиллаж, тайланг хүргүүлсэн. Үүнд:<br>1.“Гаалийн байгууллагын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний биелэлтийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/2614 дугаар албан бичгээр АТГ-ын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваад, 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/2615 дугаар албан бичгээр СЯ-ны ТЗУГ-ын дарга Ч.Тавинжилд тус тус хүргүүлэв.<br>2.“Гаалийн байгууллагын Шударга байдлын үнэлгээг 2025 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/2614 дугаар албан бичгээр АТГ-ын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваад, 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/2615 дугаар албан бичгээр СЯ-ны ТЗУГ-ын дарга Ч.Тавинжилд тус тус хүргүүлэв.<br><br>**100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 3.15 | Төрийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах ажлыг эхлүүлэх. | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | Төрийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2-т “Албан хаагчийн дүрэмт хувцасны загварыг эдэлгээний хугацаа, хэрэглэх журмын хамт Ерөнхийлөгч, Засгийн газар тус тус тогтооно.” гэж заасан.<br>Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцасны загварыг эрх бүхий албан тушаалтнаар батлуулаагүй байна. | Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийн эх загварыг зураг нь хэлбэрээр гаргах. | III улиралд | Хугацаа болоогүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.16 | Албан хаагчийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.4, 28.1.5 дахь заалтын дагуу ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, хэмжилт хийлгэх шаардлагатай саналыг хүлээн авч, нэгтгэн, үнэлгээ, дүн шинжилгээ хийж, удирдлагад танилцуулсан. | 1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 31.1-д заасан шаардлагыг хангаж, Үндэсний итгэмжлэлийн төвөөс ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийхээр итгэмжлэгдсэн техникийн хяналтын байгууллагуудыг судалж, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх үнийн саналыг авсан байна.<br>2.Албан хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, албан хаагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр зарим ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж тайлагнасан байна. | III улиралд | Хугацаа болоогүй |
| 3.17 | МУ-ын ЕС-ын 2023 оны 191 дүгээр захирамжийн дагуу ГЕГ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хэм хэмжээ тогтоосон эрхийн актад хяналт, | Үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | ГЕГ нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэм хэмжээ тогтоосон, нийтээр дагаж мөрдөгдөх нийт 36 эрхийн акт батлуулах эрхтэй бөгөөд үүнээс 2024 онд 2 эрхийн актыг шинэчлэн | Нийт 5 эрхийн актыг шинэчлэн найруулж, нэмэлт, өөрчлөлт оруулан, ХЗДХЯ-нд бүртгүүлж, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна. | Гаалийн харилцааг зохицуулж байгаа нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актад Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.<br>Үнэлгээг хийхдээ Захиргааны ерөнхий хууль, “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний тухай” Засгийн газрын хуралдааны 2024 оны 39 дүгээр тэмдэглэл, “Аргачлал батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээ үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт хийх болон шинэчлэн боловсруулж батлан ХЗДХЯ-нд бүртгүүлж, олон нийтэд сурталчлах | | | найруулж, 2 эрхийн актад нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулсан. | | хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах аргачлал”-ыг үндэслэсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд 2008 оноос хойш Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сан”-д бүртгэлтэй нийт 36 захиргааны хэм хэмжээний актыг хамруулж, дараах үндэслэлээр 3 хэм хэмжээний актыг хүчингүй болгож, улсын нэгдсэн бүртгэлээс хасуулсан. Үүнд:<br>1.“Журам батлах тухай” 2008 оны 660 дугаар тушаал (Хураагдсан бараа, тээврийн хэрэгслийг борлуулах журам)<br>Тушаал батлахад үндэслэсэн "Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгах ажлыг зохицуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1995 оны 131 дүгээр тогтоол “Журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоол (Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам)-оор хүчингүй болсон.<br>2.“Журам батлах тухай” 2008 оны 735 дугаар тушаал (Гаалийн хууль тогтоомжтой холбогдсон асуудлаар иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх журам)<br>Гаалийн хууль тогтоомжтой холбогдсон асуудлаар зөвлөгөө өгөх дотоод үндсэн чиг үүрэгт заасан үйл ажиллагааг нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээ болгож тогтоон, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн байсан.<br>3.“Заавар батлах тухай” 2016 оны А/62 дугаар тушаал (Бүрэн буюу бүрэн бус суудлын автомашин, суудлын автомашины кузовыг тодорхойлон ангилах заавар)<br>Гаалийн тухай хуулиар гаалийн удирдах төв байгууллагын дарга батлах тусгайлсан эрх олгоогүй байхад нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг баталж, эрх зүйн зөрчил үүсгэсэн.<br>Мөн “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ыг “Журам батлах тухай” Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны А/19 дүгээр тушаалаар шинэчлэн баталж, хянуулж бүртгүүлэхээр 2025 оны 02/365 албан бичгээр хүргүүлснийг нийтээр заавал дагаж мөрдөх шинжгүй тул гаалийн байгууллага | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дотооддоо, түүгээрээ мөрдөх чиглэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Шийдвэр буцаан хүргүүлэх, улсын нэгдсэн бүртгэлд хөдөлгөөн хийсэн тухай” 2025 оны 1/646 албан бичгээр ирүүлж, улсын нэгдсэн бүртгэлээс хассан тухай мэдэгдсэн.<br>Дээрх хүчингүй болсон 3 болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон акт бус гэж үзсэн 1, нийт 4 эрхийн акт “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сан”-аас хасагдаж, 32 нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт хэрэгжиж байгаа болно.<br><br>**100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 4 | Соён гэгээрүүлэх | | | | | | |
| 4.1 | Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, төлөвлөгөөг гарган ажиллах | Үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | ГЕГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/715 дугаар тушаалын хавсралтаар "Гаалийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг" батлагдсан. | Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргаж батлуулсан байна.<br><br>Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана. | "Гаалийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийг Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/715 дугаар тушаалын хавсралтаар баталсан. Уг Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх 15 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Гаалийн ерөнхий газрын даргаар батлуулж, нийт албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан ажлын дагуу:<br>1.Гаалийн байгууллагын хөдөлмөрийн харилцаатай холбоотой хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн актуудад нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгийг Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны А/108 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн гишүүд 11 журмыг шинэчлэн боловсруулж нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.<br>2.Гаалийн байгууллагын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг нэг удаа зохион байгуулж, шалгалтад тэнцсэн 44 иргэнийг чиглүүлэх сургалтад хамруулж, харьяа гаалийн газар, хороодод томилсон.<br>3.Гаалийн байгууллагын батлагдсан бүтэц, орон тооноос илүү орон тоон дээр ажиллаж байгаа алба хаагчдын судалгааг гаргаж, "Чингис Хаан" Олон Улсын нисэх буудал дахь гаалийн газрын 6 албан хаагч, Гашуунсухайт дахь гаалийн газрын 2 албан хаагчдыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тухайн газруудын сул орон тоон дээр шилжүүлэн томилсон.<br>4.Өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүссэн эмэгтэй 108, эрэгтэй 45 нийт 153 албан хаагчдын судалгааг нэгтгэж гаргасан. Эхний хагас жилийн байдлаар байдлаар 5 албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгосон.<br>5.“Харьяа гаалийн газар, хороодын дүрэм”-ийн шинэчилсэн найруулгын төсөл, “Гаалийн байгууллагын сургалтын журам”-ын төсөл, “Гаалийн улсын байцаагчийг шилжүүлэн ажиллуулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулсан төслийг боловсруулсан.<br>6.Харьяа гаалийн газар, хороодын орон тоог шинэчлэх саналыг нэгтгэн боловсруулж, 2026 оны төсвийн төсөлд саналаа Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлж ажилласан.<br>7.Харьяа гаалийн газар, хороодын 1300 алба хаагчдын хувийн хэргийн материалыг татан авч, хувийн хэргийн баяжилтыг хийсэн.<br><br>**100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 4.2 | "Гаалийн байгууллагын албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхлүүлэх | Үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Гаалийн байгууллагын алба хаагчийн сургалт, хөгжил, гүйцэтгэлийг сайжруулах, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, амь насыг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх, ажиллах таатай орчноор хангах зорилгоор хүний нөөцийн хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрийг | Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргаж батлуулсан байна.<br><br>Хөтөлбөрийн дагуу төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ. | Гаалийн ерөнхий газрын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Гаалийн ерөнхий газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Хөтөлбөрийн дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:<br>-Нийт 602 удаагийн сургалтад давхардсан тоогоор 21,109 албан хаагчийг хамруулж, мэдлэг, ур чадварын хөгжүүлсэн.<br>-Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн Б/287 дугаар тушаалаар Эрэлч нохойн сургалтын төвийн төрийн үйлчилгээний албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг сар бүр албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгохоор шийдвэрлүүлсэн.<br>-Гаалийн тухай хуулийн 280 дугаар зүйлийн 280.7 дэх хэсэгт Улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид таван жил тутамд 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | боловсруулж, ГЕГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/717 дугаар тушаалаар батлуулсан. | | тухайн байгууллагаас олгох шийдвэр гарсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 5 удаагийн тушаалаар нийт 27 албан хаагчдад 516,444,064.12 тэрбум төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон.<br>-Төрийн дээд одон медалиар шагнуулахаар нэр дэвшүүлсэн нийт 48 албан хаагчийн холбогдох материалыг 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 01/2078 албан бичгээр Сангийн яамд хүргүүлсэн.<br>-Онцгой гавьяа байгуулсан 2 албан хаагчийг “Гаалийн албаны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр шагнаж урамшуулсан.<br>-Тусгай шалгалтад тэнцсэн нийт 44 иргэдийг Төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт хамруулан, өөрийн хүсэлтээр татгалзсан буюу эрүүл мэндийн үзлэгт тэнцээгүй 2 иргэнийг томилохоос татгалзаж бусад иргэдийг холбогдох журмын дагуу тухайн албан тушаалд нь томилон шийдвэрлэсэн.<br>-Тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд нийт 52,036 ширхэг мод, суулгацыг тарьж, арчлах ажиллагааг зохион байгуулсан.<br>-Гаалийн цом-2025 арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 28-аас 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд 6 төрөл тэмцээнийг зохион байгуулан нийт 470 албан хаагч тэмцээнд оролцсон.<br>-Албан хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих зорилгоор Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэнтэй хамтран Гаалийн байгууллагын албан хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг тодорхойлох зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 06 дугаар сарын 17-ны өдрүүдэд 7 түвшинд ангилсан судалгаанд хамруулах ажлыг зохион байгуулсан. Хөтөлбөрийн дагуу төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн биелэлтэд Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраар хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэсэн.<br><br>**100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 4.3 | Гаалийн байгууллагын албан хаагчдын хувийн | Үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2024 онд Захиргаа дотоод ажлын систем СЕРП-д нийт 1456 төрийн | Хувийн хэргийн хадгалалт, хамгаалалтыг дээшлүүлэх чиглэлээр | Хүний нөөцийн хэлтэст хадгалагдаж байгаа хувийн хэрэгт хийсэн тооллого болон архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг угтсан бэлтгэл ажлын төлөвлөөг 12 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусган | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэргийн хадгалалт, хамгаалалтыг журамд нийцүүлэн ажиллах | | | тусгай албан хаагчаас 1380 албан хаагчийн цахим анкетын баталгаажуулалт хийсэн. Төрийн албаны зөвлөлийн ХНУМТС-ийн санд гаалийн байгууллагын албан хаагчдын цалин, нэмэгдэл, шилжилт хөдөлгөөн болон бусад мэдээллийг оруулсан. ГЕГ-ын даргын "Гаалийн ерөнхий газар болон дэргэдэх байгууллагуудын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" 2024 оны 02 дугаар сарын А/123 дугаар тушаалын дагуу газар, хэлтэс, төвийн нэршил өөрчлөгдсөн болон шинээр байгуулагдсаны дагуу бүтцийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг нэмсэн. | төлөвлөгөө гаргаж ажиллана.<br><br>Хувийн хэргийн баяжилтыг хийнэ. | боловсруулж 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Захиргааны удирдлагын газрын даргаар батлуулсан.<br><br>Батлагдсан төлөвлөгөөний дагуу харьяа 19 гаалийн газар, хороодын нийт 1121 төрийн жинхэнэ алба хаагчдын 72,490 хуудас материалыг хянаж, хувийн хэрэгт товьёг үүсгэж, гаалийн байгууллагын Захиргаа, дотоод ажлын системд гаалийн байгууллагын нийт 1456 төрийн тусгай албан хаагчдын цахим анкетын баяжилт болон баталгаажуулалтыг хийсэн.<br><br>**100** хувь "Бүрэн хангалттай" зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 4.4 | Жендерийн дэд салбарын зөвлөлийн үйл | Үйл ажиллаг аа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Гаалийн байгууллагын Жендерийн дэд | Жендерийн дэд салбар зөвлөлийн 2025 оны | Жендэрийн дэд салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг холбогдох хууль, дүрэм журам, Жендэрийн үндэсний хороо, Сангийн яамны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг эрчимжүүлэх | | | салбар зөвлөлийг ГЕГ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/537 дугаар тушаалаар байгуулсан. | төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. Төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, тайланг Сангийн яаманд хүргүүлнэ. | Жендэрийн салбар зөвлөлийн 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж Гаалийн байгууллагын 2025 оны төлөвлөгөөг 6 чиглэл, 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Гаалийн ерөнхий газрын дэд даргаар батлуулсан.<br>-Сангийн яамны жендэрийн салбар зөвлөлөөс ирүүлсэн "Ажлын байрны жендэрийн мэдрэмжийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн маягт"-ын дагуу үнэлгээг 6 бүлгийн хүрээнд 37 үзүүлэлтийг чанарын болон тоон утгаар илэрхийлэн 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Сангийн яамны Жендерийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн.<br>-Жендэрийн үндэсний хорооноос "Харилцан хүндэлье" аяныг зарласантай холбогдуулан албан хаагчдыг "Та бүхэн бие биетэйгээ өглөө бүр мэндэлж, амжилт хүсэн талархаж, сайн сайхныг хүсэн ерөөж харилцан хүндэтгэлтэй хандан эерэг байхыг уриалж байна" гэсэн зурагт хуудас болон газар, хороодын аянд нэгдсэн тухай видео бичлэгийг "Бид гаалийнхан", "Гаалийн албан хаагчдын мэдээлэл солилцох албан ёсны групп"-д тус тус байршуулан сурталчилж, мэдээ тайланг Сангийн яамд хүргүүлэхээр ажиллаж байна.<br>-2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны техникийн зөвлөх Т.Амгаланг урьж "Жендэр ба бодлого, төлөвлөлт" сэдвээр сургалт зохион байгуулсан ба танхимаар ГЕГ-ын 65 албан хаагч, цахимаар харьяа гаалийн газар, хороодын 333 албан хаагч хамрагдсан. Мөн харьяа 8-н гаалийн газар, хороод Жендэрийн тухай ойлголттой холбоотой сургалтуудыг зохион байгуулж нийт 252 албан хаагчийг хамрагдсан байна.<br><br>1. **100** хувь "Бүрэн хангалттай" зорилтот түвшиндээ хүрсэн.<br>2. 2-р арга хэмжээ- Хугацаа болоогүй.<br><br>Дундаж **100** хувь. | |
| 4.5 | ГЕГ-ын ЗББНДБ болон харьяа ГГХ-ын сургалтын саналыг | Үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2024 онд ГЕГ-ын хэмжээнд нийт 915 сургалт зохион байгуулан, давхардсан | ГЕГ-ын 2025 оны Сургалтын төлөвлөгөөг боловсруулан, батлуулж хэрэгжилтэд | Гаалийн байгууллагаас 2025 оны сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлон судалгаа авч нэгтгэн, "Гаалийн ерөнхий газрын 2025 оны сургалтын төлөвлөгөө"-г боловсруулж, ГЕГ-ын даргаар батлуулсан. Гаалийн байгууллагын хэмжээнд 2025 оны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үндэслэн, 2025 оны Сургалтын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтэд хяналт тавин, тайлагнах | | | тоогоор нийт 36189 гаалийн албан хаагч, гадаад худалдаанд оролцогч, хувь хүн, бусад төрийн байгууллагын алба хаагчид хамрагдсан байна. | хяналт тавин тайлагнасан байна. | эхний хагас жилд нийт 603 сургалт зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 21459 албан хаагч хамрагдсан байгаа нь 2024 оны мөн үетэй харьцуулахад сургалтын тоо 230-аар буюу 61,6 хувиар, хамрагдсан албан хаагчийн тоо 9521-ээр буюу 79,7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.<br><br>**100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 4.6 | Мэргэшсэн чадварлаг хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа | Үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2024 онд гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтыг 4 удаа зохион байгуулан нийт 181 суралцагч хамрагдсан<br>ГУБ нарын мэргэшүүлэх бүсчилсэн сургалт 3 зохион байгуулсан /134 ГУБ хамрагдсан/<br>Дэлхийн гаалийн байгууллагын дунд түвшний удирдлагын хөгжил сургалт-1 удаа /19 суралцагч/ | Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтыг тухай бүр зохион байгуулна.<br>ГУБ-ийн давтан сургалтыг танхимын болон бүсчилсэн хэлбэрээр ажлын байран дээр сургалт зохион байгуулна.<br>ДГБ-ын "Дунд түвшний удирдлагын хөгжил" сургалт зохион байгуулна. | Гаалийн байгууллагаас Гаалийн ерөнхий газрын даргын баталсан 2025 оны сургалтын төлөвлөгөөний дагуу дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:<br>-Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтыг 2 удаа /74 суралцагч/,<br>-Гаалийн улсын байцаагчийг мэргэшүүлэх сургалтыг 4 удаа /125 гаалийн улсын байцаагч/,<br>-Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалтыг 3 удаа /179 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн/,<br>-Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалтыг 3 удаа /174 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн/,<br>-VR мэргэшүүлэх сургалтыг 1 удаа /171 гаалийн улсын байцаагч/,<br>-Цахимаар бараагаа мэдүүлэх гадаад худалдаа эрхлэгч нарт зориулсан сургалтыг 1 удаа /танхимаар 30, цахимаар 80 суралцагч/ буюу нийт 14 сургалтыг тус тус зохион байгуулсан ба сургалтад нийт 753 ажилтан, албан хаагч хамрагдаж, 99.2 хувийн амжилттай дүгнэгдсэн болно. Сургалт бүрийн өмнө сургалтын хөтөлбөр, хичээлийн хуваарийг боловсруулан батлуулж, багш нар нийт 1575 цагийн хичээл заасан.<br>ДГБ-ын "Дунд түвшний удирдлагын хөгжил" гаалийн улсын байцаагчийг мэргэшүүлэх 24 цагийн сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд барааны ангилал, гаалийн тариф, татвар, гаалийн үнэ, үнэлгээний чиглэлээр танхимаар зохион байгуулсан. Уг сургалтад харьяа гаалийн газар, хороодын нийт 25 гаалийн улсын байцаагч хамрагдсан.<br><br>**100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.7 | Бусад байгууллагатай хамтран ажиллах, захиалгат сургалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Гаалийн зуучлагч байгууллагын захиалгат сургалтад 2024 онд анхан шатны эрх олгох 2 удаа нийт 102 хүн, эрх сунгах давтан сургалт 3 удаа нийт 146 хүн тус тус хамрагдсан. | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрх олгох анхан шатны сургалт, | -2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 185 иргэнийг анхан шатны сургалтад хамруулж, 105 иргэнд гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрх олгосон. Давтан сургалтад 179 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн хамрагдаж, 176 нь эрхээ сунгуулсан буюу 98.3%-ийн гүйцэтгэлтэй байна.<br>-МУИС болон Гаалийн ерөнхий газрын хамтын ажиллагааны санамж бичгийг үндэслэн “Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалт”-ыг хамтран зохион байгуулсан. Сургалт нь “Гаалийн зуучлагч байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ыг 2025 онд шинэчлэн баталсантай холбогдуулан зохион байгуулж байгаа онцлог юм.<br>-МУИС-ийн Бизнесийн сургуулийн Маркетинг, худалдааны тэнхимийн доктор, профессорууд Сургалтын хөтөлбөрийн дагуу хичээл зааснаас гадна ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудын чиглэл хариуцсан албан хаагчид, Сургалтын төвийн багш нар хамтран оролцож, гаалийн байгууллагад хэрэгжүүлж байгаа өнөөгийн бодлого, анхаарах асуудлыг сургалтын агуулгад багтаасан.<br><br>**100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | 100 |
| 4.8 | Зураасан код, түүнтэй адилгах кодыг гаалийн мэдүүлэгт нөхөн бичихтэй холбоотой сургалт, сурталчилгаа зохион байгуулсан байна. | Үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Гаалийн мэдүүлгийн II хэсэгт бар код нөхөн бичих талбар нэмж оруулсан. | Зураасан код, түүнтэй адилгах кодыг гаалийн мэдүүлэгт нөхөн бичихтэй холбоотой сургалтыг Дэлхийн Стандарт Нэг Монгол Нийгэмлэг ТББ-тай хамтран зохион байгуулна. | Гаалийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т Энэ хуулийн 13.1-д заасан мэдээллийг Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн ангилал болон Татварын ерөнхий хуулийн 33.4-т заасан журмын дагуу олгосон зураасан болон түүнтэй адилтгах код, нэр төрлөөр гаргахаар зохицуулсан. Энэ зохицуулалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Барааны зураасан код болон түүнтэй адилтгах кодыг олон улсын стандартын дагуу давхардалгүй үүсгэхтэй холбоотой асуудлаар 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 14:00 цагт “Дэлхийн Стандарт Нэг Монгол Нийгэмлэг” ТББ-ийн захирал Ш.Цэвэлсайхантай уулзалт зохион байгуулж санал солилцсон. Уулзалтын үр дүнд “Дэлхийн Стандарт Нэг Монгол Нийгэмлэг” ТББ-ын захирал Ш.Цэвэлсайхантай хамтран барааны зураасан код болон түүнтэй адилтгах кодыг олон улсын стандартын дагуу давхардалгүй үүсгэхтэй холбоотой асуудлаар: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Бүрдүүлэлтийн цахим төвийн 36 албан хаагчид 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр ;<br>-Улаанбаатар хот дахь гаалийн газрын 130 албан хаагчид 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр;<br>-Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын 101 албан хаагчид 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр;<br>-Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 48 албан хаагчид 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр тус тус танхимын сургалт зохион байгуулж, нийт 315 албан хаагчийг хамруулсан.<br><br>**100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| 4.9 | Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чиглэлээр сургалт зохион байгуулж, ГУАБ, ГУБ нарыг мэргэшүүлэх | Үйл ажиллагаа | Зохион байгуулсан сургалтын тоо | 2024 онд гаалийн газар, хороодын ГУАБ, ГУБ нарт зориулсан сургалт зохион байгуулагдаагүй. | Улаанбаатар хотод байрлах 2 гаалийн газрын ГУАБ, ГУБ нарт сургалт зохион байгуулсан байна. | III улиралд | Хугацаа болоогүй |
| 4.10 | Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ | Үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах санхүүгийн хэрэгсэл, хар тамхи улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 9 удаагийн сургалт явуулж, харьяа гаалийн газар хороодод 6 удаа чиглэл хүргүүлсэн. | 1.Хар тамхины хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр гаалийн газар хороодод эрх бүхий байгууллагуудтай хамтран 2 удаагийн сургалт зохион байгуулсан байна.<br>2.Холбогдох мэдээллээр харьяа гаалийн газар хороодод чиглэл зөвлөмж хүргүүлсэн байна. | Хар тамхины хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр гаалийн газар, хороодод эрх бүхий байгууллагуудтай хамтран 2 удаагийн сургалт зохион байгуулсан байна:<br>-Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, химийн болон угтвар, тэсрэх бодис анхан шатанд таньж тодорхойлогч Target-ID, TruNarc төхөөрөмжийг хэрхэн оновчтой зөв ашиглах, арчлах тухай цуврал видео сургалтын материалыг бэлтгэж DVD-нд хуулбарлан 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр 198 тоот дотоод зурвасаар ГЕГ-ын Сургалтын төвд, мөн өдрийн 01-2/811 тоот албан бичгээр харьяа гаалийн 19 газар, хороодод хүргүүлсэн. Мөн Гаалийн албан хаагчдын мэдээлэл солилцох албан ёсны фэйсбүүк группт 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Видео хичээл № 1 (Target-ID)-ийг нийтэлсэн бөгөөд 1900 үзэлттэй, 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Видео хичээл № 2 (TruNarc)-ыг нийтэлсэн бөгөөд 721 үзэлттэй байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Гаалийн газар, хороодын төрийн тусгай албанд шинээ томилогдох болзол шалгуурыг ханган гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад хамрагдаж буй 44 иргэнд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан гэмт хэргийн нөхцөл байдал, арга хэлбэр буюу түүнтэй тэмцэх нь”, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг рентген хяналтаар таньж илрүүлэх аргачлал” сэдэвт сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр орсон.<br>-Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Үндэсний зөвлөлийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 9-ний өдрийн А/04 тушаалын хавсралтаар батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 147 дахь ажил (Гаалийн ерөнхий газрын орон тооны бүтцэд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэл хариуцсан алба хаагч 5-аас багагүй, хилийн боомтуудад 1-ээс багагүй байхаар зохицуулалт хийж, мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, гаалийн хяналтын техник, тоног төхөөрөмжийг сайжруулах)-ын хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэл хариуцсан алба хаагчдыг сургах, мэдээллээр хангах зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 16-ын өдрөөс 02 дугаар сарын 20-ны өдрийн хугацаанд, ГЕГ-ын зарим бүтцийн нэгжүүдийн 30 алба хаагч нарт 6 удаагийн, 6 цагийн цуврал сургалтыг танхимын хэлбэрээр ГЕГ-ын VR цахим сургалтын төвд зохион байгуулсан. Цуврал 6 сургалтын материалыг видео хичээл болгон бэлтгэж 2025 оны I-IV улирлын хугацаанд гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар, хороодод хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж эхний 3 хичээлийг видео хэлбэрт шилжүүлэн гаалийн байгууллагын алба хаагчдад хүргэсэн.<br>Холбогдох мэдээллээр харьяа гаалийн газар, хороодод чиглэл зөвлөмж хүргүүлсэн байна:<br>-Гаалийн ерөнхий газрын Зөрчилтэй тэмцэх газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 19-ны өдөр хамтран баталсан “Улс хоорондын шуудан илгээмж, карго үйлчилгээ үзүүлэгч иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хийх уулзалт” зохион байгуулах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | удирдамжийн дагуу Улс хоорондын шуудан илгээмж, карго үйлчилгээ үзүүлэгч иргэн, аж ахуй нэгжийн төлөөллүүдтэй 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр "Улс хоорондын шуудан илгээмж ашиглан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх төр, хувийн хэвшлийн түншлэл" сэдвээр уулзалт зохион байгуулсан бөгөөд нийт 50 төлөөлөл уулзалтад оролцсон.<br>-Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын нийт алба хаагчдад 2025 оны 05 дугаар сарын 08-09-ны өдрүүдэд, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмж дэх гаалийн газрын нийт алба хаагчдад 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр, Замын-Үүд дэх гаалийн газрын нийт алба хаагчдад 2025 оны 06 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн талаарх бүс нутгийн болон дотоодын нөхцөл байдал, анхаарах асуудал" сэдвийн хүрээнд танилцуулга, мэдээлэл хүргэсэн бөгөөд нийт 650 алба хаагч хамрагдсан.<br>-ГЕГ-ын даргаас өгсөн чиглэлийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр ЗТГ-ын дарга Ж.Эрдэнэболд нь 2025 оны эхний 5 сарын байдлаар хэрэгжүүлсэн ажил арга хэмжээ, дүн шинжилгээнд үндэслэн хэрэгжүүлсэн шалгалт, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн олон улсын болон бүс нутаг, дотоодын нөхцөл байдал, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн чиглэлийн талаарх танилцуулга мэдээллийг ГЕГ-ын удирдлага болон Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй гаалийн газар, хороодын удирдлагад хаалттай мэдээллийг хүргүүлсэн.<br>-Улаанбаатар хот дахь гаалийн газрын дарга, нийт албадын дарга, гаалийн улсын ахлах байцаагч нарт болон УБТЗ, Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо, Гаалийн хяналтын бүс эзэмшигч ААН, Гаалийн зуучлалын мэргэшсэн холбоодын удирдах алба тушаалтнуудад 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн өнөөгийн нөхцөл байдал, анхаарах асуудал" сэдвийн танилцуулга, мэдээлэл хүргэсэн бөгөөд нийт 60 албан тушаалтан хамрагдсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Чингис хаан олон улсын нисэх буудалд дахь гаалийн газрын хяналт тавьж буй Карго терминалын гаалийн хяналтын бүсэд ашиглаж буй гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмжийн ашиглалтыг нэмэгдүүлэх хяналттай байлгах зорилгоор тухай тоног төхөөрөмжийг гаалийн байгууллагын теле хяналтын нэгдсэн системд холбох ажлыг шийдвэрлэж хариуг 2025 оны 06 дугаар сарын 04-ний дотор ирүүлэхийг чиглэл болгосон. Тус чиглэлийн дагуу холболтын ажлыг хийж ашиглалтад оруулсан тухайн хариуг 01/396 албан бичгээр ирүүлсэн.<br>ДГБ-ын Ази, номхон далайн бүс нутгийн байгууллага болох Зөрчлийн мэдээлэл солилцох төв (WCO RILO/AP)-өөс ирүүлсэн бүс нутгийн хэмжээнд илрүүлсэн хориглосон, хязгаарласан барааг хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан үйлдэл, барааг гаалийн хяналтаас нуун далдлах арга хэлбэрийн талаарх 25 удаагийн Сэрэмжлүүлэг мэдээллийг тухай бүр орчуулж, CERP дотоод сүлжээнд байршуулсан.<br><br>**100** хувь “Бүрэн хангалттай” зорилтот түвшиндээ хүрсэн. | |
| Дундаж үнэлгээ: **90.8** хувь | | | | | | | |

“

---oOo---